



ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХӨГЖЛИЙН ТӨВ



World Health  
Organization

Western Pacific Region

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

# 2016

Энэхүү эмхэтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.  
Эрүүл мэндийн хөгжлийн төв

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж  
Улаанбаатар -210648  
Факс: 976-11-320633  
Утас: 70111485  
Э-шуудан: admin@hdc.mohs.mn  
www.chd.mohs.mn

Эрхэлсэн: Б.Нарантуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирал  
Хянасан: Х.Ганцэцэг, СМТА-ны дарга

|            |                 |                           |
|------------|-----------------|---------------------------|
| Эмхтгэсэн: | С.Даваажаргал   | СМТА-ны ахлах мэргэжилтэн |
|            | Х.Нарантуяа     | СМТА-ны мэргэжилтэн       |
|            | Б.Болдбаатар    | СМТА-ны мэргэжилтэн       |
|            | Б.Норолхоосүрэн | СМТА-ны мэргэжилтэн       |
|            | Д.Доржмягмар    | СМТА-ны мэргэжилтэн       |
|            | Х.Дэлгэрмаа     | СМТА-ны мэргэжилтэн       |
|            | Г.Цэцэнсанаа    | ЭЭХА-ны дарга             |
|            | З.Хулан         | ЭЭХА-ны мэргэжилтэн       |

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Уранчимэг, СМТА  
Д.Алтанцэцэг, СМТА

Хэвлэлийн дизайнер: П.Бат-Өлзий

## ГАРЧИГ

|                                                                                    |              |
|------------------------------------------------------------------------------------|--------------|
| <b>Өмнөх үг</b>                                                                    | <b>5</b>     |
| <b>Хүснэгтийн жагсаалт</b>                                                         | <b>6-7</b>   |
| <b>Зургийн жагсаалт</b>                                                            | <b>8-9</b>   |
| <b>Товчилсон үгийн жагсаалт</b>                                                    | <b>10</b>    |
| <b>Ном зүй</b>                                                                     | <b>11</b>    |
| <b>Хураангуй</b>                                                                   | <b>12</b>    |
| <b>БҮЛЭГ 1. Монгол улсын хүн ам</b>                                                | <b>13-20</b> |
| 1.1. Хүн ам                                                                        | 15-16        |
| 1.2. Хүн ам зүйн үзүүлэлт                                                          | 16-17        |
| 1.3. Хүн амын дундаж наслалт                                                       | 17-20        |
| <b>БҮЛЭГ 2. Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүд</b>                           | <b>21-27</b> |
| <b>БҮЛЭГ 3. Эх хүүхдийн эрүүл мэнд</b>                                             | <b>28-42</b> |
| 3.1. Эх, хүүхдийн эрүүл мэнд                                                       | 29           |
| 3.2. Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ         | 29-31        |
| 3.3. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ                              | 32-34        |
| 3.4. Төрсний дараах тусламж, үйлчилгээ                                             | 34-36        |
| 3.5. Эхийн эндэгдэл                                                                | 36-38        |
| 3.6. Хүүхдийн эрүүл мэнд                                                           | 38-41        |
| 3.7. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл                              | 41           |
| 3.8. Үр хөндөлт                                                                    | 42           |
| 3.9. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСАХ/                     | 42           |
| <b>БҮЛЭГ 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>                                        | <b>43-54</b> |
| 4.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ                                | 45-46        |
| 4.2. Сумын эрүүл мэндийн төвийн болон сум, сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ | 47-49        |
| 4.3. Нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ                | 49-50        |
| 4.4. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тусламж үйлчилгээ                         | 51-52        |
| 4.5. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн тусламж, үйлчилгээ                   | 52-53        |
| 4.6. Хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ                                           | 54           |
| <b>БҮЛЭГ 5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц</b>                                  | <b>55-59</b> |
| <b>БҮЛЭГ 6. Халдварт өвчин</b>                                                     | <b>60-70</b> |
| 6.1. Нийт халдварт өвчин                                                           | 61           |
| 6.2. Гэдэсний халдварт өвчин                                                       | 62-65        |
| 6.3. Амьсгалын замын халдварт өвчин                                                | 65-68        |
| 6.4. Бэлгийн замаар дамжих халдвар                                                 | 68-70        |
| 6.5. Халдварт өвчний шалтгаант нас баралт                                          | 70           |
| <b>БҮЛЭГ 7. Халдварт бус өвчин</b>                                                 | <b>71-82</b> |
| 7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан                                         | 72-73        |
| 7.2. Цусны даралт ихсэх өвчин                                                      | 74           |
| 7.3. Чихрийн шижин өвчин                                                           | 74           |
| 7.4. Хорт хавдрын өвчлөл                                                           | 75-76        |
| 7.5. Амбулаторт бүртгэгдсэн элэгний өвчлөл                                         | 76           |

|                                                                                                        |                |
|--------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| 7.6. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан                                                | 76-78          |
| 7.7. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн талаар                                                | 78-79          |
| 7.8. Мэс заслын үйл ажиллагаа                                                                          | 80-82          |
| <b>БҮЛЭГ 8. Хүн амын нас баралт</b>                                                                    | <b>83-89</b>   |
| 8.1. Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт                                              | 86             |
| 8.2. Хорт хавдрын шалтгаант нас баралт                                                                 | 86-87          |
| 8.3. Гэмтэл хордлого гадны шалтгаант нас баралт                                                        | 87-89          |
| <b>БҮЛЭГ 9. Монгол улсын эмзүйн салбарын үзүүлэлт</b>                                                  | <b>90-95</b>   |
| 9.1. Эмийн импорт                                                                                      | 91-92          |
| 9.2. Эмийн бүртгэл                                                                                     | 92-94          |
| 9.3. Эмийн үйлдвэрлэл                                                                                  | 95             |
| 9.4. Эмийн аюулгүй байдал                                                                              | 95             |
| 9.5. Эмийн зохистой хэрэглээ                                                                           | 95             |
| <b>БҮЛЭГ 10. Цусны албаны үйл ажиллагаа</b>                                                            | <b>96-99</b>   |
| <b>БҮЛЭГ 11. Эрүүл мэндийн эдийн засаг</b>                                                             | <b>100-114</b> |
| 11.1. Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэл                                                         | 101-106        |
| 11.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал                                                   | 106-114        |
| <b>БҮЛЭГ 12. Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүд, 2007-2016 он</b>                                         | <b>115-128</b> |
| <b>БҮЛЭГ 13. Үндэсний хөтөлбөрүүд</b>                                                                  | <b>129-137</b> |
| <b>БҮЛЭГ 14. ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд орох Монгол улсын үзүүлэлтүүд, 2016</b> | <b>138-143</b> |
| <b>БҮЛЭГ 15. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, /хүснэгтээр/</b>                                        | <b>144-193</b> |



## Өмнөх үг

Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ тайланд тулгуурлан 2016 оны эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу тооцон, дүгнэлт, үнэлгээ хийж эмхтгэн та бүхэнд толилуулж байна.

Энэхүү эмхэтгэл нь жил бүр эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалаар, хүн амын өвчлөлийн болон нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг бүс нутгаар гаргаж, үндэсний хэмжээнд хэрэгжиж буй нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцон харуулдаг.

2016 оны тус эмхтгэлд Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл болох Тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл мэндийн үзүүлэлтийг Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгагдсан эрүүл мэндийн 4 зорилтын хүрээнд мэдээллийг боловсруулж “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах” үндэсний хөтөлбөрийн үзүүлэлтүүдийг шинээр оруулан нийт 97 хүснэгт, 92 зураг, 50 газар зүйн байршлын дүрслэлээр илэрхийлэн Та бүхний хүртээл болгож байгаагаараа онцлог юм.


2016 оны байдлаар Монгол улсын хүн амын дундаж наслалт 69.57 байгаа ба эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.10, эрэгтэйчүүдийнх 65.58 байна. Олон улсын түвшинд 15 хүртэлх насны хүн амын эзлэх хувь 31 хувиас дээш байвал залуу хүн амтай улс орон гэж үздэг бол манай улсын хувьд энэ үзүүлэлт 30.0 хувь байна. 2016 оны нас хүйсийн суваргад 0-4 насныхан хамгийн өндөр байгаа нь сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин өндөр байсныг харуулж байгаа ба мөн 25-29 насныхан их байгаа нь хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонхны үе үргэлжилж байгааг энэхүү эмхтгэлээс харж болно.

Монгол улсад эмнэлгийн нэг оронд ногдох хүний тоо 134, нэг их эмчид ногдох хүний тоо 309 байгаа ба 10 000 хүн тутмын 2749 хүн давхардсан тоогоор хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг авч, жилд 1 иргэн 5.5 удаа амбулаторийн тусламж үйлчилгээ авсан байгаа нь жилээс жилд тусламж үйлчилгээний хүртээмж өсөж байгааг харуулж байна.

Энэхүү эмхтгэлийг хэвлүүлэн салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон мэдээлэл хэрэглэгчдийн хүртээл болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт гүн талархал илэрхийлье.

Эрүүл мэндийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон мэдээлэл хэрэглэгч нийт хүмүүст нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт бүрэн итгэлтэй байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|                |                                                                                                                                         |
|----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүснэгт 1.2.1. | Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар                                                                                              |
| Хүснэгт 1.3.1. | Хүн амын дундаж наслалт, эхний 10 байранд байгаа орнуудын жагсаалт                                                                      |
| Хүснэгт 1.3.2. | Хүн амын дундаж наслалт бүсээр, хүйсээр, 2016 он                                                                                        |
| Хүснэгт 2.1.   | Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар                                                                      |
| Хүснэгт 2.2.   | Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар                                        |
| Хүснэгт 2.3.   | Зүрх судасны тогтолцооны өвчин, Хорт хавдрын шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2007-2016 он                                         |
| Хүснэгт 2.4.   | Сүрьеэ, вирүст гепатитийн өвчлөлийн түвшин (10 000 хүн амд), сонгосон онуудаар                                                          |
| Хүснэгт 3.3.1. | Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр, 2016 он                                                                                       |
| Хүснэгт 3.3.2. | Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2016 он                                                                                  |
| Хүснэгт 3.3.3. | Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2016 он                                                                                          |
| Хүснэгт 3.5.1. | Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2016 он                                                                         |
| Хүснэгт 3.6.1. | Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2016 он                                                                                                  |
| Хүснэгт 3.6.2. | Нярай хүүхдийн өвчлөл, бодит тоогоор, 2016 он                                                                                           |
| Хүснэгт 3.6.3. | Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, хувиар /хот, хөдөө/, 2016 он                                                  |
| Хүснэгт 3.6.4. | Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн шалтгаан, насны бүлгээр, /тухайн насны 10 000 хүүхдэд/, 2016 он                                       |
| Хүснэгт 3.7.1. | Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, нас, хүйсээр, 2016 он                                                                   |
| Хүснэгт 3.7.2. | Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувиар /хот, хөдөө/ 2016 он                                                  |
| Хүснэгт 3.8.1. | Үр хөндөлт, байршлаар, 2016 он                                                                                                          |
| Хүснэгт 3.9.1. | ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо байршлаар, 2016 он                                                                              |
| Хүснэгт 4.1.   | Эрүүл мэндийн байгууллагуудын тоо, 2016 он                                                                                              |
| Хүснэгт 4.1.1. | Өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2014-2016 оны байдлаар                                   |
| Хүснэгт 4.2.1. | Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2016 он            |
| Хүснэгт 4.2.2. | Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлт, 2014, 2016 он |
| Хүснэгт 4.3.1. | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2014-2016 он                                     |
| Хүснэгт 4.4.1. | БООТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2014-2016 он                                                                 |
| Хүснэгт 4.4.2. | БООТ-ийн хүний нөөцийн зарим үзүүлэлт, 2016 он                                                                                          |
| Хүснэгт 4.4.3. | БООТ-ийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт, 2016 он                                                                                        |
| Хүснэгт 4.5.1. | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн, эмнэлгийн тусламж                                                                             |

|                  |                                                                                                                                                                        |
|------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                  | үйлчилгээний чанар болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд, сонгосон онуудаар                                                                                              |
| Хүснэгт 4.5.2.   | Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны зарим үр дүнгийн үзүүлэлтүүд, 2016 он                                                                         |
| Хүснэгт 4.6.1.   | Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2016 он                                                                                                       |
| Хүснэгт 4.6.2.   | Хувийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2016 он                                                                                                          |
| Хүснэгт 6.2.1.   | Гэдэсний халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2015-2016 он                                                                                                       |
| Хүснэгт 6.2.3.1. | Вирүст хепатит, 10 000 хүн амд, /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар 2015-2016 он/                                                                                |
| Хүснэгт 6.3.1.   | Амьсгалын замын халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2015-2016 он                                                                                                |
| Хүснэгт 6.3.1.1. | Сүрьеэ өвчин, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2015-2016 он/                                                                                  |
| Хүснэгт 6.4.1.   | Бэлгийн замаар дамжих халдвар, бодит тоо, 10 000 хүн амд, 2015-2016 он                                                                                                 |
| Хүснэгт 7.1.1.   | Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2016 он                                                                                                         |
| Хүснэгт 7.4.1.   | Зонхилох арван байрлалын хорт хавдар, хүйсээр, /TNM ангилалаар/, 2016 он                                                                                               |
| Хүснэгт 7.6.1.   | Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2016 он                                                                                            |
| Хүснэгт 7.6.2.   | Хэвтэн эмчлүүлэгчдийн зонхилон тохиолдох өвчлөл, хувиар, 2007-2016 он                                                                                                  |
| Хүснэгт 7.7.1.   | Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүний тоо, аймгаар, 2015-2016 он                                                                                                      |
| Хүснэгт 7.8.1.   | Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын хагалгааны тоо, 2016 он                                                                                              |
| Хүснэгт 7.8.2.   | Зонхилон хийгдсэн мэс засал, хагалгааны төрлөөр, 2016 он                                                                                                               |
| Хүснэгт 8.1.     | Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2016 он                                                                                                    |
| Хүснэгт 8.1.1.   | Шалтгаанаар тооцсон зүрх-судасны тогтолцооны өвчний нас баралтын түвшин, 10 000 хүн амд, насны бүлгээр, 2016 он                                                        |
| Хүснэгт 8.3.1.   | Дэлхийн хүн амын нас баралтын 2030 он дахь төлөв байдал, 2016 оны Монгол улсын нас баралтын үзүүлэлттэй харьцуулсан байдал                                             |
| Хүснэгт 9.4.1.   | Эмийн гаж нөлөөний болон мэдээлсэн эмнэлгийн тоо, 2012-2016 он                                                                                                         |
| Хүснэгт 11.2.1.  | Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид хэвтүүлэн эмчлэх болон өдрөөр эмчлэх тусламж үйлчилгээний зардал, /хамгийн өндөр зардал бүхий 10 оношийн бүлэг/, 2016 он |
| Хүснэгт 1.       | Эрүүл мэндийн сайдын багцын санхүүжилтийн үндсэн үзүүлэлт                                                                                                              |
| Хүснэгт 2.       | Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангилалаар, сая төгрөгөөр                                                                                                 |
| Хүснэгт 3.       | Эрүүл мэндийн сайдын багцын зардлын бүтэц, сая төгрөгөөр                                                                                                               |
| Хүснэгт 4.       | Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал, сая төгрөгөөр                                                                                                          |
| Хүснэгт 5.       | Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал, өртөг ойролцоо оношийн бүлгээр, 2016 он                                                                                        |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1.1.1. 2016 оны хот, хөдөөгийн хүн амын тоо, аймгаар
- Зураг 1.1.2. 2016 оны дундаж хүн амын тоо, аймгаар
- Зураг 1.1.3. Монгол улсад оршин суугаа хүн ам, хот, хөдөөгийн хүн амын эзлэх хувь
- Зураг 1.1.4. Хүн амын тоо, жилийн өсөлтийн хувь, сонгосон онуудаар
- Зураг 1.2.1. Төрөлт, амьд төрсөн нярайн тоо, сүүлийн 5 жилээр
- Зураг 1.2.2. Төрөлтийн нийлбэр коэффициент, сонгосон онуудаар
- Зураг 1.3.1. Нас, хүйсийн суварга, 2006, 2016 он
- Зураг 3.1.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, 2003-2016 он
- Зураг 3.2.1. Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2016 он
- Зураг 3.2.2. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2016 он
- Зураг 3.3.1. 1 000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар 2016 он
- Зураг 3.3.2. Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар 2016 он
- Зураг 3.3.3. Улаанбаатар хотод төрсөн орон нутгийн харъяат эхчүүд, бодит тоо, 2016 он
- Зураг 3.4.1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн хувь, эрүүл мэндийн байгууллагаар, 2016 он
- Зураг 3.4.2. Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь, аймгаар, 2016 он
- Зураг 3.4.3. Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар, 2016 он
- Зураг 3.4.4. Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, 2016 он
- Зураг 3.5.1. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2016 он
- Зураг 3.5.2. Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2016 он
- Зураг 3.6.1. Амьгүй төрөлтийн түвшин, 1 000 нийт төрөлтөд, аймгаар, 2016 он
- Зураг 3.6.2. Нярай хүүхдийн өвчлөл, амьд төрсөн хүүхдэд эзлэх хувиар, аймгаар, 2016 он
- Зураг 4.1.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгийн тоо, /сүүлийн 5 жилээр/
- Зураг 4.2.1. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн дундаж тоо, 2016 он
- Зураг 4.2.2. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2014-2016 он
- Зураг 4.3.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2016 он
- Зураг 4.5.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2016 он
- Зураг 5.1.1. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид, сүүлийн 5 жилээр
- Зураг 5.1.2. Нэг их эмч, сувилагчид ногдох хүний тоо, бүс нутгаар, 2016 он
- Зураг 5.1.3. Эмнэлгийн дунд мэргэжилтэн, хүний их эмч, 10 000 хүн амд, 2006-2016 он
- Зураг 5.1.4. 10 000 хүн амд ногдох их эмч, сувилагчийн тоо, бүс нутгаар, 2016 он
- Зураг 5.1.5. Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын насны бүтэц, 2016 он
- Зураг 5.1.6. Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтанд хамрагдсан эмч, сувилагч, тусгай мэргэжилтний тоо, 2016 он
- Зураг 6.1.1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц, хувиар, 2016 он
- Зураг 6.2.1. Гар хөл амны өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2008-2016 он
- Зураг 6.2.3.1. Вирүст гепатит, 10 000 хүн амд, 2006-2016 он
- Зураг 6.3.1.1. Сүрьеэгийн өвчлөл, нас баралт 10 000 хүн амд, 2006-2016 он
- Зураг 6.3.2.1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн улаанбурхны өвчлөл, насны бүлгээр, 10 000 хүн амд, 2016 он

- Зураг 6.4.1. Бэлгийн замаар дамжих халдвар, 10 000 хүн амд, 2012-2016 он
- Зураг 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2006-2016 он
- Зураг 7.2.1. Цусны даралт ихсэх өвчин, 10 000 хүн амд, 2016 он
- Зураг 7.3.1. Чихрийн шижин өвчин, хүйсээр, бүсээр, 10 000 хүн амд, 2016 он
- Зураг 7.4.1.1. Хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарч байгаа хүний эзлэх хувь, 2016 он
- Зураг 7.5.1. Элэгний циррозын өвчлөл, нас баралт, 10 000 хүн амд, /2000-2016 он/
- Зураг 7.8.1. Мэс заслын хагалгааны тоо, аймгаар, 2016 он
- Зураг 7.8.2. Цочмог мухар олгойн мэс заслын хагалгаа, аймгаар, 2016 он
- Зураг 7.8.3. Цөсний замын мэс заслын хагалгаа, аймгаар, 2016 он
- Зураг 8.1. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2006-2016 он
- Зураг 8.2.1. Зонхилон тохиолдох хорт хавдрын нас баралт, /анх оношлогдсоноос хойшхи амьдарсан хугацаа, хувиар/, 2016 он
- Зураг 8.2.2. Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөл, /анх оношлогдсон I-IV үе шатандаа/, 2016 он
- Зураг 8.3. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын хэлбэр, хүйсээр, 10 000 хүн амд, 2016 он
- Зураг 8.3.2. Осол гэмтлийн өвчлөл, нас баралт, 10 000 хүн амд, 2006-2016 он
- Зураг 9.1.1. Эмийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2016 он
- Зураг 9.1.2. Эмнэлгийн хэрэгслийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2016 он
- Зураг 9.2.1. Монгол улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эмийн тоо, 1996-2016 он
- Зураг 9.2.2. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, түүхий эдийн тоо, 2012-2016 он
- Зураг 9.2.3. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, АТС ангилалаар, 2011-2016 он
- Зураг 9.2.4. Эмийн бүртгэлд эх орны эмийн бүтээгдэхүүний эзлэх хувь, 2012-2016 он
- Зураг 10.1. Доноруудын цус өгөлтийн тоо, сонгосон онуудаар
- Зураг 10.2. 1 000 хүн ам тутамд цус өгөлтийн тоо, сонгосон онуудаар
- Зураг 10.3. Цусны албанд цусаа бэлэглэсэн донорын төрөл, хувиар, 2012-2016 он
- Зураг 10.4. Цусны доноруудын насны бүтэц, сонгосон онуудаар
- Зураг 10.5. Доноруудын цус сэлбэлтээр дамжих халдвараар хасагдалт, 2012-2016 он
- Зураг 10.6. Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэгжээр
- Зураг 10.7. ЦССҮТ болон ЦСТ-ийн ЦЦБ үйлдвэрлэл, хувиар
- Зураг 11.1.1. ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь
- Зураг 11.1.2.А. Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангилалаар /тэрбум төгрөгөөр/
- Зураг 11.1.2.Б. Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангилалаар /хувиар/
- Зураг 11.1.3. Эрүүл мэндийн салбарын зардал, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр, хувиар
- Зураг 11.1.4. Эрүүл мэндийн салбарын зардал, дэд бүлгээр, хувиар
- Зураг 11.1.5.А. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, тусламж үйлчилгээний шатлалаар /тэрбум төгрөгөөр/
- Зураг 11.1.5.Б. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, тусламж үйлчилгээний шатлалаар /хувиар/
- Зураг 11.1.6.А. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төрлөөр /тэрбум төгрөгөөр/
- Зураг 11.1.6.Б. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төрлөөр /хувиар/
- Зураг 11.1.7. Эрүүл мэндийн салбарын зардлын санхүүжүүлэх эх үүсвэр, хувиар
- Зураг 11.2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал, тэрбум төгрөгөөр
- Зураг 11.2.2.А. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, орлогын эх үүсвэрээр /тэрбум төгрөгөөр/
- Зураг 11.2.2.Б. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, орлогын эх үүсвэрээр /хувиар/
- Зураг 11.2.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал, хувиар
- Зураг 11.2.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний зардал, даатгалын тусламж, үйлчилгээний ангилалаа, хувиар

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|          |                                                                                       |
|----------|---------------------------------------------------------------------------------------|
| АХБ      | Азийн хөгжлийн банк                                                                   |
| БОЭТ     | Бүсийн оношлогоо эмчилгээний төв                                                      |
| ГССҮТ    | Гэмтэл согог судлалын үндэсний төв                                                    |
| ДОХ/БЗДХ | Дархлал олдмол хомсдол/Бэлгийн замаар дамжих халдвар                                  |
| ДЭМБ     | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага                                                     |
| ДНБ      | Дотоодын нийт бүтээгдэхүүн                                                            |
| ЖСАХ     | Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл                                                 |
| НБЕК     | Нас баралтын ерөнхий коэффициент                                                      |
| НЭМГ     | Нийслэлийн эрүүл мэндийн газар                                                        |
| НДЕГ     | Нийгмийн даатгалын ерөнхий газар                                                      |
| ОХУ      | Оросын холбооны улс                                                                   |
| ӨОУА     | Өвчний олон улсын ангилал                                                             |
| ТЕК      | Төрөлтийн ерөнхий коэффициент                                                         |
| ТНК      | Төрөлтийн нийлбэр коэффициент                                                         |
| УБ       | Улаанбаатар                                                                           |
| УГТЭ     | Улсын гуравдугаар төв эмнэлэг                                                         |
| УНТЭ     | Улсын нэгдүгээр төв эмнэлэг                                                           |
| УХТЭ     | Улсын хоёрдугаар төв эмнэлэг                                                          |
| ҮСХ      | Үндэсний статистикийн хороо                                                           |
| УАУТХ    | Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн                                          |
| ЦССҮТ    | Цус сэлбэлт судлалын үндэсний төв                                                     |
| ЦСТ      | Цусны салбар төв                                                                      |
| ЦЦБ      | Цус, цусан бүтээгдэхүүн                                                               |
| ХДХВ/ДОХ | Дархлал олдмол хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдол                              |
| ХӨСҮТ    | Халдварт өвчин судлалын үндэсний төв                                                  |
| ХСҮТ     | Хавдар судлалын үндэсний төв                                                          |
| ЭБЭ      | Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд                                               |
| ЭМЯ      | Эрүүл мэндийн яам                                                                     |
| ЭМСЯ     | Эрүүл мэнд, спортын яам                                                               |
| ЭМБ      | Эрүүл мэндийн байгууллага                                                             |
| ЭМТ      | Эрүүл мэндийн төв                                                                     |
| ЭМСХХ    | Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр                                                |
| ЭМД      | Эрүүл мэндийн даатгал                                                                 |
| ЭХЭМҮТ   | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв                                                |
| РВЭЭ     | Ретро вирусийн эсрэг эмийн эмчилгээ                                                   |
| АТС      | Anatomical therapeutic classification/ Хүний анатомын бүтцэд суурилсан эмийн ангилал/ |
| DOTS     | Directly observed treatment short-course /шууд хяналттай богино хугацааны эмчилгээ/   |



## НОМ ЗҮЙ

1. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт тооцох аргачлал., Улаанбаатар., 2010.
2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага., Өвчний олон улсын ангилал I боть., 2008.
3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага., Өвчний олон улсын ангилал II боть., 2008.
4. Монгол улсын үндэсний статистикийн хороо., Монгол улсын статистикийн эмхтгэл., Улаанбаатар., 2013.
5. Монгол улсын үндэсний статистикийн хороо., Монгол улсын статистикийн эмхтгэл., Улаанбаатар., 2014.
6. Монгол улсын үндэсний статистикийн хороо., Монгол улсын статистикийн эмхтгэл., Улаанбаатар., 2015.
7. Нэгдсэн үндэсний байгууллагын, Хүн амын сан, Монгол улсын их сургууль, Хүн амын сургалт судалгааны төв., Эрүүл мэнд, нөхөн үржихүйн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага, цуврал II., Улаанбаатар., 2013.
8. Хавдар судлалын үндэсний төв., Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2015 оны тайлан., Улаанбаатар., 2016.
9. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл I боть., Улаанбаатар., 2016.
10. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл II боть., Улаанбаатар., 2016.
11. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл III боть., Улаанбаатар., 2016.
12. Эрүүл мэндийн хөгжлийн төв., Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл IV боть., Улаанбаатар., 2016.
13. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2011.
14. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2012.
15. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2013.
16. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2014.
17. Эрүүл мэндийн хөгжлийн төв, ЭМЯ., Эрүүл мэндийн үзүүлэлт., Улаанбаатар., 2015.

## ХУРААНГУЙ

2016 оны “Эрүүл мэндийн үзүүлэлт” эмхтгэл нь нийт 15 бүлэг, 41 дэд бүлгээс бүрдэж байгаа ба эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан гаргасан. Монгол улсын хүн ам 2016 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 119.9 мянга болж, нийт хүн амын 68.9 хувь нь хот суурин газар, үлдсэн 31.1 хувь нь хөдөө амьдарч байна. Дундаж наслалт 2016 онд 69.57 болж, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.10, эрэгтэйчүүдийнх 65.58 байна.

2016 онд улсын хэмжээнд 77 803 эх амаржсан нь 2015 онтой харьцуулахад төрөлт 2 631 тохиолдлоор буюу 3.3 хувиар буурсан байна. Улсын хэмжээнд 78 194 хүүхэд амьд төрсөн ба 1 681 нь хоёр ихэр, 27 нь гурван ихэр хүүхэд байна.

Хүн амын нас баралтын ерөнхий коэффициент 1990 онд 7.9 байсан бол 2016 онд уг үзүүлэлт 5.2 болж 1990 онтой харьцуулахад 2.7-оор буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсад 1 000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 87.5 байсан бол 2016 онд 20.8 болжээ. Нялхсын эндэгдлийн хувьд ихээхэн ахиц дэвшил гарч, 1990 онд 4,789 нялхас эндэж байсан бол 2016 онд 1 315 болж буурчээ.

Монгол Улсад эхийн эндэгдлийн түвшин 1990-ээд онд нэлээд өндөр байсан бөгөөд эхийн эндэгдлийг бууруулах хоёр удаагийн стратегийг 2001-2010 онуудад хэрэгжүүлснээр 2001-2006 онд эхийн эндэгдэл эрчимтэй буурсан. 2016 оны байдлаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 48.6 байна.

2016 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 3 500 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 13, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв 12, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сум дундын эмнэлэг 39, сумын эрүүл мэндийн төв 273, өрхийн эрүүл мэндийн төв 220, хувийн ортой эмнэлэг 234, үүдэн эмнэлэг 1 076 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн салбарт 2016 онд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд болон бусад салбарын эрүүл мэндийн ажилтан нийт 48 173 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.6 хувиар өссөн байна. Нийт ажиллагчдаас 93.2 хувь нь эрүүл мэндийн салбарын, 6.8 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна.

Нийт ажиллагчдын 22.3 хувь нь анхдагч шатлалын, 18.0 хувь нь хоёрдогч шатлалын, 16.1 хувь нь гуравдагч шатлалын, 18.1 хувь нь хувийн эмнэлгүүдэд, 25.5 хувь нь амаржих газар болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нэг их эмчид ногдох хүний тоо 2016 онд 309 байгаа нь өмнөх оныхоос 7 хүнээр буурч, нэг сувилагчид ногдох хүний тоо 269 болж, өмнөх оныхоос 2 хүнээр нэмэгдсэн байна. Эмч, сувилагчийн харьцаа улсын түвшинд 1:1.2, Улаанбаатар хотод 1:1, аймгийн түвшинд 1:1.4 байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нас баралтын 16 181 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 193 тохиолдлоор буюу 1.2 хувиар буурсан байна. Нийт нас барсан хүний 59.7 хувь нь эрэгтэй, 40.3 хувь эмэгтэй байна. Нийт нас баралтын 4 551 тохиолдол буюу 28.1 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 22.3 хувь нь хоног болоогүй нас баралт байна.

2016 онд улсын хэмжээнд 28 төрлийн халдварт өвчний 69 663 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 10 263 тохиолдлоор нэмэгдсэн буюу 10 000 хүн амд 227.8 байна.

10 000 хүн амд ногдох халдварт бус өвчлөл 8 245.4 байгаа ба үүнээс амьсгалын тогтолцооны өвчин 1 647.4, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1 231.4, шээс бэлгийн тогтолцооны өвчин 807.6, зүрх-судасны тогтолцооны өвчин 1 007.6, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин 469.9 ногдож байна.





# БҮЛЭГ 1.

МОНГОЛ УЛСЫН  
ХҮН АМ

## БҮЛЭГ 1.

# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

Энэ бүлэгт Монгол Улсын хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, дундаж наслалт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав.

Мэдээллийн үндсэн эх үүсвэр нь Үндэсний статистикийн хорооны 10 жил тутамд явуулдаг хүн ам, орон сууцны тооллого, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ, тайлан болно.

Монгол Улсын хүн амд Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харъяат хүн амыг хамруулна.

Өрх гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

Хотын хүн амд Улаанбаатар хот, аймгийн төв, тосгонд оршин суугаа хүн амыг хамруулна.

Хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөө амьдарч байгаа хүн амыг хамруулна.

Төрөлтийн хүйсийн харьцаа нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

Төрөлтийн ерөнхий коэффициент нь 1 000 хүнд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо амьд төрсөн хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, промилль-оор илэрхийлнэ.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент нь тухайн насны бүлгийн 1 000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд тухайн насны бүлэг дэх эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, промилиор илэрхийлнэ.

Төрөлтийн нийлбэр коэффициент нь нэг эмэгтэйн нөхөн үржихүйн нас /15-49/-ныхаа туршид төрүүлэх нийт хүүхдийн тоог илэрхийлэх бөгөөд насны бүлэг дэх төрөлтийн коэффициентүүдийн нийлбэрийг насны бүлгийн интервалын уртаар үржүүлж, 1 000-д хувааж тодорхойлно.


Нас баралтын ерөнхий коэффициент нь 1 000 хүнд ногдох тухайн жилд нас барсан хүний тоог илэрхийлэх бөгөөд тухайн жилд нас барсан хүний тоог хүн амын тухайн жилийн дундаж тоонд харьцуулж, промилиор илэрхийлнэ. Ердийн цэвэр өсөлтийг төрөлт, нас баралтын абсолют зөрүүгээр тодорхойлно.

### 1.1. Хүн ам


Монгол улсын хүн ам 2016 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 119.9 мянга болж, өмнөх оноос 62.1 мянган хүн буюу 2.0 хувиар өссөн байна. Нийт хүн амын 68.9 хувь нь хот суурин газар, үлдсэн 31.1 хувь нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хотод 1 440.4 мянган хүн буюу нийт хүн амын 46.2 хувь нь оршин сууж байна.

Хүн амын 49.2 хувь нь эрэгтэйчүүд, 50.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 97 байна. Насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 30.0 хувийг, 15- 64 насны хүн ам 66.2 хувийг, 65-аас дээш насны хүн ам 3.8 хувийг тус тус эзэлж байна. Өрхийн тоо 2016 оны байдлаар 869.8 мянга болж өрх, 67.8 хувь нь хотод, 32.2 хувь нь хөдөө байна. Улаанбаатар хотод 380.8 мянган өрх, хангайн бүсэд 171.0, төвийн бүсэд 149.1, баруун бүсэд 104.2, зүүн бүсэд 64.7 мянган өрх байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.5 хүн ногдож байна.

**Зураг 1.1.1. 2016 оны хот, хөдөөгийн хүн амын тоо, аймгаар**




**Зураг 1.1.2. 2016 оны дундаж хүн амын тоо, аймгаар**




Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 67.8 хувь нь буюу 2 сая 76.8 мянган хүн хот, тосгонд амьдарч байгаагийн дотор Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь аймгийн хүн амын талаас илүү хувь нь хот тосгонд амьдарч байна.

**Зураг 1.1.3. Монгол улсад оршин суугаа хүн амаас хот, хөдөөгийн хүн амын эзлэх хувь, 2010-2016 он**



**Зураг 1.1.4. Хүн амын тоо, жилийн өсөлтийн хувь, сонгосон онуудаар**




Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн хувь нэмэгдэж 2011 онд 1.74 байсан бол 2016 онд 2.0 болж 0.26 пунктээр нэмэгдсэн байна.

## 1.2 ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өнгөрсөн 10 жилд нийтдээ 719.6 мянган хүүхэд төрсний дотор 2007-2009 онуудад төрөлт өмнөх жилүүдийнхээс тогтвортой нэмэгдсэн ба 2014 онд 81.7 болж сүүлийн 10 жилийн хамгийн өндөр төрөлт байсан ба 2016 онд 78.1 мянга болсон байна.

**Зураг 1.2.1. Төрөлт, амьд төрсөн нярайн тоо, сүүлийн 5 жилээр**




Түүнчлэн 1990 онд 1 000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 35.3 байсан бол 2005 онд 17.8 болж 2 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2006 оноос тогтвортой нэмэгдэн 2016 онд 25.3 болсон нь өмнөх оныхоос 1.4 пунктээр буурсан байна.

Төрсөн хүүхдийн тоо 2016 онд 78.1 мянгад хүрч өмнөх оныхоос 3.3 хувиар буурсан байна.. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд 105 хөвгүүн ногдож байна.

**Хүснэгт 1.2.1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар**

| Үзүүлэлт                   | 1990    | 2008    | 2009    | 2010    | 2011    | 2012    | 2013    | 2014    | 2015    | 2016    |
|----------------------------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|
| Нийт хүн (мян)             | 2 149.2 | 2 683.5 | 2 735.5 | 2 780.7 | 2 811.6 | 2 867.7 | 2 930.3 | 2 995.9 | 3 057.7 | 3 119.9 |
| Хотын хүн ам (хувиар)      | 54.6    | 61.4    | 62.6    | 63.3    | 67.1    | 67.2    | 68.1    | 66.4    | 68.0    | 68.9    |
| Хөдөөгийн хүн ам (хувиар)  | 45.4    | 38.6    | 37.4    | 36.7    | 32.9    | 32.8    | 31.9    | 33.6    | 32.0    | 31.1    |
| Насны бүлгээр (хувиар)     |         |         |         |         |         |         |         |         |         |         |
| 0-15                       | 41.5    | 28.1    | 27.6    | 27.3    | 27.2    | 27.6    | 27.4    | 28.0    | 29.6    | 30.0    |
| 15-64                      | 54.4    | 67.8    | 68.4    | 68.8    | 68.8    | 68.4    | 68.8    | 68.0    | 66.6    | 66.2    |
| 65 аас дээш                | 4.1     | 4.1     | 4.0     | 3.9     | 4.0     | 4.0     | 3.8     | 4.0     | 3.8     | 3.8     |
| Хүн ам зүйн коэффициентууд |         |         |         |         |         |         |         |         |         |         |
| ТЕК                        | 35.3    | 23.7    | 25.3    | 23.8    | 25.3    | 26.3    | 27.5    | 27.6    | 26.7    | 25.3    |
| НБЕК                       | 7.9     | 5.7     | 5.7     | 6.3     | 6.2     | 5.9     | 5.6     | 5.6     | 5.4     | 5.2     |
| Цэвэр өсөлт                | 2.7     | 1.8     | 1.9     | 1.7     | 1.9     | 2.0     | 2.2     | 2.2     | 2.1     | 2.1     |
| ТНК                        | 4.3     | 2.6     | 2.8     | 2.4     | 2.6     | 2.7     | 3.0     | 3.1     | 3.1     | 3.0     |

Хүн амын нас баралтын ерөнхий коэффициент 1990 онд 7.9 байсан бол 2016 онд уг үзүүлэлт 5.2 болж 1990 онтой харьцуулахад 2.7-оор буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг 1.2.2. Төрөлтийн нийлбэр коэффициент, сонгосон онуудаар**

Нэг эмэгтэйн амьдалынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоо 1990 онд 4.3 байсан бол 2000-2003 онд гэхэд 2 дахин буурч, 2010 онд 2.4 байсан бөгөөд 2016 онд 3.0 болон нэмэгдсэн байна.

**1.3 ДУНДАЖ НАСЛАЛТ**

Дэлхийн хүн амын дундаж наслалт 1950 оноос хойш 1990-ээд оныг эс тооцвол арван жил тутамд 3-аас дээш жилээр нэмэгдэж байна.

1990-ээд оны үед Африкийн орнуудад ХДХВ-ийн тархалт өндөр байсан, хуучин ЗХУ-ын задралын үе болон Европын орнуудад нас баралтын түвшин өндөр байсантай холбоотой дундаж наслалтын зогсолтын үе байсан.

Дэлхийн ихэнх бүс нутгуудад 2000 оноос эхлэн хүн амын дундаж наслалт нэмэгдсэн ба өөрөөр хэлбэл 2000-2015 оны хооронд 5 жилээр, ДЭМБ-ын мэдээллээр Африкийн бүс нутагт 9.4 жилээр тус тус нэмэгдсэн хандлага ажиглагдсан байна.

Дэлхийн хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтын 2000 оноос хойшхи өсөлт нь өнгөрсөн

зууны туршид гарсан үзүүлэлтийн хамгийн сайн буюу дундаж түвшинг давсан үзүүлэлт байсан байна. Манай орны хувьд 2016 оны байдлаар төрөлтөөс тооцсон дундаж наслалт 69.57 болсон нь өмнөх оноос 0.32 пунктээр буурсныг илэрхийлж байгаа ба эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.10, эрэгтэйчүүдийнх 65.58 болсон байна. Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү амьдардаг. Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.52 жилээр илүү байна.

2016 оны байдлаар дэлхийн улс орнуудын хүн амын дундаж наслалтаас харахад Монако улс хамгийн өндөр буюу 89.42 жил, Чад улс хамгийн бага буюу 49.81 жил байна. Монгол улс 159-д бичигджээ.

**Хүснэгт 1.3.1. Хүн амын дундаж наслалт, эхний 10 байранд байгаа орнуудын жагсаалтаар**

| Жагсаалт | Улс/хот               | Дундаж наслалт | Мэдээлэл тавигдсан хугацаа |
|----------|-----------------------|----------------|----------------------------|
| 1        | Монако/Monaco         | 89.42          | 2016 он                    |
| 2        | Япон/Japan            | 85.26          | 2016 он                    |
| 3        | Сингапур/Singapore    | 85.21          | 2016 он                    |
| 4        | Макао/Macau           | 84.55          | 2016 он                    |
| 5        | Сан-Марино/San Marino | 83.34          | 2016 он                    |
| 6        | Андора/Andorra        | 82.85          | 2016 он                    |
| 7        | Жерсей/Jersey         | 82.61          | 2016 он                    |
| 8        | Хонконг/Hong Kong     | 82.52          | 2016 он                    |
| 9        | Австрали/Australia    | 82.31          | 2016 он                    |
| 10       | Итали/Italy           | 82.28          | 2016 он                    |


<http://www.infoplease.com/world/statistics/life-expectancy-country.html>

2016 оны байдлаар дундаж наслалт аймаг, бүсүүдээр ялгаатай байгаа ба Хангайн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу 69.61, Төвийн бүсийн хүн амын дундаж наслалт 71.45 байгаа нь хамгийн өндөр байна. Аймгуудаар харуулбал Хөвсгөл /65.79/, Увс /68.82/, Дорнод /68.41/, Дархан-Уул /68.51/, Говь-Алтай /68.84/, Баянхонгор /68.89/, Завхан /69.19/ зэрэг аймгууд дундаж наслалтаараа улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна.

### Хүснэгт 1.3.2. Хүн амын дундаж наслалт бүсээр, хүйсээр, 2016 он

| Аймаг, хот         | Бүгд         | Эрэгтэй      | Эмэгтэй      |
|--------------------|--------------|--------------|--------------|
| <b>Баруун бүс</b>  | <b>70.26</b> | <b>66.38</b> | <b>73.41</b> |
| Баян-Өлгий         | 72.76        | 69.45        | 75.16        |
| Говь-Алтай         | 68.84        | 63.99        | 72.33        |
| Завхан             | 69.19        | 66.77        | 71.82        |
| Увс                | 68.82        | 63.44        | 72.21        |
| Ховд               | 71.71        | 68.27        | 75.55        |
| <b>Хангайн бүс</b> | <b>69.61</b> | <b>66.76</b> | <b>73.50</b> |
| Архангай           | 70.54        | 68.02        | 72.07        |
| Баянхонгор         | 68.89        | 65.51        | 70.66        |
| Булган             | 72.30        | 67.69        | 75.34        |
| Өвөрхангай         | 69.32        | 66.72        | 72.16        |
| Хөвсгөл            | 65.79        | 62.76        | 70.53        |
| Орхон              | 70.83        | 69.83        | 80.23        |
| <b>Төвийн бүс</b>  | <b>71.45</b> | <b>68.05</b> | <b>75.53</b> |
| Говьсүмбэр         | 72.86        | 71.43        | 75.40        |
| Дархан-Уул         | 68.51        | 64.21        | 73.24        |
| Дорноговь          | 70.17        | 65.52        | 75.34        |
| Дундговь           | 73.22        | 70.15        | 77.87        |
| Өмнөговь           | 71.44        | 67.65        | 74.74        |
| Сэлэнгэ            | 71.87        | 67.61        | 77.10        |
| Төв                | 72.06        | 69.79        | 74.99        |
| <b>Зүүн бүс</b>    | <b>70.38</b> | <b>66.52</b> | <b>74.29</b> |
| Дорнод             | 68.41        | 64.46        | 72.75        |
| Сүхбаатар          | 71.78        | 66.88        | 75.70        |
| Хэнтий             | 70.94        | 68.22        | 74.43        |
| <b>Улаанбаатар</b> | <b>71.8</b>  | <b>66.5</b>  | <b>75.3</b>  |
| Улаанбаатар        | 71.24        | 66.04        | 74.67        |

### Зураг 1.3.1. Нас, хүйсийн суварга, бодит тоогоор, /2006, 2016он/





Дээрх хүн амын нас, хүйсийн суваргыг харахад 2006 онд 10-19 насныхны хувь харьцангуй их байхад 2016 оны суварга нь дунд хэсгээрээ буюу 25-34 насны хүн амд аажмаар өргөсч байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын хувь нэмэгдэж хүн амын цонх үе үргэлжлэхийг харуулж байна. Суваргаас харвал 2016 онд 0-4 насны хүн амын тоо хамгийн өндөр байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин эрс буурч байсан ч 2006 оноос эхлэн нэмэгдэж өнгөрсөн онд 1985 оны түвшинд хүрсэнтэй холбоотой юм.



## БҮЛЭГ 2.

ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛТЫН  
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## БҮЛЭГ 2.

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тогтвортой Хөгжлийн Зорилтууд нь олон улсын хөгжлийн талаар ирээдүйд биелүүлэхээр санал болгон дэвшүүлж буй багц зорилтууд буюу 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл бөгөөд 2015 оны 9-р сард НҮБ-ын дээд хэмжээний 70 дугаар чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг баталсан.

Монгол Улсын ИХ Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг батлан гаргасан байна. Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016-2020, 2020-2025, 2025-2030 он гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд Монгол Улс ядуурлын бүх төрлийг эцэс болгож, монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг ханган дундаж наслалтыг 78-д хүргэж хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно гэж тооцсон байна.

Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 3 дахь зорилго нь “Эрүүл амьдралыг хангах” буюу бүх түвшинд эрүүл амьдралыг хангаж, сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих зорилго тавьсан байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 17 ЗОРИЛГО

|                                                                                   |                                                             |                                                                                                                                       |
|-----------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| ТХЗ-1 (7, 11)                                                                     | ТХЗ-7 (5, 10)                                               | ТХЗ-13 (5, 8)                                                                                                                         |
| Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох                                                | Тогтвортой, сэргээгдэх, орчин үеийн эрчим хүчээр хангах     | Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх                                                                                                      |
| ТХЗ-2 (8, 12)                                                                     | ТХЗ-8 (12, 22)                                              | ТХЗ-14 (10, 20)                                                                                                                       |
| Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангах, тогтвортой ХАА-г хөгжүүлэх | Тогтвортой эдийн засгийг дэмжих, ажлын байрыг бий болгох    | Далай, тэнгисийг тогтвортой хөгжлийн зорилгоор ашиглах                                                                                |
| ТХЗ-3 (13, 26)                                                                    | ТХЗ-9 (8, 22)                                               | ТХЗ-15 (12, 24)                                                                                                                       |
| Эрүүл амьдралыг хангах                                                            | Тогтвортой дэд бүтэц, шинэ технологи, үйлдвэржилтийг дэмжих | Экосистемийг хадгалах, цөлжилттэй тэмцэх, бэлчээрийн даацыг зөв зохистой ашиглах                                                      |
| ТХЗ-4 (10, 15)                                                                    | ТХЗ-10 (10, 17)                                             | ТХЗ-16 (12, 21)                                                                                                                       |
| Бүх нийтийн боловсролыг хөгжүүлэх, насан туршийн боловсролыг дэмжих               | Улс орнуудын ялгаатай байдлыг бууруулах                     | Тогтвортой, бүх нийтийн оролцоог хангасан нийгмийг цогцлоох, шударга ёсыг дээдэлсэн нийгмийг хөгжүүлэх                                |
| ТХЗ-5 (9, 23)                                                                     | ТХЗ-11 (10, 20)                                             | ТХЗ-17 (19, 38)                                                                                                                       |
| Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах                   | Тогтвортой, аюулгүй хот суурин бий болгох                   | Тогтвортой хөгжлийн төлөөх сайн түншлэлийг хөгжүүлэх                                                                                  |
| ТХЗ-6 (8, 12)                                                                     | ТХЗ-12 (11, 21)                                             | <b>Шар:</b> нийгмийн, <b>Хөх:</b> эдийн засгийн, <b>Ногоон:</b> байгалийн хөрөнгө, <b>Ягаан:</b> институцийн хөгжилд чиглэгдсэн болно |
| Ус болон ахуйн ариун цэврийн хэрэглээг хангах                                     | Тогтвортой, зөв хэрэглээг бий болгох                        |                                                                                                                                       |

**Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.**

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 2020 он гэхэд 71, 2025 онд 74, 2030 он гэхэд 78-д хүргэнэ гэж заасан байна.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2016 онд 69.57 болсон ба өмнөх оныхоос 0.32 пунктээр буурсан бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.10, эрэгтэйчүүдийнх 65.58 болсон байна. Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү амьдардаг байна. Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.52 жилээр илүү байна.

**Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.**

Зорилтод тусгаснаар **2020 онд** Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 25, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 13 болгож бууруулахаар;

**2025 онд** Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 20, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 11 болгож бууруулахаар;

**2030 онд** сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 15, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1 000 амьд төрөлтөд 9, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

**Хүснэгт 2.1. Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар**

| Үзүүлэлт       | 1990  | 2000  | 2006 | 2007  | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2020              |
|----------------|-------|-------|------|-------|------|------|------|------|------|------|------|------|------|-------------------|
| Улсын дундаж   | 199.0 | 158.5 | 69.7 | 89.6  | 49.0 | 81.4 | 45.5 | 48.2 | 50.8 | 42.6 | 30.6 | 26.0 | 48.6 | 25.0 <sup>a</sup> |
| УБ хот         | 126.0 | 171.1 | 71.8 | 73.7  | 55.2 | 78.9 | 46.2 | 44.2 | 43.0 | 52.3 | 35.9 | 28.8 | 41.8 | -                 |
| Аймгийн дундаж | 230.0 | 153.4 | 68.2 | 102.0 | 44.3 | 83.5 | 44.9 | 51.8 | 58.6 | 32.8 | 25.0 | 23.0 | 56.0 | -                 |

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" батлах тухай, 2016 он

Манай улсад эхийн эндэгдэл 1990 оны түвшингээс 4.1 дахин буурч, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрээд байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд эхийн эндэгдлийн түвшин тогтвортой буурч 2007 онд 100 000 амьд төрөлтөд 89.6 байсан бол 2015 онд 26.0 болж хамгийн бага түвшинд хүрсэн. Харин 2016 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 48.6 болж өмнөх оноос 22.6-оор нэмэгдсэн хэдий ч 2007 онтой харьцуулахад 41-оор буурсан байна.

2016 оны байдлаар эхийн эндэгдлийн 38 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 48.6 байна. 2015 оноос эхийн эндэгдэл 17 тохиолдлоор буюу 44.7 хувиар, 100 000 амьд төрөлт тутамд 22.6 эндэгдлээр өссөн байна. Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Увс, Хэнтий зэрэг аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Эхийн эндэгдлийн 78.9 хувь нь эмнэлэгт, 21.1 хувь нь гэртээ эндсэн байна.

**Хүснэгт 2.2. Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин**

(1 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

| Үзүүлэлт                                               | 1990 | 2000  | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2020              |
|--------------------------------------------------------|------|-------|------|------|------|------|------|------|------|------|------|-------------------|
| Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/                  |      |       |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| <b>Хүйс</b>                                            |      |       |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| Эрэгтэй                                                | -    | -     | 22.4 | 22.6 | 21.3 | 17.5 | 17.1 | 16.0 | 17.2 | 17.4 | 18.6 |                   |
| Эмэгтэй                                                | -    | -     | 16.6 | 17.6 | 17.3 | 15.1 | 13.4 | 13.1 | 13.3 | 13.0 | 14.9 |                   |
| <b>Байршил</b>                                         |      |       |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| Улсын дундаж                                           | 63.4 | 31.23 | 19.6 | 20.2 | 19.4 | 16.3 | 15.3 | 14.6 | 15.3 | 15.3 | 16.8 | 13.0 <sup>a</sup> |
| УБ хот                                                 | 70.3 | 32.8  | 17.5 | 18.0 | 16.1 | 13.3 | 13.1 | 13.6 | 15.0 | 14.7 | 15.0 | -                 |
| Аймгийн дундаж                                         | 62.5 | 30.8  | 21.2 | 21.9 | 22.1 | 19.2 | 17.5 | 15.7 | 15.7 | 15.9 | 18.8 | -                 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ |      |       |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| <b>Хүйс</b>                                            |      |       |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| Эрэгтэй                                                | -    | -     | 26.4 | 25.9 | 26.4 | 21.9 | 20.8 | 22.6 | 20.3 | 20.7 | 23.0 |                   |
| Эмэгтэй                                                | -    | -     | 20.2 | 21.2 | 22.7 | 18.0 | 16.5 | 16.9 | 16.4 | 15.7 | 18.5 |                   |
| <b>Байршил</b>                                         |      |       |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| Улсын дундаж                                           | 87.5 | 42.4  | 23.4 | 23.6 | 24.6 | 20   | 18.7 | 18.0 | 18.4 | 18.3 | 20.8 | 15.0 <sup>a</sup> |
| УБ хот                                                 | 99.9 | 42.4  | 20.8 | 21.0 | 20.6 | 16.2 | 16.0 | 16.3 | 17.8 | 17.3 | 18.2 | -                 |
| Аймгийн дундаж                                         | 94.4 | 42.5  | 25.3 | 25.7 | 28.0 | 23.5 | 21.3 | 19.7 | 19.0 | 19.2 | 23.7 | -                 |

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" батлах тухай, 2016 он

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурч байгаагийн илрэл нь 1 000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2016 онд 1990 оны түвшинтэй харьцуулахад 4.2 дахин ба нялхсын эндэгдэл 3.8 дахин тус тус буурснаас харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд нялхсын эндэгдэл тогтвортой буурч Мянганы хөгжлийн зорилтын үзүүлэлтийг хангаад байсан бөгөөд 2013 онд хамгийн бага түвшинд хүрч 1 000 амьд төрөлтөд 14.6 болсон ба 2014, 2015 онд 15.3 болсон.

2016 оны байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдэл 1 315 тохиолдол бүртгэгдэж, 1 000 амьд төрөлтөд 16.8 ногдож байгаа нь өмнөх оноос 1.5-оор өссөн байна.

Нялхсын эндэгдэл өмнөх оноос өссөн шалтгаан нь улаанбурхан өвчин дэгдэлт хэлбэрээр гарч улаанбурхан өвчний хүндрэл хатгаагаар 1 хүртэлх насны нийт 118 хүүхэд эндсэнтэй холбоотой ба энэ нь нийт эндсэн хүүхдийн 9.6 хувийг эзэлж байна.

Улаанбурхан өвчний улмаас нас барсан тохиолдлуудын 78.7 хувийг 0-8 сартай буюу вакцинжуулалтад хамрагдах нас болоогүй хүүхдүүд байсан ба хүйсийн хувьд 56.8% (75)-ийг эрэгтэй хүүхэд эзэлж байна. Хамгийн их өртсөн нас нь 4 сартай хүүхдүүд байна.

Нас барсан тохиолдлын 58.9%(73) нь хавсарсан болон суурь өвчтэй байсан. Үүнд: цус багадалт, тэжээлийн дутагдал, сульдаа, шүүдэст эмзэгшил, дархлаа эсгэгийн дутмагшил, ДЦП, зүрхний төрөлхийн хоргүй хавдар, моноклеоз, дауны өвчин, уушиг зүрхний төрөлхийн гажиг, тархины даралт байна. Нас баралтын үндсэн шалтгаан нь улаанбурхан өвчний хүндрэл уушигны хатгаа байна

### **Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2020 он гэхэд 15.0 болгон бууруулна гэж заасан.

2016 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 000 амьд төрөлтөд 20.8 байгаа нь 2007 онтой харьцуулахад 1.3-оор буурсан хэдий ч өмнөх оноос 2.5-оор нэмэгдсэн байна.

2016 онд тав хүртэлх насандаа 1 628 хүүхэд эндсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 152 тохиолдлоор илүү буюу амьд төрсөн 1 000 хүүхдэд ногдох эндэгдэл 2.5 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 86.7 хувь нь өвчнөөр, 13.3 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн бөгөөд 75.2 хувь нь эмнэлэгт, 19.5 хувь нь гэртээ, 5.3 хувь нь бусад газар эндсэн байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн өссөн шалтгаан нь 2016 онд улаанбурхан өвчнөөр нийт 127 хүүхэд эндсэнтэй холбоотой ба энэ нь эндсэн хүүхдийн 7.8 хувийг эзэлж байна.

Өвчний учир эндсэн хүүхдийн 34.1 хувийг перинатал үеийн эмгэг, 19.5 хувийг амьсгалын тогтолцооны эмгэг /хатгаа/, 8.9 хувийг улаанбурхан өвчний шалтгаант эндэгдэл эзэлж байна.

**Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.**

**2020 онд** хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах;

**2025 онд** эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулах;

**2030 онд** 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

1995 оноос хойш хүн амын нас баралтын шалтгаанд зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдрын шалтгаант нас баралт тэргүүлсээр байна.

2016 онд хүн амын нас баралтын шалтгааны 33.1 хувийг зүрх-судасны тогтолцооны өвчин, 25.6 хувийг хавдрын шалтгаант нас баралт эзэлж байгаа нь нийт хүн амын нас баралтын шалтгааны

58.7 хувийг эзэлж байна.

Жилд дунджаар 5 000-5 500 гаруй хүн буюу нас барсан 3 хүний нэг нь зүрх-судасны тогтолцооны өвчин, 4 хүний нэг нь буюу 4 000 гаруй хүн хорт хавдрын улмаас нас барж байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д 2020 он гэхэд 10 000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулна гэж заасан байна.

2016 онд зүрх-судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 20.54, 10 000 эмэгтэй хүн амд 14.46 ногдож байгаа ба 2007 онтой харьцуулахад буурах хандлагатай байгаа хэдий ч 45-64 насны бүлгийн эрэгтэйчүүдийн дунд 10 000 хүн амд ногдох зүрхний ишемийн өвчин 25.8, тархинд цус харвалт 19.8, цусны даралт ихсэх өвчин 1.3 ногдож байгаа бөгөөд тухайн насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшинтэй харьцуулбал зүрхний ишемийн өвчний нас баралт 4.7 дахин, тархинд цус харвалтын өвчний шалтгаант нас баралт 2.0 дахин өндөр, цусны даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 1.4 дахин их байна.

**Хүснэгт 2.3. Зүрх судасны тогтолцооны өвчин, Хорт хавдрын шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2007-2016 он**

| Үзүүлэлт                              | 2007  | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  | 2015  | 2016  | 2020              |
|---------------------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------------------|
| <b>Зүрх-судасны тогтолцооны өвчин</b> |       |       |       |       |       |       |       |       |       |       |                   |
| Нийт                                  | 21.92 | 20.54 | 21.74 | 23.61 | 22.58 | 20.91 | 19.60 | 19.11 | 18.86 | 17.45 | 17.4 <sup>a</sup> |
| Эрэгтэй                               | 25.21 | 22.02 | 24.19 | 27.33 | 26.65 | 25.02 | 22.70 | 22.10 | 21.66 | 20.54 | -                 |
| Эмэгтэй                               | 18.80 | 18.76 | 19.41 | 20.29 | 18.73 | 17.04 | 16.70 | 16.20 | 15.40 | 14.46 | -                 |
| <b>Хорт хавдар</b>                    |       |       |       |       |       |       |       |       |       |       |                   |
| Нийт                                  | 12.21 | 11.80 | 11.89 | 13.02 | 12.69 | 12.60 | 13.00 | 13.52 | 13.59 | 13.41 | 10.5 <sup>a</sup> |
| Эрэгтэй                               | 13.25 | 13.45 | 13.95 | 15.11 | 15.85 | 14.74 | 14.9  | 15.5  | 14.81 | 15.07 | -                 |
| Эмэгтэй                               | 9.50  | 10.10 | 9.92  | 11.15 | 10.36 | 10.67 | 11.2  | 11.7  | 11.6  | 11.61 |                   |

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016

Хорт хавдрын шалтгаант нас баралт нь 1990 оноос хойш хүн амын нас баралтын 2 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байгаа ба 2016 оны байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 15.07, 10 000 эмэгтэй хүн амд 11.61 ногдож байна. 2007 оны байдлаар 10 000 хүн амд ногдох нийт нас баралт 12.21 байсан бол 2016 онд 13.41 болж 1.2-оор нэмэгдсэн байгаа ба цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг, гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, уушиг, гуурсан хоолойн хорт хавдар нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд орж байна.

**Зорилт 4.** Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.

Энэхүү зорилтод **2020 он** гэхэд товлотл дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14.4 болгон бууруулах;

**2025 онд** товлот дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10 000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 болгон бууруулах;

**2030 онд** товлот дархлаажуулалтын хамралтын хувийг 99.8, 10 000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болгон бууруулах зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

10 000 амд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 1996 онд 14.6 байсан бол 2006 онд 18.6 болж 1.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2007 оноос эхлэн өвчлөл буурч 10 000 хүн амд ногдох түвшин 16.8 байсан бол 2011 онд 14.3, 2015 онд 14.1, 2016 оны байдлаар 13.1 болж тус тус буурсан байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар жилд дунджаар 4 000 гаруй сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдэж, 2012-2015 онуудад сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол жил бүр нэмэгдэж байсан бол 2016 онд өмнөх оноос 225 тохиолдлоор буурсан байна.

**Хүснэгт 2.4.** Сүрьеэ, вируст гепатитийн өвчлөлийн түвшин (10 000 хүн амд), сонгосон онуудаар

| Үзүүлэлт              | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2020              |
|-----------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|-------------------|
| <b>Сүрьеэ өвчин</b>   |      |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| Нийт                  | 16.8 | 16.0 | 15.6 | 15.3 | 14.3 | 13.9 | 14.2 | 14.1 | 14.1 | 13.1 | 14.4 <sup>a</sup> |
| Эрэгтэй               | 18.2 | 17.4 | 16.4 | 16.7 | 16.5 | 15.9 | 16.2 | 16.1 | 15.7 | 14.2 |                   |
| Эмэгтэй               | 15.4 | 14.6 | 14.8 | 13.9 | 12.2 | 12.0 | 12.3 | 12.1 | 12.5 | 12.0 |                   |
| <b>Вируст гепатит</b> |      |      |      |      |      |      |      |      |      |      |                   |
| Нийт                  | 38.5 | 39.3 | 25.3 | 33.0 | 52.7 | 24.1 | 8.8  | 3.9  | 2.9  | 1.8  | 3.0 <sup>a</sup>  |
| Эрэгтэй               | 41.7 | 42.6 | 28.3 | 36.4 | 59.1 | 27.1 | 10.4 | 4.7  | 3.3  | 2.0  |                   |
| Эмэгтэй               | 35.5 | 36.2 | 22.5 | 29.7 | 46.5 | 21.4 | 7.2  | 3.1  | 2.6  | 1.7  |                   |

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" батлах тухай, 2016

2016 онд улсын хэмжээнд вирүст гепатит өвчний 566 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 0.8 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 326 тохиолдлоор буурсан байна. Нийт вирүст гепатитийн өвчлөлийн 6.9 хувийг вирүст гепатит А, 64.8 хувийг вирүст гепатит В, 28.3 хувийг бусад вирүст гепатит тус тус эзэлж байна.

Нийт гепатитийн өвчлөлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 000 хүн амд вирүст гепатит А 0.2-оор, вирүст гепатит В 0.4-оор тус тус буурсан үзүүлэлтэй байна.

Вирүст гепатит 2007 онд 10 000 хүн тутамд 38.5 байсан бол 2016 онд 1.8 болж буурсан байна.





## БҮЛЭГ 3.

ЭХ ХҮҮХДИЙН  
ЭРҮҮЛ МЭНД


## БҮЛЭГ 3.

# ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### 3.1. ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын Засгийн Газраас хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг тодорхойлсон бөгөөд 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын 61 дүгээр тогтоолоор “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний дөрөв дэх хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2012-2016 онуудад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих замаар монгол хүний хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх юм.

**Зураг 3.1.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, /2003-2016 он/**



100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл өмнөх 10 жилтэй харьцуулахад 2016 онд 48.6 болж буурсан байна. Гэвч өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлт харагдаж байна.


### 3.2. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ БА ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны байдлаар улсын хэмжээнд 75 851 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд 84.7 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа, 13.8 хувь нь 4-6 сартайдаа, 1.5 хувь нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ.

Жирэмсний эрт үеийн хяналтыг хот, хөдөөгөөр авч үзвэл хотод жирэмсэн эмэгтэйчүүдийн 85.0 хувь нь, хөдөө орон нутагт 84.4 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад хотод 0.9 хувиар, хөдөө орон нутагт 0.2 хувиар өссөн байна.

Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.6 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдсанаас 3.7 хувь нь цус багадалттай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.2 хувиар буурсан байна. Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Ховд аймагт шинжилгээгээр илэрсэн цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь улсын дүнгээс 2.0-9.6 хувиар их байна.

**Зураг 3.2.1. Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, 2016 он**



Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд 97.1 хувь хамрагдсанаас 2.4 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Баянхонгор 3.3, Говь-Алтай 3.6, Говьсүмбэр 4.1, Сэлэнгэ 4.5, Хөвсгөлд 4.9 хувь байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 0.9-2.5 хувиар их байна.

Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 91.3 хувь нь хамрагдсан нь өмнөх оноос 1.0 хувиар буурсан байна. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.5 хувьд нь заг хүйтэн өвчин илэрчээ. Баян-Өлгий 1.0, Булган 1.0, Дорнод 1.6, Өмнөговь 2.6, Сүхбаатар 1.2, Хөвсгөл 1.9 хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дунджаас 0.5-2.1 хувиар их байна.


Трихомониаз илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 91.5 хувь нь хамрагдсанаас 2.0 хувьд нь эерэг үзүүлэлттэй байгаагаас Баянхонгор 11.0, Булган 4.0, Дорноговь 2.7, Дорнод 5.3, Орхон 3.4, Өмнөговь 2.8, Сүхбаатар 4.6, Сэлэнгэ 4.5, Төв 2.6 хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дунджаас 0.6-9.0 хувиар их байна.

Хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 53.4 хувь нь рентген шинжилгээнд хамрагдаж идэвхтэй сүрьеэгийн 341 тохиолдол буюу 0.8 хувьд эерэг гарсан байна.

2016 онд эхчүүдийн амрах байр улсын хэмжээнд 345 ажиллаж байгаагаас 266 нь сумын эрүүл мэндийн төвд, сум дундын эмнэлэгт 39, аймгийн нэгдсэн эмнэлэгт 18, тосгоны эрүүл мэндийн төвд 10, хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт 5, БОЭТ-д 5, Улаанбаатар хотын эмнэлэгт 2 тус тус ажилласан байна.

Эхчүүдийн амрах байрны 117 буюу 33.9 хувь нь зориулалтын байранд байгаа ба 227 буюу 65.8 хувь нь эмнэлэг дотор, 0.3 хувь нь гэрт байрлаж нийт 67 184 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.6 байна. 2016 онд 6 байр шинээр баригдаж, 27 байранд засвар үйлчилгээ, 77 байранд тохижилт хийгдсэн байна. Нийт амарвал зохих эхчүүдийн 76.2 хувь нь амрах байранд амарсан байна.

**Зураг 3.2.2. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2016 он**



2016 оны байдлаар нийт төрсөн эхчүүдийн 83.6 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад байж төрсөн нь өмнөх онтой харьцуулахад 2.4 хувиар буурсан байна.

### 3.3. ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ


2016 онд улсын хэмжээнд 77 803 эх амаржсан нь 2015 онтой харьцуулахад төрөлт 2 631 тохиолдлоор буюу 3.3 хувиар буурсан байна. Төрөлт Баян-Өлгий, Дорнод, Увс зэрэг аймгуудад нэмэгдэж бусад аймаг болон Улаанбаатар хотод буурчээ. 1 000 хүн амд ногдох төрөлтийн түвшин улсын дүнгээр 25.3 байгаа бол энэ үзүүлэлт Баян-Өлгий 28.3 Дорнод 27.0, Ховд 26.4, зэрэг аймгуудад улсын дунджаас илүү байна.

**Зураг 3.3.1. 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2016 он**



Нийт төрөлтийн 47.7 хувь нь Улаанбаатар хотод, 28.9 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 12.2 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 6.3 хувь нь сум, сум дунд, тосгон, ортой их эмчийн салбарт, 2.3 хувь нь хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт, 2.1 хувь нь хувийн эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвд, 0.4 хувь нь гэртээ төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 29.8 хувь нь анхны төрөлт, 45.5 хувь нь 3 ба түүнээс дээш жилийн зайтай төрсөн ба нийт төрөлтийн 99.8 хувийг эмнэлгийн мэргэжилтэн удирдан явуулсан байна. Насны хувьд 5.0 хувь нь 20 хүртэлх насны, 15.3 хувь нь 35-аас дээш насны төрөлт эзэлж байна. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход 2016 онд нөхөн үржихүйн насны 1 000 эмэгтэй тутмын 92 нь хүүхэд төрүүлсэн байна.

**Зураг 3.3.2. Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2016 он**




ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг ба манай улсын хувьд 2016 оны байдлаар харьцангуй өндөр буюу 25.4 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар төрсөн эхийн тоог өмнөх онтой харьцуулахад 210 тохиолдлоор буюу 1.0 хувиар буурсан байна. Мэс заслын аргаар төрлөгийг шийдсэн хувийг аймгийн дундажтай харьцуулахад баруун бүсэд 2.7 хувиар бага, харин хангай, төв болон зүүн бүсэд 0.2-1.3 хувиар их байна.

**Хүснэгт 3.3.1 Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр 2016 он**

|                    | Төрсөн эх     | Мэс заслын аргаар төрсөн эхийн тоо | Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь |
|--------------------|---------------|------------------------------------|-------------------------------------|
| Баруун бүс         | 9 662         | 1 770                              | 18.3                                |
| Төвийн бүс         | 13 004        | 2 902                              | 22.3                                |
| Хангайн бүс        | 9 756         | 2 067                              | 21.2                                |
| Зүүн бүс           | 4 956         | 1 103                              | 22.3                                |
| <b>Аймгийн дүн</b> | <b>37 378</b> | <b>7 842</b>                       | <b>21.0</b>                         |
| Улаанбаатар        | 40 425        | 11 888                             | 29.4                                |
| <b>Улсын дүн</b>   | <b>77 803</b> | <b>19 730</b>                      | <b>25.4</b>                         |

Гэрийн төрөлтийн 296 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 33 тохиолдлоор буюу 11.1 хувиар буурсан бөгөөд гэрийн төрөлтийн 56.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оноос 0.5 хувиар буурсан байна. Эмнэлгийн тусламжгүй төрөлт 139 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор буюу 10.7 хувиар буурсан байна. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хөдөө орон нутгийн харъяат 5 349 эх амаржсан нь өмнөх оноос 78 төрөлтөөр буурсан ба Улаанбаатар хотод бүртгэгдсэн төрөлтийн 13.2 хувийг эзэлж байна.

**Зураг 3.3.3 Улаанбаатар хотод төрсөн хөдөө орон нутгийн харъяат эхчүүд, бодит тоо, 2016 он**

**Хүснэгт 3.3.2 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2016 он**

| Аймгийн нэр        | Нийт төрөлт   | Үүнээс     |             |                                  |                            |                              |                            |                         |                                       |                 |              |
|--------------------|---------------|------------|-------------|----------------------------------|----------------------------|------------------------------|----------------------------|-------------------------|---------------------------------------|-----------------|--------------|
|                    |               | Гэртээ     | БОЭТ-д      | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт | Хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт | Сум ЭМТ, сум дундын эмнэлэгт | Тосгоны эрүүл мэндийн төвд | Их эмчийн ортой салбарт | УБ хотын амаржих газар болон ЭХЭМҮТ-д | Хувийн эмнэлэгт | Бусад газарт |
| Архангай           | 1 951         | 1          | 0           | 1 403                            | 0                          | 547                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Баян-Өлгий         | 2 838         | 11         | 0           | 2 183                            | 0                          | 640                          | 4                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Баянхонгор         | 1 960         | 7          | 0           | 1 713                            | 0                          | 237                          | 3                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Булган             | 868           | 3          | 0           | 683                              | 0                          | 174                          | 8                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Говь-Алтай         | 1 176         | 4          | 0           | 1 063                            | 0                          | 106                          | 3                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Говьсүмбэр         | 446           | 1          | 0           | 444                              | 0                          | 1                            | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Дархан-Уул         | 2 476         | 8          | 0           | 2 461                            | 0                          | 7                            | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Дорноговь          | 1 426         | 4          | 0           | 1 144                            | 258                        | 20                           | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Дорнод             | 2 067         | 11         | 1987        | 0                                | 0                          | 69                           | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Дундговь           | 955           | 8          | 0           | 816                              | 0                          | 131                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Завхан             | 1 413         | 1          | 0           | 842                              | 331                        | 239                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Орхон              | 2 598         | 2          | 2593        | 0                                | 0                          | 3                            | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Өвөрхангай         | 2 664         | 11         | 1917        | 0                                | 283                        | 439                          | 0                          | 1                       | 0                                     | 13              | 0            |
| Өмнөговь           | 1 401         | 4          | 1178        | 0                                | 0                          | 219                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Сүхбаатар          | 1 251         | 4          | 0           | 1 201                            | 0                          | 46                           | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Сэлэнгэ            | 1 826         | 2          | 0           | 971                              | 617                        | 192                          | 44                         | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Төв                | 1 226         | 9          | 0           | 928                              | 0                          | 289                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Увс                | 2 027         | 13         | 0           | 1 603                            | 0                          | 411                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Ховд               | 2 208         | 7          | 1803        | 0                                | 164                        | 234                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Хөвсгөл            | 2 963         | 15         | 0           | 2 323                            | 0                          | 625                          | 0                          | 0                       | 0                                     | 0               | 0            |
| Хэнтий             | 1 638         | 4          | 0           | 1 285                            | 122                        | 225                          | 0                          | 2                       | 0                                     | 0               | 0            |
| <b>Аймгийн дүн</b> | <b>37 378</b> | <b>130</b> | <b>9478</b> | <b>21 063</b>                    | <b>1 775</b>               | <b>4 854</b>                 | <b>62</b>                  | <b>3</b>                | <b>0</b>                              | <b>13</b>       | <b>0</b>     |
| Улаанбаатар        | 40 425        | 166        | 0           | 1 451                            | 0                          | 0                            | 6                          | 0                       | 37 150                                | 1 637           | 15           |
| <b>Улсын дүн</b>   | <b>77 803</b> | <b>296</b> | <b>9478</b> | <b>22 514</b>                    | <b>1 775</b>               | <b>4 854</b>                 | <b>68</b>                  | <b>3</b>                | <b>37 150</b>                         | <b>1 650</b>    | <b>15</b>    |

**Хүснэгт 3.3.3. Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2016 он**

| Насны бүлэг | Тухайн насны эмэгтэйчүүдийн тоо | Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо | Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент |
|-------------|---------------------------------|-----------------------------------------------------------------|---------------------------------------|
| 20 хүртэлх  | 178 480                         | 3 896                                                           | 21.8                                  |
| 20-24       | 124 857                         | 20 198                                                          | 161.8                                 |
| 25-29       | 153 050                         | 25 128                                                          | 164.2                                 |
| 30-34       | 135 616                         | 16 984                                                          | 125.2                                 |
| 35-39       | 118 049                         | 9 621                                                           | 81.5                                  |
| 40-44       | 202 810                         | 2 367                                                           | 11.7                                  |
| 40-өөс дээш | 90 784                          | 74                                                              | 0.8                                   |

Төрөлтийн нийлбэр коэффициент 3.1 байгаа ба 20-24 насны 1 000 эмэгтэй тутмын 161.8 нь, 25-29 насны 1 000 эмэгтэй тутмын 164.2 нь хүүхэд төрүүлж байгаа нь насны бүлэг дотроо өндөр үзүүлэлттэй байна.

**3.4. ТӨРСНИЙ ДАРААХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

2016 онд хяналтад байж төрсөн эхчүүдийн 92.1 хувь нь төрсний дараа 42 хоногийн дотор идэвхтэй хяналтад хамрагдсан ба өмнөх онтой харьцуулахад 7.7 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой юм.

2016 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 62 882 тохиолдол бүртгэгдэж 1 000 амьд төрөлтөд 804.2 ногдож байна.

Нийт хүндрэл дотор :

- Жирэмсэн үеийн хүндрэл 37.8 хувь

- Төрөх үеийн хүндрэл 52.5 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл 2.1 хувь
- Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 7.5 хувийг тус тус эзэлж байна.


**Зураг 3.4.1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн хувь, эрүүл мэндийн байгууллагаар, 2016 он**



2016 онд төрөлхийн тэмбүүгийн нийт 42 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 10 тохиолдлоор буурсан байна. Улаанбаатар хотод 25, Баян-Өлгий аймагт 2, Баянхонгор аймагт 1, Дорнод аймагт 1, Орхон аймагт 4, Өмнөговь аймагт 1, Сүхбаатар аймагт 1, Төв аймагт 4, Увс аймагт 1, Ховд аймагт 1, Хэнтий аймагт 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдэд БЗДХ өвчин болон төрөлх тэмбүүгийн тохиолдол нэмэгдэж байгаа нь жирэмсэн эмэгтэйд тэмбүү өвчнийг эрт оношлох, стандартын дагуу эмчлэх, эмчилгээний чанарыг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.

**Зураг 3.4.2. Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь, 2016 он**




Жирэмсний хүндрэлд манас таталтын эзлэх хувь Баянхонгор 42.8, Увс 92.9, Завхан 87.1, Сүхбаатар 65.0, Сэлэнгэ 53.0, Увс 86.9, Дархан-Уул 60.6, Булган 79.3 байгаа нь улсын дунджаас 1.7-3.7 дахин өндөр, Баян-Өлгий 9.2, Говь-Алтай 4.9, Орхон 5.6, Өмнөговь 7.6 байгаа нь аймгийн дунджаас 2.7-5.1 дахин бага байна.

Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 24.9 хувь, манас таталт 0.2 хувь, төрөх




үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 34.6 хувь, төрсний дараах хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 80.2 хувьтай тус тус тэргүүлж байна.

**Зураг 3.4.3. Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, 2016 он**



Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын хувь Архангай 60.0, Говьсүмбэр 57.1, Дорноговь 43.7, Өвөрхангай 58.2, Сэлэнгэ 47.3, Увс 72.4, Ховд 52.0, Хөвсгөл 74.2 байгаа нь улсын дунджаас 1.3-2.1 дахин өндөр байна.

**Зураг 3.4.4. Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, 2016 он**




### 3.5. ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

Манай улсад эхийн эндэгдэл 1990 оны түвшингээс 4.1 дахин буурч, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрээд байна.

2016 оны байдлаар эхийн эндэгдлийн 38 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 48.6 байгаа нь 2015 оноос 17 тохиолдлоор буюу 44.7 хувиар, 100 000 амьд төрөлт тутамд 22.6 эндэгдлээр өссөн байна.

Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Увс, Хэнтий зэрэг аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Эхийн эндэгдлийн 78.9 хувь нь эмнэлэгт, 21.1 хувь нь гэртээ эндсэн байна.

**Зураг 3.5.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2016 он**

Эндсэн эхчүүдийг боловсролоор нь авч үзвэл: 31.5 хувь нь дээд, 55.3 хувь нь дунд, 13.2 хувь нь бага боловсролтой ба 31.6 хувь нь ажил эрхэлдэг, 26.3 хувь нь малчин, 5.3 хувь нь оюутан, 36.8 хувь нь ажил эрхэлдэггүй байна.

Эхийн эндэгдлийг эмнэлгийн төрлөөр нь авч үзвэл 2.6 хувь нь дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд, 15.8 хувь нь сум, сум дундын болон хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт, 23.8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 10.5 хувь нь нийслэлийн амаржих газарт, 15.8 хувь нь Бүсийн оношлогоо, эмчилгээний төвд, 10.5 хувь нь ХӨСҮТ, УНТЭ, УХТН, ГССҮТ-д, 10.5 хувь нь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд, 10.5 хувь нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд тус тус бүртгэгдсэн байна.


Эндсэн эхчүүдийн 31.6 хувь нь жирэмсэн үеийн хүндрэл, 2.6 хувь нь төрөх үеийн хүндрэлээс, 31.6 хувь нь төрсний дараах хүндрэлээс, 34.2 хувь нь жирэмсэн болон төрөхөөс бусад өвчний улмаас эндсэн байна. Энэ үзүүлэлтээс харахад өмнөх оноос жирэмсэн болон төрөхөөс бусад өвчний хүндрэл 8.7, төрөх үеийн хүндрэл 6.9 хувиар буурч, жирэмсэн үеийн хүндрэл 3.0, төрсний дараах хүндрэл 12.6 хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 3.5.1. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2016 он**

| Насны бүлэг | Эндсэн эхийн тоо | Эзлэх хувь | Амьд төрүүлсэн хүүхдийн тоо | 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин |
|-------------|------------------|------------|-----------------------------|------------------------------------------------------|
| 20 хүртэлх  | 1                | 2.6        | 3 896                       | 25.7                                                 |
| 20-24       | 2                | 5.3        | 20 198                      | 9.9                                                  |
| 25-29       | 10               | 26.3       | 25 128                      | 39.8                                                 |
| 30-34       | 14               | 36.8       | 16 984                      | 82.4                                                 |
| 35-39       | 9                | 23.7       | 9 621                       | 93.5                                                 |
| 40-өөс дээш | 2                | 5.3        | 2 367                       | 84.5                                                 |

Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд насны бүлгээр авч үзэхэд 30-34 насанд 82.4, 35-39 насанд 93.5, 40-44 насанд 88.2 байгаа нь улсын дунджаас 33.8-44.9 тохиолдлоор өндөр байна.

Зураг 3.5.2. Эхийн эндэгдэл, бүсээр, 100 000 амьд төрөлтөд, сүүлийн 3 жилээр



Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд бүс нутгаар авч үзвэл төвийн болон хангайн бүсэд улсын дунджаас 20.3-22.9 тохиолдлоор их, харин Улаанбаатар болон зүүн, баруун бүсэд улсын дунджаас 3.3-17.7 тохиолдлоор бага байна. 2016 онд төвийн ба хангайн бүсэд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд 68.9-71.5 болж өмнөх оны түвшнээс 40.0-49.7 тохиолдлоор нэмэгдсэн байна.

### 3.6. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөж торних үндэс болдог.

Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96.1 байгаа ба Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ аймгууд улсын дунджаас 5.8-9.0 хувиар доогуур үзүүлэлттэй байна.


Хүснэгт 3.6.1 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2016 он

| Бүсээр             | Төрсөн хүүхэд |               |               | Нийт төрөлтөд           |                                 |                                               |
|--------------------|---------------|---------------|---------------|-------------------------|---------------------------------|-----------------------------------------------|
|                    | Бүгд          | Эрэгтэй       | Эмэгтэй       | Хүйсийн харьцаа /100-д/ | Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь | Амьгүй төрөлтийн түвшин /1 000 нийт төрөлтөд/ |
| Баруун бүс         | 9 688         | 5 031         | 4 657         | 108.0                   | 4.5                             | 7.4                                           |
| Төвийн бүс         | 9 788         | 5 030         | 4 758         | 105.7                   | 3.4                             | 5.3                                           |
| Хангайн бүс        | 13 055        | 6 680         | 6 375         | 104.8                   | 4.5                             | 5.4                                           |
| Зүүн бүс           | 4 976         | 2 552         | 2 424         | 105.3                   | 3.1                             | 5.0                                           |
| <b>Аймгийн дүн</b> | <b>37 507</b> | <b>19 293</b> | <b>18 214</b> | <b>105.9</b>            | <b>4.0</b>                      | <b>5.9</b>                                    |
| Улаанбаатар        | 40 687        | 20 917        | 19 770        | 105.8                   | 4.5                             | 6.5                                           |
| <b>Улсын дүн</b>   | <b>78 194</b> | <b>40 210</b> | <b>37 984</b> | <b>105.9</b>            | <b>4.3</b>                      | <b>6.2</b>                                    |

Улсын хэмжээнд 78 194 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 2 681 хүүхдээр буюу 3.4 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.3 хувь нь 2 500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдийн 1 681 нь хоёр ихэр, 27 нь гурван ихэр хүүхэд байна.

Амьгүй төрөлтийн 484 тохиолдол бүртгэгдсэн нь 1 000 нийт төрөлтөд 6.2 байгаа ба өмнөх онтой харьцуулахад 73 тохиолдлоор буюу 15.0 хувиар буурсан байна.


**Зураг 3.6.1. Амьгүй төрөлтийн түвшин, 1000 нийт төрөлтөд, аймгаар, 2016 он**



Амьгүй төрөлтийн түвшин Баян-Өлгий, Дундговь, Төв аймагт 1 000 нийт төрөлтөд 7.3-12.3 байгаа нь улсын дунджаас 1.1-6.1 тохиолдлоор өндөр байна. Амьгүй төрөлтийн түвшин Дундговь, Төв аймагт 7.3-12.3 байгаа нь бүсийн дунджаас 2-7 тохиолдлоор өндөр үзүүлэлтэй байна. Зүүн болон Төвийн бүсийн амьгүй төрөлтийн түвшин улс, аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Амьгүй төрөлтөд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 52.9 байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 105.9 байна.

Нийт амьд төрөлтийн 0.7 хувьд нь төрөлхийн гажгийн тохиолдол бүртгэгдсэн байна. Төрөлхийн гажгийн тохиолдлын түвшин 1 000 нийт төрөлтөд 6.5 ногдож байна. 2016 онд нэг хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь 94.2, тав хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь 82.5 байна. Нярай хүүхдийн өвчлөлийн 17 169 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь амьд төрсөн хүүхдийн 22.0 хувийг эзэлж байна.

**Зураг 3.6.2. Нярай хүүхдийн өвчлөл, амьд төрсөн хүүхдэд эзлэх хувиар, 2016 он**



### Хүснэгт 3.6.2. Нярай хүүхдийн өвчлөл, бодит тоогоор, 2016 он

|             | Нярай хүүхдийн өвчлөл бүгд | Перинаталь үед үүссэн зарим эмгэг | Халдварт ба шимэгчит өвчин |                          | Амьсгалын тогтолцооны өвчин |                        | Хоол шингээх эрхтний эмгэг |                                     | Төрөлхийн гажиг, гаж хөгжил | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант эмгэг | Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан | Бусад өвчин |
|-------------|----------------------------|-----------------------------------|----------------------------|--------------------------|-----------------------------|------------------------|----------------------------|-------------------------------------|-----------------------------|-------------------------------------------|---------------------------------------|-------------|
|             |                            |                                   | Бүгд                       | Үүнээс: Төрөлхийн тэмбүү | Бүгд                        | Үүнээс: Уушгины хатгаа | Бүгд                       | Үүнээс: Халдварт бус суулгалт өвчин |                             |                                           |                                       |             |
| Аймгийн дүн | 8 704                      | 6 208                             | 109                        | 16                       | 1189                        | 445                    | 129                        | 95                                  | 231                         | 4                                         | 0                                     | 824         |
| Улаанбаатар | 8 465                      | 7 432                             | 18                         | 15                       | 297                         | 76                     | 67                         | 5                                   | 351                         | 7                                         | 0                                     | 261         |
| Улсын дүн   | 17 169                     | 13 640                            | 127                        | 31                       | 1486                        | 521                    | 196                        | 100                                 | 582                         | 11                                        | 0                                     | 1085        |

Перинаталь үед үүссэн зарим эмгэг дотор төрөхөд ураг бүтэх 9.8 хувь, нярайн шарлалт 36.4 хувийг эзэлж байна.

Нэг хүртэлх насны хүүхдэд бүртгэгдсэн төрөлхийн гажгийн 978 тохиолдлоос зүрх, цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг 34.9 хувь, сэтэрхий уруул ба тагнай 15.1 хувь, хоол боловсруулах тогтолцооны төрөлхийн гажиг 13.9 хувь, түнхний төрөлхийн гажиг 14.2 хувьтай тэргүүлэх байрыг эзэлж байна.

### Хүснэгт 3.6.3 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, хувиар / хот, хөдөө/, 2016 он

|                                                          | 1 хүртэлх насны |       | 5 хүртэлх насны |       |
|----------------------------------------------------------|-----------------|-------|-----------------|-------|
|                                                          | Хот             | Хөдөө | Хот             | Хөдөө |
| Амьсгалын тогтолцооны өвчин                              | 54.3            | 63.9  | 57.5            | 68.8  |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин                      | 9.9             | 9.7   | 8.7             | 12.6  |
| Перинаталь үед үүссэн зарим эмгэг                        | 7.9             | 3.7   | 4.0             | 2.3   |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 1.9             | 0.7   | 7.0             | 1.9   |
| Халдварт ба шимэгчит зарим өвчин                         | 12.6            | 7.9   | 7.6             | 3.3   |
| Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин                      | 4.9             | 3.7   | 9.6             | 4.8   |

- Тэргүүлэх шалтгаан
- Хоёрдугаар шалтгаан
- Гуравдугаар шалтгаан

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлд амьсгалын тогтолцооны өвчин хот, хөдөөд адил тэргүүлэх шалтгаан болж байна. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 27.5 хувь, амьсгалын дээд замын халдвар 18.2 хувь, томуу, томуу төст өвчлөл 11.6 хувийг тус тус эзэлж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн дийлэнх буюу 56.7 хувийг халдварт бус суулгалт өвчин эзэлж байна.

### Хүснэгт 3.6.4. Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, /тухайн насны 10 000 хүүхдэд/, 2016 он

|                                                          | 1-4 нас | 5-9 нас | 10-14 нас | 15-19 нас |
|----------------------------------------------------------|---------|---------|-----------|-----------|
| Амьсгалын тогтолцооны өвчин                              | 5 839.3 | 1 653.3 | 1 162.4   | 798.6     |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин                      | 990.0   | 1 058.0 | 859.2     | 890.6     |
| Халдварт ба шимэгчит зарим өвчин                         | 490.7   | 201.1   | 211.4     | 448.2     |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 396.9   | 313.8   | 408.8     | 434.8     |
| Шээс бэлгийн тогтолцооны өвчин                           | 102.0   | 123.1   | 191.9     | 442.8     |
| Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин                      | 650.6   | 386.2   | 413.5     | 525.1     |

- Тэргүүлэх шалтгаан
- Хоёрдугаар шалтгаан
- Гуравдугаар шалтгаан

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл ба гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, арьс арьсан доорх эслэгийн өвчлөл, шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, халдварт ба шимэгчит зарим өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

2016 онд 10-14 болон 15-19 насны хүүхдийн осол гэмтлийн өвчлөл өмнөх оноос тухайн насны 10 000 хүүхэд тутамд 57.5-60.9 тохиолдлоор тус тус буурсан байна. Харин хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 1-4, 5-9, 15-19 насны бүлэг тус бүрд 32.7-69 тохиолдлоор нэмэгдсэн байна. 1-4 насны 10 000 хүүхдэд ногдох өвчлөлд халдварт бус суулгалт 443.3, шүдний цооролт 222.0, шүд ба дайврын эмгэг 140.3 байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна. Харин 5-9 насны хүүхдийн өвчлөлд тухайн насны 10 000 хүүхдэд шүдний цооролт өвчин 396.5, шүд ба дайврын эмгэгийн өвчин 397.2 байгаа нь тэргүүлэх шалтгаан болж байна.

### 3.7. НЯЛХАС БОЛОН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2016 оны байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдлийн 1 315 тохиолдол бүртгэгдэж, 1 000 амьд төрөлтөд 16.8 ногдож байгаа нь өмнөх оноос 1.5-оор өссөн байна. Нялхсын эндэгдлийн 54.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1 000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 9.2 байна. Нярайн эндэгдлийн нийт 721 тохиолдол бүртгэгдсэний 528 буюу 73.2 хувь нь нярайн эрт үед /амьдралын эхний 0-6 хоногт/, 193 буюу 26.8 хувь нь нярайн хожуу үед /амьдралын эхний 7-28 хоногт/ эндсэн байна.

Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 56.9 хувь нь эрэгтэй, 43.1 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Харин тав хүртэлх насандаа 1 628 хүүхэд эндсэн бөгөөд амьд төрсөн 1 000 хүүхдэд ногдох түвшин 20.8 байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 152 тохиолдлоор илүү буюу амьд төрсөн 1 000 хүүхдэд ногдох эндэгдэл 2.5 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. 1 000 амьд төрсөн эрэгтэй хүүхдэд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 23.0, 1 000 амьд төрсөн эмэгтэй хүүхдэд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18.5 байна.

1 000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Архангай /27.6/, Баян-Өлгий /32.1/, Баянхонгор /30.0/, Өвөрхангай /28.4/, Сүхбаатар /27.7/, Төв /30.4/, Увс /27.0/, Хөвсгөл /32.4/ аймгуудад улсын дунджаас 6.2-11.6 тохиолдлоор өндөр байна.

#### Хүснэгт 3.7.1. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нас, хүйсээр, 2016 он

|                                   | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд   |
|-----------------------------------|---------|---------|--------|
| Нярайн эрт үеийн эндэгдэл         | 303     | 225     | 528    |
| Нярайн хожуу үеийн эндэгдэл       | 121     | 72      | 193    |
| Нярайн эндэгдэл                   | 424     | 297     | 721    |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 926     | 702     | 1 628  |
| Амьд төрсөн хүүхдийн тоо          | 40 210  | 37 984  | 78 194 |

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд хот болон хөдөөд перинаталь үед үүссэн зарим эмгэг тэргүүлэх шалтгаан болж байна.

#### Хүснэгт 3.7.2. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаан, хувиар /хот, хөдөө/, 2016 он

|                                                          | 1 хүртэлх насны |       | 5 хүртэлх насны |       |
|----------------------------------------------------------|-----------------|-------|-----------------|-------|
|                                                          | Хот             | Хөдөө | Хот             | Хөдөө |
| Амьсгалын тогтолцооны өвчин                              | 9.2             | 12.1  | 1.4             | 0.6   |
| Мэдрэлийн тогтолцооны өвчин                              | 11.6            | 20.6  | 3.6             | 3.8   |
| Перинаталь үед үүссэн зарим эмгэг                        | 49.1            | 40.2  | 40.0            | 31.9  |
| Төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг          | 17.5            | 8.2   | 1.4             | 1.5   |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг | 4.3             | 7.1   | 6.6             | 9.6   |

- Тэргүүлэх шалтгаан
- Хоёрдугаар шалтгаан
- Гуравдугаар шалтгаан

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 86.7 хувь нь өвчнөөр, 13.3 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн бөгөөд 75.2 хувь нь эмнэлэгт, 19.5 хувь нь гэртээ, 5.3 хувь нь бусад газар эндсэн байна. Энэ нь тав хүртэлх настай хүүхдийн идэвхтэй хяналт болон эцэг эхчүүдийн хараа хяналт, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зэрэгт анхаарах хэрэгтэйг харуулж байна.



### 3.8. ҮР ХӨНДӨЛТ

2016 оны байдлаар үр хөндөлтийн 18 316 тохиолдол бүртгэгдэж, 1 000 амьд төрөлтөд 234.2, нөхөн үржихүйн насны 1 000 эмэгтэйд 21.5 үр хөндөлт ногдож байна. Үр хөндөлт өмнөх оноос 148 тохиолдлоор буюу 0.8 хувиар өссөн ба 1 000 амьд төрөлт тутамд 9.6 тохиолдлоор өссөн байна. 1 000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт Өмнөговь /301.6/, Дорноговь /416.4/, Орхон /295.0/ зэрэг аймгууд болон Улаанбаатар хотод /339.3/ байгаа нь улсын дунджаас 60.8-182.2 тохиолдлоор өндөр байна. Мөн хувийн эмнэлэгт хийгдсэн үр хөндөлт өмнөх оноос 1 166 тохиолдлоор буюу 28.3 хувиар өссөн байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 1 000 амьд төрөлтөд 7.7 байна.

Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 20-иос доош насных 5.0 хувь, 20-34 насных 70.7 хувь, 35-аас дээш насны эмэгтэйчүүд 24.3 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 20-иос доош насны үр хөндөлтийн түвшин 0.1 хувиар буурсан байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 18.0 хувь нь төрөөгүй ба анхны удаа үр хөндүүлсэн тоо өмнөх оноос 14 тохиолдлоор буюу 0.9 хувиар өссөн байна. Үр хөндөлтийн хүндрэл 41 тохиолдол бүртгэгдсэн ба нийт хүндрэлийн 29.3 хувийг умайн агшилт суларч цус алдсан, 56.1 хувийг умайн дайврын үрэвсэл, 4.9 хувийг умай цоорсон хүндрэл эзэлж байна.

#### Хүснэгт 3.8.1. Үр хөндөлт, байршлаар, 2016 он

| №  | Эрүүл мэндийн байгууллага              | Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо | Эзлэх хувь   |
|----|----------------------------------------|-------------------------------|--------------|
| 1  | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | 2 215                         | 12.1         |
| 2  | Амаржих газрууд                        | 8 158                         | 44.5         |
| 3  | Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв    | 68                            | 0.4          |
| 4  | Хувийн эмнэлэг                         | 4 112                         | 22.5         |
| 5  | Бүсийн оношлогоо эмчилгээний төв       | 1 480                         | 8.1          |
| 6  | Аймгийн нэгдсэн эмнэлэг                | 2 195                         | 12.0         |
| 7  | Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг              | 55                            | 0.3          |
| 8  | Сум дундын эмнэлэг                     | 13                            | 0.1          |
| 9  | Тосгоны эрүүл мэндийн төв              | 0                             | 0.0          |
| 10 | Сумын эрүүл мэндийн төв                | 20                            | 0.1          |
| 11 | Бусад эмнэлэг                          | 0                             | 0.0          |
|    | <b>Бүгд</b>                            | <b>18 316</b>                 | <b>100.0</b> |

### 3.9. ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГЫН ХЭРЭГЛЭЭ / ЖСАХ/

Нөхөн үржихүйн насны 1 000 эмэгтэйн 540 нь, 15-49 насны эмэгтэйчүүдийн 54.0 хувь нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг байна.

Жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээг төрлөөр нь авч үзэхэд бэлгэвч 27.7, ерөндөг 27.5, бэлдмэл /эм/ 20.9, тариа 11.6, бусад 8.4, суулгац/норплант/ 2.3, стерилизаци 1.6 хувийг тус тус эзэлж байна. 2010 оны “Хүүхэд хөгжил 2010” судалгаагаар 15-49 насны гэрлэсэн болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд бараг бүгд ЖСАХ-ний талаар мэддэг боловч талаас дөнгөж илүү хувь нь (55 хувь) судалгааны үед жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байгаа гэсэн үр дүн гарсан байна. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэж байсан эмэгтэйчүүдийн 16.6 хувь хэрэглэхээ больж 1.1 хувь нь жирэмсэлсэн байна.

#### Хүснэгт 3.9.1. ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо, байршлаар, 2016 он

| № | Байршил         | ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо | Эзлэх хувь   |
|---|-----------------|-----------------------------------------|--------------|
| 1 | Улаанбаатар хот | 215 106                                 | 46.9         |
| 2 | Аймгийн төв     | 107 791                                 | 23.5         |
| 3 | Сумын төв       | 80 692                                  | 17.6         |
| 4 | Баг             | 55 533                                  | 12.0         |
|   | <b>Бүгд</b>     | <b>459 122</b>                          | <b>100.0</b> |



## БҮЛЭГ 4.

ЭМНЭЛГИЙН  
ТУСЛАМЖ  
ҮЙЛЧИЛГЭЭ



## БҮЛЭГ 4.

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн онцгой ивээлд нэгдсэн зохицуулалттай байж, тусламж үйлчилгээг үзүүлэхдээ төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг харилцан ашигтай, шудрага, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тэгш хүртээмжтэй байхад чиглэнэ.

Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандарттай харьцуулан дүгнэхийг хичээсэн бөгөөд манай улсын эмнэлгийн тусламж үйлчилгээ нь анхан болон лавлагаа шатлалтай бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд баримтлах зарчим нь үйлчилгээг хүн бүрт жигд, хүртээмжтэй чанартай үзүүлэх явдал юм.

Монгол улсын хүн амд Өрхийн эрүүл мэндийн төв, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлэг, Клиник, Амаржих газар, Нийгмийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сувилал, Түргэн тусламжийн төв, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

2016 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 3 500 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 13, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв 12, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сум дундын эмнэлэг 39, сумын эрүүл мэндийн төв 273, өрхийн эрүүл мэндийн төв 220, хувийн ортой эмнэлэг 234, үүдэн эмнэлэг 1 076 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

**Хүснэгт 4.1. Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2016 он**

| Эрүүл мэндийн байгууллагууд                 | 2015         | 2016         |
|---------------------------------------------|--------------|--------------|
| Өрхийн эрүүл мэндийн төв                    | 218          | 220          |
| Сум/ тосгоны эрүүл мэндийн төв              | 272/19       | 273/19       |
| Сум дундын эмнэлэг                          | 39           | 39           |
| Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв | 12           | 12           |
| Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг                   | 6            | 6            |
| Аймгийн нэгдсэн эмнэлэг                     | 16           | 16           |
| Бүсийн оношлогоо эмчилгээний төв            | 5            | 5            |
| Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд       | 13           | 13           |
| Амаржих газрууд                             | 3            | 3            |
| Ортой хувийн эмнэлэг                        | 224          | 234          |
| Үүдэн хувийн эмнэлэг                        | 1 006        | 1 076        |
| Аршаан сувилал, сувилал                     | 105          | 115          |
| Эм ханган нийлүүлэх байгууллага             | 210          | 289          |
| Эмийн үйлдвэр                               | 33           | 39           |
| Хувийн эмийн сан                            | 967          | 1041         |
| Бусад                                       | 96           | 100          |
| <b>Бүгд</b>                                 | <b>3 244</b> | <b>3 500</b> |

**4.1. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-2”-ийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ.

2016 оны байдлаар 220 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 сая 418.4 мянган хүн амд 133 өрхийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн төвийн 703.8 мянган хүн амд 87 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.


**Хүснэгт 4.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2014-2016 он**

| Үзүүлэлт                                                         | 2014      |           |           | 2015      |           |           | 2016      |           |           |
|------------------------------------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
|                                                                  | УБ хот    | Аймаг     | Нийт дүн  | УБ хот    | Аймаг     | Нийт дүн  | УБ хот    | Аймаг     | Нийт дүн  |
| Эмнэлгийн тоо                                                    | 129       | 89        | 218       | 129       | 89        | 218       | 133       | 87        | 220       |
| Их эмчийн тоо                                                    | 663       | 319       | 982       | 622       | 329       | 951       | 633       | 335       | 968       |
| Сувилагчийн тоо                                                  | 561       | 308       | 869       | 577       | 320       | 897       | 586       | 306       | 892       |
| Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо                                 | 3 972 397 | 1 953 155 | 5 925 552 | 4 033 462 | 1 799 545 | 5 833 007 | 4 188 116 | 1 909 237 | 6 097 353 |
| Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь | 42.2      | 35.0      | 39.8      | 43.0      | 37.1      | 41.2      | 43.7      | 37.4      | 41.7      |
| Нэг иргэний жилд үзүүлсэн удаа                                   | 3.0       | 3.1       | 3.0       | 2.9       | 2.6       | 2.8       | 3.0       | 2.7       | 2.9       |
| Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо                             | 5 991.5   | 6 122.7   | 6 034.2   | 6 484.7   | 5 469.7   | 6 133.6   | 6 616.3   | 5 699.2   | 6 298.9   |
| Жирэмсний эрт үеийн хяналтын хувь                                | 85.3      | 84.7      | 85.1      | 84.0      | 82.3      | 83.6      | 84.9      | 81.3      | 83.1      |

220 өрхийн эрүүл мэндийн төвд их эмч 968, сувилагч 892 болон нийт 2674 эмч, эмнэлгийн ажиллагчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад 1 800-2 000 хүн тутамд 1 их эмч ажиллана гэж заасан хэдий ч 2016 оны байдлаар улсын хэмжээнд 1 өрхийн эмчид 2 192 хүн ногдож байна. Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд, Хэнтий аймагт нэг их эмчид ногдох хүний тоо стандартад заасан хэмжээнд байгаа бусад аймгуудад стандартын хэмжээнээс өндөр байна.

2016 онд өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд жилд дунджаар 6.0 сая үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 2.9 удаа өрхийн эрүүл мэндийн төвд хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна. Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 41.7 байгаа ба УБ хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 43.7 хувь, харин аймгийн өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 37.4 хувь байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь өмнөх оноос 0.5 хувиар нэмэгдсэн байна. “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30 хувиас доошгүй байна гэж заасан хэдий ч 2016 оны байдлаар өмнөх оны түвшинд буюу 27.4 хувь байгаа ба өмнөх оноос 0.9 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 4.1.1** Өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгийн тоо, /сүүлийн 5 жилээр/



Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 2005 онд 3.0 сая үзлэг хийгдэж байсан бол 2007 онд 3.9 сая, 2016 онд 4.2 сая үзлэг хийгдсэн байна. Жилд нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо Улаанбаатар хотод 6 616, аймгийн түвшинд 5 699 байна.

## 4.2. СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БОЛОН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харъяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно.

Сум дундын эмнэлэг нь хүн амын суурьшил, нягтралаас хамааран харъяаллын болон зэргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2013 онд батлагдсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-аар сумын эрүүл мэндийн төвүүд нь аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилна.


Нэгдүгээр зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ийн дотор үйлчлэх хүрээний хүн ам 3 000 хүртэл, хоёрдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50-99 км-ийн дотор болон 1-2 цаг хүртэлх хугацаанд зорчих сумын эрүүл мэндийн төв, гуравдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 100 км-ээс алс, сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэг хамаарна гэж заасан.

Гэвч сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ээс дотогш боловч үйлчлэх хүрээний хүн амын тоо 3000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан бол хоёрдугаар зэрэглэлд, 100 км-ээс дотогш боловч хүн амын тоо 8000-аас дээш бол гуравдугаар зэрэглэлд хамааруулна гэж заасан.

**Хүснэгт 4.2.1** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2016 он

| Зэрэглэл           | Эмнэлгийн тоо | Эмчийн тоо (дундаж) | Стандартын түвшинд |      | Стандартаас доогуур |      |
|--------------------|---------------|---------------------|--------------------|------|---------------------|------|
|                    |               |                     | тоо                | Хувь | Тоо                 | Хувь |
| I зэрэглэл         | 21            | 2.1                 | 17                 | 81.0 | 4                   | 19.0 |
| II зэрэглэл        | 82            | 2.1                 | 42                 | 51.2 | 40                  | 48.8 |
| III зэрэглэл       | 170           | 2.9                 | 131                | 77.1 | 39                  | 22.9 |
| Сум дундын эмнэлэг | 39            | 5.5                 | 6                  | 15.4 | 33                  | 84.6 |

**Зураг 4.2.1** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн дундаж тоо, 2016 он




**Хүснэгт 4.2.2** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд, 2014, 2016 он

| Үзүүлэлт                                                         | 2014 он       |                    | Нийт дүн  | 2016 он       |                    | Нийт дүн  |
|------------------------------------------------------------------|---------------|--------------------|-----------|---------------|--------------------|-----------|
|                                                                  | Сумын эмнэлэг | Сум дундын эмнэлэг |           | Сумын эмнэлэг | Сум дундын эмнэлэг |           |
| Эмнэлгийн орны тоо                                               | 2 592         | 628                | 3 220     | 2 832         | 718                | 3 550     |
| Их эмчийн тоо                                                    | 616           | 215                | 831       | 731           | 244                | 975       |
| Сувилагчийн тоо                                                  | 1436          | 273                | 1709      | 1448          | 286                | 1734      |
| Дундаж ор хоног                                                  | 7.1           | 7.3                | 7.2       | 6.7           | 6.7                | 6.7       |
| Хэвтэн эмчлүүлэгчийн тоо                                         | 100 149       | 19 986             | 120 135   | 100 963       | 21 932             | 122 895   |
| Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо                                 | 1 778 900     | 416 248            | 2 195 148 | 1 686 053     | 361 558            | 2 047 611 |
| Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь | 36.0          | 37.6               | 36.3      | 37.3          | 37.2               | 37.3      |
| Жирэмсний эрт үеийн хяналтын хувь                                | 88.4          | 89.7               | 88.6      | 87.0          | 85.7               | 86.8      |
| Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/                           | 0.0           | 0.0                | 0.0       | 114.9         | 71.9               | 102.6     |
| Нялхсын эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/                      | 39.7          | 20.0               | 34.4      | 51.7          | 41.0               | 48.7      |

2016 оны байдлаар эмнэлгийн нийт орны 15.5 хувь нь сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2014 онтой харьцуулбал 330 ороор буюу 10.2 хувиар нэмэгдсэн байна.

Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт жилд 122.9 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна. 2016 онд хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 2014 онтой харьцуулахад сум дундын эмнэлэгт 9.7, сумын эмнэлэгт 0.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

**Зураг 4.2.2** Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2014-2016 он



Дундаж ор хоног 2014 онд 7.2 хоног байсан бол 2016 онд 6.7 болж буурсан байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт нэг иргэний үзүүлсэн дундаж тоо 2014 онд 2.3 байсан бол 2016 онд 2.1 болж буурсан байна.

2016 онд сумын болон сум дундын эмнэлгийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 86.8 болж 2014 оноос 1.8 хувиар буурсан байна.

2016 онд сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт эхийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 102.6 байгаа ба 1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл сумын эрүүл мэндийн төвийн түвшинд 51.7, сум дундын эмнэлгийн түвшинд 41.0 байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин 2014 оноос 14.3-оор нэмэгдсэн байна.

#### 4.3 НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ


Нэгдсэн эмнэлэг нь хүн амд 7-оос доошгүй чиглэл /дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно гэж заасан байдаг.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна. 2016 оны байдлаар 16 аймгийн нэгдсэн эмнэлэгт 1 071 их эмч, 1 723 сувилагч, 641 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 4 946 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 813 их эмч, 889 сувилагч, 310 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 3 072 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 15.7 хувь нь ногдож байгаа бөгөөд 2016 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн орны тоо 3 613 буюу 2014 онтой харьцуулахад 314 ороор нэмэгдсэн байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд нийт орны 9.4 нь хувь ногдож байгаа бөгөөд дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2014 онд 93.4 мянга байсан бол 2016 онд 109.6 мянга болж, 16.2 мянган хүнээр нэмэгдсэн байна.

**Зураг 4.3.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2016 он**



**Хүснэгт 4.3.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2014-2016 он**

| Үзүүлэлт                                                         | 2014 он                 |                          | 2015 он                 |                          | 2016 он                 |                          | Сүүлийн 3 жилийн дундаж |                          |
|------------------------------------------------------------------|-------------------------|--------------------------|-------------------------|--------------------------|-------------------------|--------------------------|-------------------------|--------------------------|
|                                                                  | Аймгийн нэгдсэн эмнэлэг | Дүүргийн нэгдсэн эмнэлэг | Аймгийн нэгдсэн эмнэлэг | Дүүргийн нэгдсэн эмнэлэг | Аймгийн нэгдсэн эмнэлэг | Дүүргийн нэгдсэн эмнэлэг | Аймгийн нэгдсэн эмнэлэг | Дүүргийн нэгдсэн эмнэлэг |
| Эмнэлгийн орны тоо                                               | 3 299                   | 1 918                    | 3 378                   | 2 112                    | 3 613                   | 2 168                    | 3 430                   | 2 066                    |
| Их эмчийн тоо                                                    | 984                     | 816                      | 1 030                   | 795                      | 1 071                   | 813                      | 1 028                   | 808                      |
| Сувилагчийн тоо                                                  | 1 664                   | 856                      | 1725                    | 891                      | 1 723                   | 889                      | 1 704                   | 879                      |
| Дундаж ор хоног                                                  | 7.4                     | 7.1                      | 7.4                     | 7.0                      | 7.3                     | 6.8                      | 7                       | 7                        |
| Хэвтэн эмчлүүлэгчийн тоо                                         | 138 248                 | 93 393                   | 135 033                 | 93 403                   | 142 658                 | 109 579                  | 138 646                 | 98 792                   |
| Хоног болоогүй нас баралтын хувь                                 | 37.5                    | 20.7                     | 32.4                    | 30.9                     | 31.3                    | 25.0                     | 33.7                    | 25.5                     |
| Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо                                 | 1 584 293               | 2 406 930                | 1 558 984               | 2 484 337                | 1 568 529               | 2 382 470                | 1 570 602               | 2 424 579                |
| Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь | 34.1                    | 40.5                     | 31.1                    | 39.3                     | 30.8                    | 36.3                     | 32.0                    | 38.7                     |
| Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)                          | 22.2                    |                          | 16.9                    |                          | 42.5                    |                          | 26.7                    | -                        |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)                      | 11.4                    | -                        | 11.7                    | -                        | 14.1                    | -                        | 12.6                    | -                        |
| Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь                    | 12.9                    | -                        | 13.5                    | -                        | 17.1                    | -                        | 14.7                    | -                        |

2016 оны байдлаар дундаж ор хоног аймгийн нэгдсэн эмнэлэгт 2014 онтой харьцуулахад 0.1-ээр, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 0.3-аар буурсан байна.

2016 онд эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2014 оноос 6.2 хувиар буурч, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 4.3 хувиар нэмэгдсэн байна.

Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2016 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 1.5 сая, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2.3 сая байна. Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2014 оноос 3.3 хувиар, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 4.2 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин 2014 онд 11.4 байсан бол 2016 онд 14.1 болж 2014 онтой харьцуулахад 2.7-оор, сүүлийн 3 жилийн дунджаас 1.5-оор өндөр байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2016 онд 42.5 байгаа нь 2014 онтой харьцуулахад 20.3-оор, сүүлийн 5 жилийн дунджаас 15.8-оор өндөр байна.

Сүүлийн 3 жилд дунджаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 14.7 хувийг хөдөөнөөс буюу сум, сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна. 2016 онд хөдөөнөөс аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж хэвтэн эмчлүүлэгчид өмнөх 2015 онтой харьцуулахад 3.6 хувиар нэмэгдсэн байна.



#### 4.4 БҮСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

2016 оны байдлаар улсын хэмжээнд Орхон, Дорнод, Өвөрхангай, Ховд, Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлгүүд БОЭТ-ийн статусаар үйл ажиллагаа явуулж байгаа ба 449 их эмч, 706 сувилагч, 259 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтан, нийтдээ 1945 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

**Хүснэгт 4.4.1. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2014-2016 он**

| Үзүүлэлт                                      | Онууд   |         |         | Сүүлийн 3 жилийн дундаж |
|-----------------------------------------------|---------|---------|---------|-------------------------|
|                                               | 2014    | 2015    | 2016    |                         |
| Эмнэлгийн орны тоо                            | 1470    | 1484    | 1539    | 1497.7                  |
| Дундаж ор хоног                               | 7.6     | 7.6     | 7.5     | 7.6                     |
| Хоног болоогүй нас баралтын хувь              | 30.1    | 29.0    | 30.0    | 29.7                    |
| Хэвтэн эмчлүүлэгчийн тоо                      | 54 773  | 55 769  | 57 050  | 55 864                  |
| Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо              | 575 205 | 556 035 | 544 285 | 558 508                 |
| Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөнд)       | 31.0    | 20.7    | 62.7    | 38.1                    |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)   | 11.7    | 8.8     | 11.3    | 10.6                    |
| Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь | 27.5    | 28.1    | 26.0    | 27.2                    |

2016 онд Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдэд 57.0 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд, жилд 14 860 хүн сумын болон сум дундын эмнэлэг, бүсийн аймгуудаас ирж хэвтэн эмчлүүлсэн нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 26.0 хувийг эзэлж байна.

БОЭТ-ийн дундаж ор хоног 2016 онд 7.5 байгаа ба сүүлийн 3 жилийн дундажтай адил түвшинд байна. Хоног болоогүй нас баралтын хувь 2016 онд 30.0 байгаа нь сүүлийн 3 жилийн дунджаас 0.3-аар бага байна. Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд нялхсын эндэгдэл тогтвортой бага түвшинд байгаа хандлагын дагуу БОЭТ-ийн 1 000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2014-2016 онд 1 000 амьд төрөлтөд 10.6 байгаа нь аймгийн дунджаас доогуур байна.

2016 онд Бүсийн оношлогоо эмчилгээ төвүүдэд эхийн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 62.7 байгаа ба Өмнөговь 3, Ховд 2, Өвөрхангай 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

**Хүснэгт 4.4.2. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн хүний нөөцийн зарим үзүүлэлт, 2016 он**

| №          | Аймаг      | Нийт ажиллагсад | Их эмч     | Сувилагч   | Эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтан | Орны тоо    |
|------------|------------|-----------------|------------|------------|-----------------------------------------------------------|-------------|
| 1          | Дорнод     | 500             | 101        | 172        | 72                                                        | 336         |
| 2          | Орхон      | 508             | 111        | 202        | 57                                                        | 434         |
| 3          | Өвөрхангай | 337             | 85         | 117        | 52                                                        | 301         |
| 4          | Өмнөговь   | 213             | 55         | 72         | 28                                                        | 210         |
| 5          | Ховд       | 387             | 97         | 143        | 50                                                        | 258         |
| <b>Дүн</b> |            | <b>1945</b>     | <b>449</b> | <b>706</b> | <b>259</b>                                                | <b>1539</b> |



**Хүснэгт 4.4.3.** Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт, 2016 он

| Аймаг      | Хэвтэн эмчлүүлэгчид | Ор хоног       | Дундаж ор хоног | Хоног болоогүй нас баралт | Амбулаторийн үзлэг | "Эхийн эндэгдэл /100000 амьд төрөлтөд/" | "Нялхсын эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/" | "5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/" |
|------------|---------------------|----------------|-----------------|---------------------------|--------------------|-----------------------------------------|-----------------------------------------------|----------------------------------------------------------------|
| Дорнод     | 12 025              | 91 588         | 7.6             | 23.6                      | 107 613            | 0.0                                     | 7.0                                           | 8.5                                                            |
| Орхон      | 15 668              | 115 539        | 7.4             | 47.3                      | 137 396            | 0.0                                     | 12.6                                          | 12.6                                                           |
| Өвөрхангай | 10 396              | 79 412         | 7.6             | 19.7                      | 81 567             | 51.6                                    | 13.4                                          | 13.9                                                           |
| Өмнөговь   | 7 315               | 51 008         | 7.0             | 35.8                      | 93 598             | 252.1                                   | 13.4                                          | 14.3                                                           |
| Ховд       | 11 646              | 88 370         | 7.6             | 22.2                      | 124 110            | 109.8                                   | 10.4                                          | 11.0                                                           |
| <b>Дүн</b> | <b>57 050</b>       | <b>425 917</b> | <b>7.5</b>      | <b>30.0</b>               | <b>544 284</b>     | <b>62.7</b>                             | <b>11.3</b>                                   | <b>11.9</b>                                                    |

#### 4.5 ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Төв эмнэлэг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг лавлагаа мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд тухайн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, лавлагаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна.

2016 оны байдлаар 13 Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдэд 1 217 их эмч, 1 917 сувилагч, 463 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 5 826 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

Нийт эмнэлгийн орны 17.1 хувь нь, мөн хэвтэн эмчлүүлэгчдийн 17.1 хувь нь Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ногдож байна.


Дундаж ор хоног 2014 онд 9.4 байсан бол 2016 онд 8.7 болж буурсан байна. Түүнчлэн эмнэлэгт хоног болоогүй нас баралтын хувь 2014 онд 27.9 байсан бол 2016 онд 20.3 хувь болж буурсан бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж 22.9 хувь байна.

**Хүснэгт 4.5.1.** Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

| Үзүүлэлт                                                  | Онууд     |           |           | Сүүлийн 3 жилийн дундаж |
|-----------------------------------------------------------|-----------|-----------|-----------|-------------------------|
|                                                           | 2014      | 2015      | 2016      |                         |
| Эмнэлгийн орны тоо                                        | 3 818     | 3 837     | 3 937     | 3 864.0                 |
| Их эмчийн тоо                                             | 1 229     | 1 221     | 1 217     | 1 222.3                 |
| Сувилагчийн тоо                                           | 1 879     | 1 912     | 1 917     | 1 902.7                 |
| Дундаж ор хоног                                           | 9.4       | 8.9       | 8.7       | 9.0                     |
| Хоног болоогүй нас баралтын хувь                          | 27.9      | 20.5      | 20.3      | 22.9                    |
| Хэвтэн эмчлүүлэгчийн тоо                                  | 134 088   | 14 1977   | 146 033   | 140 699.3               |
| Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо                          | 1 233 558 | 1 279 401 | 1 285 282 | 1 266 080.3             |
| Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн тоо / хөдөөнөөс/ | 30 355    | 30 520    | 44 040    | 34971.7                 |

Сүүлийн 3 жилд дунджаар Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 140.6 мянган хүн хэвтэн эмчлүүлж байгаагийн 24.9 хувийг хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2014 онтой харьцуулбал 2016 онд нийт хэвтэн эмчлүүлэгчид 8.9 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 4.5.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2016 он**



**Хүснэгт 4.5.2. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны зарим үр дүнгийн үзүүлэлтүүд, 2016 он**

| Эмнэлгүүдийн нэр                             | Амбулаторийн үзлэгийн тоо | Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид | Дундаж ор хоног | Хоног болоогүй нас баралт /хувь/ |
|----------------------------------------------|---------------------------|------------------------------|-----------------|----------------------------------|
| Улсын нэгдүгээр төв эмнэлэг                  | 313 270                   | 22 901                       | 7.1             | 19.5                             |
| Улсын хоёрдугаар төв эмнэлэг                 | 117 843                   | 8 517.5                      | 7.9             | 25.6                             |
| Улсын гуравдугаар төв эмнэлэг                | 165 639                   | 18 539                       | 7.6             | 16.2                             |
| Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв       | 174 354                   | 38 597.5                     | 6.3             | 5.2                              |
| Хавдар судлалын үндэсний төв                 | 101 940                   | 10 260                       | 7.3             | 22.4                             |
| Халдварт өвчин судлалын үндэсний төв         | 135 727                   | 14 104.5                     | 10.0            | 15.5                             |
| Гэмтэл согог судлалын үндэсний төв           | 105 191                   | 14 257                       | 9.9             | 26.7                             |
| Арьсны өвчин судлалын үндэсний төв           | 93 211                    | 5 404                        | 9.4             | 0.0                              |
| Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв         | 38 444                    | 6 277.5                      | 29.3            | 0.0                              |
| Хүүхдийн төв сувилал                         | 259                       | 1 188.5                      | 18.1            | 0.0                              |
| Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн | 18 432                    | 6 126                        | 7.1             | 0.0                              |
| Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн       | 16 616                    | 667.5                        | 0.0             | 0.0                              |
| Геронтологийн үндэсний төв                   | 20 972                    | 0                            | 0.0             | 0.0                              |

## 4.6 ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

2016 оны байдлаар 234 ортой, 1 076 үүдэн хувийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хувийн эмнэлгүүдэд 2 935 их эмч, 2 046 сувилагч, нийт 8 730 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

### Хүснэгт 4.6.1 Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2000-2016 он

|                            | 2000   | 2005      | 2009      | 2010      | 2011      | 2012      | 2013      | 2014      | 2015      | 2016      |
|----------------------------|--------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Ортой эмнэлгийн тоо        | 466    | 160       | 160       | 166       | 171       | 179       | 197       | 202       | 224       | 234       |
| Үүдэн эмнэлгийн тоо        |        | 523       | 922       | 947       | 1 013     | 851       | 822       | 969       | 1 006     | 1 076     |
| Эмнэлгийн орны тоо         | 964    | 1 982     | 2 422     | 2 527     | 3 069     | 3 606     | 3 829     | 4 542     | 5 262     | 5 611     |
| Нийт оронд эзлэх хувь      | 5.4    | 10.8      | 13.6      | 14.2      | 16.2      | 18.4      | 19.3      | 22.1      | 24.2      | 24.4      |
| Эмчийн тоо                 | 736    | 1 145     | 1 396     | 1 549     | 1 677     | 1 904     | 1 965     | 2 368     | 2 698     | 2 935     |
| Сувилагч                   | 296    | 682       | 858       | 1 007     | 1 135     | 1 275     | 1 326     | 1 742     | 1 941     | 2 046     |
| Амбулаторийн үзлэгийн тоо  | -      | 1 016 705 | 1 304 897 | 1 036 934 | 1 986 901 | 1 320 932 | 1 756 769 | 1 786 670 | 1 912 718 | 2 063 450 |
| Эмнэлэгт хэвтсэн хүний тоо | 23 592 | 63 267    | 75 003    | 86 117    | 97 821    | 111 338   | 121 452   | 124 610   | 142 052   | 159 194   |
| Дундаж ор хоног            | 11.3   | 9.0       | 8.1       | 7.9       | 8.2       | 7.7       | 7.4       | 7.3       | 7.0       | 7.2       |

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн орны тоо 2005 онд 1 982 байсан бол 2016 онд 5 611 болж нэмэгдсэн бөгөөд нийт эмнэлгийн орны 24.4 хувийг эзэлж байна. 2005 оноос хувийн хэвшлийн эмнэлгүүдийг ялангуяа ортой эмнэлгийг шинээр байгуулахыг хязгаарлах, харин улсын эмнэлгийн үзүүлж байгаа зарим эмнэлгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр гүйцэтгүүлэх, үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх, төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ.

Хувийн хэвшлийн эмнэлгүүдээр 2005 онд 1 016 705 хүн амбулаториор үйлчлүүлж, 63 267 хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2016 онд амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо 2 063 450, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 159 194 болж нэмэгдсэн байна.

2016 оны байдлаар хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн 41.2 хувь нь дотор, 11.4 хувь нь мэдрэл, 13.7 хувь нь уламжлалт, 8.1 хувь нь эмэгтэйчүүд, 6.4 хувь нь мэс засал, 5.1 хувь нь хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

### Хүснэгт 4.6.2. Хувийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2016 он

| Үзүүлэлт                 | Эмнэлгийн тоо |              | Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо |              |
|--------------------------|---------------|--------------|---------------------------|--------------|
|                          | Тоо           | Хувь         | Тоо                       | Хувь         |
| 5-8 ортой                | 15            | 6.4          | 2 445                     | 1.6          |
| 10-12 ортой              | 60            | 25.6         | 19 627                    | 12.3         |
| 15 ортой                 | 39            | 16.7         | 18 012                    | 11.3         |
| 20-25 ортой              | 59            | 25.2         | 36 178                    | 22.7         |
| 30 ортой                 | 22            | 9.4          | 17 915                    | 11.3         |
| 40-50 ортой              | 22            | 9.4          | 21 501                    | 13.5         |
| 50 ба түүнээс дээш ортой | 17            | 7.3          | 43 516                    | 27.3         |
| <b>Нийт дүн</b>          | <b>234</b>    | <b>100.0</b> | <b>159 194</b>            | <b>100.0</b> |

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг орны хүчин чадлаар ангилж авч үзвэл 5-8 ортой эмнэлэг 6.4 хувийг, 10-12 ортой эмнэлэг 25.6 хувийг, 15 ортой эмнэлэг 16.7 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд хувийн эмнэлгийн 48.7 хувь нь 15 хүртэлх ортой эмнэлгүүд байна.



## БҮЛЭГ 5.


ЭРҮҮЛ  
МЭНДИЙН  
САЛБАРЫН  
ХҮНИЙ НӨӨЦ

## БҮЛЭГ 5.

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ


Эрүүл мэндийн салбарт 2016 онд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд болон бусад салбарын эрүүл мэндийн ажилтан нийт 48 173 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.6 хувиар өссөн байна. Нийт ажиллагчдаас 93.2 хувь нь эрүүл мэндийн салбарын, 6.8 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна.

**Зураг 5.1.1. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид, сүүлийн 5 жилээр**



Нийт ажиллагчдын 22.3 хувь нь анхдагч шатлалын, 18.0 хувь нь хоёрдогч шатлалын, 16.1 хувь нь гуравдагч шатлалын, 18.1 хувь нь хувийн эмнэлгүүдэд, 25.5 хувь нь амаржих газар болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.


Эрүүл мэндийн нийт ажиллагчдаас 10.0 мянга нь их эмч, 1.5 мянга нь эм зүйч, 11.4 мянга нь сувилагч, 7.4 мянга нь эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан байна. Нэг их эмчид ногдох хүний тоо 2016 онд 309 байгаа нь өмнөх оныхоос 7 хүнээр буурч, нэг сувилагчид ногдох хүний тоо 269 болж, өмнөх оныхоос 2 хүнээр нэмэгдсэн байна. Нэг их эмчид ногдох хүний тоо Хангайн бүсэд хамгийн өндөр буюу 447 хүн ногдож байгаа ба баруун бүсэд 425, зүүн бүсэд 427, төвийн бүсэд 375 хүн ногдож байна. Улаанбаатар хотод нэг их эмчид ногдох хүний тоо 237, нэг сувилагчид ногдох хүний тоо 240 байна. Нэг сувилагчид ногдох хүний тоо хангайн бүсийн аймгуудад хамгийн өндөр буюу 311 байна.

**Зураг 5.1.2. Нэг их эмч, сувилагчид ногдох хүний тоо, бүс нутгаар, 2016 он**

Тусламж үйлчилгээ үзүүлж буй ажиллагчдын 20.8 хувийг эмч, 23.8 хувийг сувилагч, 15.4 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан хувийг эзэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 81.8 хувь нь эмэгтэйчүүд байна.


2016 оны байдлаар улсын хэмжээнд нийт 10 000 их эмч байгаа ба нийт эмч нарын дийлэнх буюу 76.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт эмч нарын 59.9 хувь нь Улаанбаатар хотод, 40.1 хувь нь аймаг, орон нутагт ажиллаж байна.

Насны бүлгээр авч үзвэл 29.7 хувийг 20-29 насны, 28.2 хувийг 30-39 насны, 20.2 хувийг 40-49 насны, 10.1 хувийг 50-54 насны, 7.4 хувийг 55-60 насны, 4.5 хувийг 60-аас дээш насны эмч нар эзэлж байна. Нийт их эмч/сувилагчийн 20.1/24.0 хувь нь анхдагч шатлалд, 20.3/27.9 хувь нь хоёрдогч шатлалд, 16.7/22.8 хувь нь гуравдагч шатлалын эмнэлгүүдэд ажиллаж байна.

**Зураг 5.1.3. Эмнэлгийн дунд мэргэжилтэн, хүний их эмч, 10 000 хүн амд, 2006-2016**

Монгол улсад 2016 оны байдлаар 10 000 хүн амд ногдох их эмч 32.4, сувилагч 37.2, эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан 24.0 ногдож байна. 2015 онтой харьцуулахад 10 000 хүн амд ногдох эмч 0.8-аар нэмэгдэж, сувилагч 0.3-аар буурсан байна.

**Зураг 5.1.4. 10 000 хүн амд ногдох их эмч, сувилагчийн тоо, бүс нутгаар, 2016 он**




Эмч, сувилагчийн харьцаа улсын түвшинд 1:1.2, Улаанбаатар хотод 1:1, аймгийн түвшинд 1:1.4 байна.

Эмч, сувилагчийг байршлаар авч үзэхэд хөдөө орон нутагт 10 000 хүн амд ногдох их эмч 24.0, сувилагч 33.4 байхад Улаанбаатар хотод эмч 42.2, сувилагч 41.6 байгаа нь хот суурин газар эмчийн нягтрал ихтэй байгаа нь харагдаж байна.

Ялангуяа аймагт Улаанбаатар хоттой харьцуулахад нарийн мэргэжлийн эмч болох мэс заслын эмч 1.8 дахин, гэмтэл, согог заслын эмч 2.5 дахин, дүрс оношилгоо, лабораторийн эмч 2.7-3.3 дахин тус тус бага байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн 1 310 байгууллагад 8 730 эмнэлгийн ажиллагчид тусламж үйлчилгээ үзүүлсэн ба нийт ажиллагчдын 33.6 хувь нь их эмч, 23.4 хувь нь сувилагч байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч нарын дийлэнх буюу 27.8 хувь нь шүдний, 11.4 хувь нь уламжлалын 11.1 хувь нь дотрын, 8.9 хувь нь эх барих эмэгтэйчүүдийн, чиглэлээр ажиллаж байна.


**Зураг 5.1.5. Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын насны бүтэц, 2016 он**



### Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт


2016 онд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад 170 их эмч, төрөлжсөн мэргэшлийн сургалтад 90 их эмч, 322 сувилагч, тусгай мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр суралцаж төгссөн байна.

**Зураг 5.1.6. Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, тусгай мэргэжилтний тоо, 2016 он**



2016 онд үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 1 606, удирдах ажилтны сургалтад 111, гадаад сургалтад 101, ажлын байрны сургалтад 737, зайн сургалтад 4 867, туслах сувилагчийн сургалтад 104, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжилтний сургалтад 75, эрүүл мэндийн салбарын санхүү, эдийн засагчдын сургалтад 544 нийт 8 145 эрүүл мэндийн ажилтан улсын төсвийн санхүүжилтээр суралцаж төгссөн байна.





## БҮЛЭГ 6.

ХАЛДВАРТ  
ӨВЧИН

## БҮЛЭГ 6.

# ХАЛДВАРТ ӨВЧИН

### 6.1. НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН


2016 онд улсын хэмжээнд 28 төрлийн цочмог халдварт өвчний 69 663 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 10 263 тохиолдлоор нэмэгдсэн буюу 10 000 хүн амд 227.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 27.3-оор нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн цочмог халдварт өвчний 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Увс, Баян-өлгий, Төв, Дорнод аймгууд болон Улаанбаатар хотод буурч бусад аймгуудад 2.7-236.5-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2016 онд улаанбурхан, гар хөл амны өвчин, салхинцэцэг, улаан эсэргэнэ, гахай хавдар, трихомониаз, хачигт борреллиоз, халдварт эритема, сальмонеллэз, цусан суулга, хачигт рикеттсиоз, хачигт энцефалит зэрэг халдварт өвчнүүд өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн амд 0.1-19.8 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2016 онд бүртгэгдсэн цочмог халдварт өвчин Дорнод, Дархан-уул, Баянхонгор, Дорноговь аймгууд болон Улаанбаатар хотод улсын дунджаас /10 000 хүн амд 227.8/ өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 57.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

2016 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчнүүд дотор гэдэсний халдварт өвчин 13.0, амьсгалын замын халдварт өвчин 62.0, зоонозын халдварт өвчин 0.7, бэлгийн замаар дамжих халдвар 21.5, цусаар дамжих халдвар 0.7, бусад халдварт өвчин 2.1 хувийг тус тус эзэлж байна.

**Зураг 6.1.1. 2016 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц, хувиар**



## 6.2. ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИН

2016 онд улсын хэмжээнд вирүст хепатит А, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллын халдвар, суулгалт халдвар, гар хөл амны өвчин зэрэг 6 төрлийн гэдэсний халдварт өвчний 9 086 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 13.0 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний 7 520 (82.8%) нь Улаанбаатар хотод гарсан байна.

Гэдэсний халдварт өвчний 0.4 хувийг вирүст хепатит А, 31.3 хувийг цусан суулга, 61.3 хувийг гар хөл амны өвчин, 4.7 хувийг хүнсний гаралтай бактерт хордлого, 2.0 хувийг сальмонеллын халдвар, 0.2 хувийг суулгалт халдвар тус тус эзэлж байна.

### Хүснэгт 6.2.1. Гэдэсний халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2015-2016 он

| "Халдварт өвчин<br>/ӨОУА-10 нэршлээр/" | 2015      |                   | 2016      |                   | "Өсөлт<br>/бууралт/"<br>10 000 хүн<br>амд |
|----------------------------------------|-----------|-------------------|-----------|-------------------|-------------------------------------------|
|                                        | Бодит тоо | 10 000 хүн<br>амд | Бодит тоо | 10 000 хүн<br>амд |                                           |
| Балнад                                 | 1         | 0,0               | 0         | 0.0               | 0.0                                       |
| Сальмонеллэз                           | 146       | 0,5               | 181       | 0.6               | 0.1                                       |
| Цусан суулга                           | 2 737     | 9,2               | 2 848     | 9.3               | 0.1                                       |
| Хүнсний гаралтай бактерт хордлого      | 482       | 1,6               | 430       | 1.4               | -0.2                                      |
| Суулгалт халдвар                       | 81        | 0,3               | 19        | 0.1               | -0.2                                      |
| Цочмог А хепатит                       | 82        | 0,3               | 39        | 0.1               | -0.2                                      |
| Гар-хөл-амны өвчин                     | 1 524     | 5.1               | 5 569     | 18.2              | 13.1                                      |

### 6.2.1. БАКТЕРИЙН ГАРАЛТАЙ БУСАД ХООЛНЫ ХОРДЛОГО

2016 онд улсын хэмжээнд бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварын нийт 430 тохиолдол буюу 10 000 хүн амд 1.4 бүртгэгдсэн нь нийт гэдэсний халдварт өвчний дотор 4.7% эзэлж байна. Үүнээс Улаанбаатар хотод 386 (89.8%) тохиолдол буюу 10 000 хүн амд 2.8 бүртгэгдсэн байна.


2016 оны Улаанбаатар хотод бүртгэгдсэн бактерийн гаралтай бусад хоолны хордлогот халдварын өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн ам тутамд 10 тохиолдол буюу 0.1-оор нэмэгдэж, аймгуудад 62 тохиолдол буюу 0.4-оор буурсан үзүүлэлттэй байна.

2016 онд хоолны хордлогот халдварын өвчлөл 10 000 хүн амд Баян-Өлгий /1.6/, Орхон /0.1/, Сүхбаатар /0.7/, Төв /1.9/, Хөвсгөл /0.5/, Улаанбаатар хот /2.8/ бүртгэгдсэн байна. Хоолны хордлогот халдварыг сараар авч үзвэл 4 -р сараас өвчлөл ихсэж, 5-р сард дээд цэгтээ хүрч, 9-р сараас буурчээ. Өвчлөл бүх насныханд бүртгэгдсэн боловч 25-30 насны хүмүүсийн өвчлөл 19.1 хувь буюу хамгийн өндөр байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд 61.4 хувийг эзэлж байна.

/Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн 2016 оны тайлан/

### 6.2.2. ГАР ХӨЛ, АМНЫ ӨВЧИН

2016 онд улсын хэмжээнд гар хөл, амны өвчний нийт 5 569 тохиолдол буюу 10 000 хүн амд 18.2 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 13.1-оор нэмэгдсэн байна. Гар хөл амны өвчин нь нийт халдварт өвчний 8%, гэдэсний халдварын 61.3%-ийг эзэлж байна.

**Зураг 6.2.1. Гар, хөл амны өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2008-2016 он**

2008, 2010, 2014, 2016 онуудад дэгдэлт хэлбэрээр бүртгэгдсэн ба 2016 онд өвчлөл хамгийн өндөр бүртгэгдсэн байна

2016 онд 10 000 хүн амд Дорнод аймаг 31.1, Улаанбаатар хотод 32.4 байгаа нь улсын дундаж /18.2/-аас дээгүүр байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад Төв, Увс аймгууд 0.2-4.5-оор буурч, бусад аймгуудад 0.1-25.0-оор нэмэгдсэн байна. Улаанбаатар хотод гар хөл амны өвчин 10 000 хүн амд 32.4 /4 520 тохиолдол/ байгаа нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 23.6/3 315 тохиолдол/-оор нэмэгдсэн байна.

Гар хөл амны өвчин жилийн турш бүртгэгдсэнээс 1 дүгээр сараас 9 дүгээр сар хүртэл илүүтэй бүртгэгдэж, 10 дугаар сараас эхлэн буурч байна. Гар хөл амны өвчин 2011-2016 онуудад 4-8 дугаар саруудад хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна. Насны бүлгээр авч үзвэл 0-4 насны хүүхдүүдийн дунд өвчлөл өндөр 85.9 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд 56.2 хувийг эрэгтэй, 43.8 хувийг эмэгтэй тус тус эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гар, хөл амны өвчний 72.5 хувийг гэртээ байдаг хүүхдүүд, 16.7 хувийг цэцэрлэгийн хүүхдийн өвчлөл эзэлж байна.

/Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн 2016 оны тайлан/

### 6.2.3. ВИРУСТ ХЕПАТИТ

Улсын хэмжээнд вирүст гепатит өвчний 566 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 0.8 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 326 тохиолдлоор буурсан байна. Нийт вирүст гепатит өвчлөлийн 6.9 хувийг вирүст гепатит А, 64.8 хувийг вирүст гепатит В, 18.2 хувийн вирүст гепатит С, 10.1 хувийг бусад вирүст гепатит тус тус эзэлж байна.

Нийт гепатитийн өвчлөлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 000 хүн амд вирүст гепатит А 0.2-оор, вирүст гепатит В 0.4-оор, вирүст гепатит С 0.1-оор тус тус буурсан үзүүлэлтэй байна. Манай улсын хувьд сүүлийн 10 жилд бүртгэгдсэн вирүст гепатит А-н өвчлөлийн байдлыг авч үзэхэд 2011 онд хамгийн их буюу 10 000 хүн амд 49.0 байжээ.

10 000 хүн амд ногдох нийт вирүст гепатитийн өвчлөл Өмнөговь /2.8/, Улаанбаатар /2.5/, Дорноговь /2.5/, Дархан-Уул /2.4/, Говьсүмбэр /2.4/, Баянхонгор /2.1/, Говь-Алтай /2.0/ аймгуудад улсын дундаж /1.9/-аас дээгүүр үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 6.2.3.1** *Вирүст хепатит, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2015-2016 он*

| Аймаг            | 2015       |                | 2016       |                | "Өсөлт /бууралт/" |
|------------------|------------|----------------|------------|----------------|-------------------|
|                  | Бодит тоо  | 10 000 хүн амд | Бодит тоо  | 10 000 хүн амд | 10 000 хүн амд    |
| Өмнөговь         | 25         | 3.9            | 17         | 2.8            | -1.1              |
| Дорноговь        | 12         | 1.9            | 16         | 2.5            | 0.6               |
| Улаанбаатар      | 523        | 3.8            | 350        | 2.5            | -1.3              |
| Говьсүмбэр       | 9          | 5.8            | 4          | 2.4            | -3.4              |
| Дархан-уул       | 31         | 3.1            | 24         | 2.4            | -0.7              |
| Баянхонгор       | 22         | 2.7            | 18         | 2.1            | -0.6              |
| Говь-Алтай       | 10         | 1.8            | 11         | 2.0            | 0.2               |
| <b>Улсын дүн</b> | <b>892</b> | <b>3.0</b>     | <b>566</b> | <b>1.9</b>     | <b>-1.1</b>       |

**6.2.3.1. Вирүст хепатит А**

Улсын хэмжээнд бүртгэгдсэн вирүст хепатит А-н халдварыг 2006-2016 оны байдлаар авч үзэхэд 2007 болон 2010 оны 12 дугаар сар, 2011 оны 11 дүгээр саруудад оргил үедээ хүрч, өвчлөл 2012 оноос тууштай буурч байна.

Вирүст хепатит А-н өвчлөлийг нийгмийн байдлаар авч үзэхэд сургуулийн сурагч, малчин, ажилгүй хүмүүсийн дунд өвчлөл өндөр бүртгэгдэж, өвчлөлийн 49.9 хувийг сургууль, цэцэрлэгийн хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн 2016 оны тайлан

**6.2.3.2. Вирүст хепатит В**

Улсын хэмжээнд 2016 оны байдлаар вирүст хепатит В-н 367 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 1.2 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4-оор буурсан бөгөөд сүүлийн 10 жилд бүртгэгдсэн өвчлөлийн байдлыг авч үзвэл 2011 оноос буурч байна.

2016 онд 10 000 хүн амд Өмнөговь /1.8/, Говьсүмбэр /1.8/, Дорноговь /1.7/, Улаанбаатар /1.7/, Дархан-Уул /1.6/, Говь-Алтай /1.6/, Баянхонгор /1.5/, Сүхбаатар /1.4/ аймгууд улсын дундаж /1.2/-оос дээгүүр үзүүлэлттэй байна.


2016 онд бүртгэгдсэн вирүст хепатит В-н өвчлөлийг насны байдлаар харахад 15-34 насанд өвчлөл 88.3 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэй 53.7, эмэгтэй 46.3 хувийг тус тус эзэлж байна.

Вирүст хепатит В-н өвчлөлийг нийгмийн байдлаар авч үзэхэд ажилчин 26.2, бусад 25.6, оюутан 18.0, ажилгүй 10.1, албан хаагч 9.5 хувь тус тус бүртгэгдсэн байна.

**6.2.3.3. Вирүст хепатит С**

Улсын хэмжээнд 2016 оны байдлаар вирүст хепатит С-н 103 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 0.3 ногдож байгаа нь өмнөх оны түвшингээс 0.1-оор буюу 28 тохиолдлоор буурсан байна. 10 000 хүн амд ногдох өвчлөл Өмнөговь /1.0/, Дархан-Уул /0.8/, Дорноговь /0.8/, Говьсүмбэр /0.6/, Орхон /0.6/, Увс /0.6/, Баянхонгор /0.6/, Ховд /0.6/ аймгууд, Улаанбаатар хот /0.4/ улсын дундаж /0.3/-аас дээгүүр байна.

2016 онд бүртгэгдсэн вирүст хепатит С-н өвчлөлийг насны байдлаар авч үзэхэд 25-54 насанд 77.8 хувь буюу 80 тохиолдол бүртгэгдсэн байна.

**Зураг 6.2.3.1. Вирүст хепатит, 10 000 хүн амд, 2006-2016 он**

### 6.3. АМЬСГАЛЫН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Амьсгалын замын зарим цочмог халдварт өвчний 43 198 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 62.0 хувийг эзэлж байна.

Нийт өвчний дотор улаан бурхан(70.1%), сүрьеэ (9.4%), салхинцэцэг (15.8%), улаан эсэргэнэ (3.2%)-ийг, бусад халдвар 1.5 хувийг эзэлж байна. 2015 онтой харьцуулахад 10 000 хүн амд сүрьеэ 1.2-оор буурч, улаан бурхан 19.8-оор, салхинцэцэг 3.3-оор, улаан эсэргэнэ 2.0-оор, гахай хавдар 0.3-оор, халдварт эритема 0.2-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 6.3.1. Амьсгалын замын халдварт өвчин, бодит тоо, 10 000 хүн амд, 2015-2016 он**

| "Халдварт өвчин<br>/ӨОУА-10 нэршлээр/" | 2015      |                | 2016      |                | "Өсөлт<br>/бууралт/"<br>10 000 хүн амд |
|----------------------------------------|-----------|----------------|-----------|----------------|----------------------------------------|
|                                        | Бодит тоо | 10 000 хүн амд | Бодит тоо | 10 000 хүн амд |                                        |
| Сүрьеэ                                 | 4 270     | 14.4           | 4 045     | 13.2           | -1.2                                   |
| Улаан эсэргэнэ                         | 754       | 2.5            | 1 378     | 4.5            | 2.0                                    |
| Менингококкт халдвар                   | 11        | 0.0            | 10        | 0.0            | 0.0                                    |
| Салхин цэцэг                           | 5 624     | 19.0           | 6 834     | 22.3           | 3.3                                    |
| Улаанбурхан                            | 23 464    | 79.2           | 30 273    | 99.0           | 19.8                                   |
| Улаанууд                               | 49        | 0.2            | 48        | 0.2            | 0.0                                    |
| Гахай хавдар                           | 241       | 0.8            | 346       | 1.1            | 0.3                                    |
| Ёлом                                   | 145       | 0.5            | 160       | 0.5            | 0.0                                    |
| Хийт үхжил                             | 0         | 0.0            | 0         | 0.0            | 0.0                                    |
| Халдварт эритема                       | 42        | 0.1            | 104       | 0.3            | 0.2                                    |

#### 6.3.1. СҮРЬЕЭ

Сүрьеэ өвчний нийт 4 045 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 5.8 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 2 469 тохиолдол байгаа нь сүрьеэгийн нийт өвчлөлийн 61.0 хувийг эзэлж байна.

2016 онд 10 000 хүн амд сүрьеэгийн өвчлөл Сэлэнгэ /18.0/, Дархан-Уул /17.4/, Дорнод /15.6/, Говьсүмбэр /15.1/, Хэнтий /13.6/, Сүхбаатар /13.4/ аймаг, Улаанбаатар хотод /17.7/ байгаа нь улсын дундаж /13.2/ үзүүлэлтээс өндөр байна. Шинэ тохиолдлын дотор уушгины сүрьеэ 2 131 (52.7%),

уушгины бус эрхтний сүрьеэ 1 914 (47.3%) бүртгэгдсэнийг 2015 оны мөн үетэй харьцуулахад уушгины сүрьеэ 230 тохиолдол буюу 2.6 хувиар буурч, уушгины бус эрхтний сүрьеэ 5 тохиолдол буюу 2.6 хувиар нэмэгджээ.

Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насны ангиллаар нь авч үзвэл 15-44 насныхан 63.6 хувийг эзэлж байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 53.5 хувь, эмэгтэйчүүд 46.5 хувийг тус тус эзэлж байна.


**Хүснэгт 6.3.1.1. Сүрьеэ өвчин, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, /2015-2016 он/**

| Аймаг              | 2015         |                | 2016         |                | "Өсөлт /бууралт/" |
|--------------------|--------------|----------------|--------------|----------------|-------------------|
|                    | Бодит тоо    | 10 000 хүн амд | Бодит тоо    | 10 000 хүн амд | 10 000 хүн амд    |
| Сэлэнгэ            | 193          | 18.4           | 191          | 18.0           | -0.4              |
| Дархан-Уул         | 222          | 22.3           | 176          | 17.4           | -4.9              |
| Дорнод             | 154          | 21.0           | 119          | 15.6           | -5.4              |
| Говьсүмбэр         | 16           | 10.4           | 25           | 15.1           | 4.7               |
| Хэнтий             | 141          | 20.3           | 99           | 13.6           | -6.7              |
| Сүхбаатар          | 81           | 14.7           | 79           | 13.4           | -1.3              |
| <b>Улаанбаатар</b> | <b>2 534</b> | <b>18.5</b>    | <b>2 469</b> | <b>17.7</b>    | <b>-0.8</b>       |
| <b>Улсын дүн</b>   | <b>4 270</b> | <b>14.4</b>    | <b>4 045</b> | <b>13.2</b>    | <b>-1.2</b>       |

2014-2016 онуудад бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын дотор хүүхдийн сүрьеэгийн эзлэх хувь дунджаар 10.6 хувь байгаа нь бага болон дунд орлоготой бусад орнуудын түвшинд (5-15%) байна. 2016 онд 0-15 насны 550 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн байна. Үүнээс: уушгины 74, уушгины бус эрхтэний 476 тохиолдол бүртгэгдсэн. Хүүхдийн сүрьеэгийн хүнд хэлбэр хурц тархмал 5, сүрьеэгийн менингит 4 тохиолдлыг насаар нь авч үзвэл 1 настай-3, 9 настай-2, 12-15 настай-4 хүүхэд бүртгэгдсэн байна.

/Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн 2016 оны тайлан/

**Зураг 6.3.1.1. Сүрьеэгийн өвчлөл, нас баралт 10 000 хүн амд, 2006-2016 он**



2016 оны байдлаар 10 000 хүн амд ногдох сүрьеэгийн нас баралтын түвшинг өмнөх онтой харьцуулахад 0.01-оор нэмэгдсэн байна. 2016 онд оношийн баталгаажилт 76.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар нэмэгдэж хөтөлбөрийн зорилтот түвшинд хүрсэн байна.



Шинэ халдвартай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний амжилт 84.8 хувь, эдгэрэлт 80.6 хувь байгаа нь 2015 оныхоос эмчилгээний амжилт 0.3 хувиар нэмэгдэж, эдгэрэлт 1.1 хувиар буурсан байна.


/Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн 2016 оны тайлан/

### 6.3.2. УЛААНБУРХАН

Улсын хэмжээнд улаанбурхан өвчний 30 273 тохиолдол буюу 10 000 хүн амд 99.0 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 6 809 тохиолдлоор буюу 10 000 хүн амд 19.8-оор нэмэгдсэн байна. Нийт халдварт өвчний дотор улаанбурхан өвчний эзлэх хувь 43.5 байна. 10 000 хүн амд ногдох өвчлөл Дархан-Уул /221.3/, Дорноговь /158.3/, Өвөрхангай /125.1/, Баянхонгор /117.5/, Говь-Алтай /113.1/, Архангай /107.6/, Сэлэнгэ /105.3/, Хэнтий /90.6/, Говьсүмбэр /84.7/, Ховд /76.3/, Орхон /75.3/, Сүхбаатар /73.5/, Хөвсгөл /64.1/, Төв /48.9/, Булган /44.7/, Дорнод /40.5/, Баян-Өлгий /35.0/, Завхан /25.2/ аймгууд өмнөх онтой харьцуулахад /0.8-208.9/-оор ихсэж бусад аймгуудад буурсан байна. Нийт өвчлөлийн 52.7 хувийг Улаанбаатар хотод бүртгэгдсэн өвчлөл эзэлж, 10 000 хүн амд өвчлөл өнгөрсөн оны мөн үеэс 27.8-оор буурсан байна.

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн улаанбурханы өвчлөлийг насны ангиллаар авч үзэхэд 15-29 насны хүн амын өвчлөл 13 372 буюу нийт өвчлөлийн 44.0 хувийг, 0-11 сартай хүүхдийн өвчлөл 6 411 буюу нийт өвчлөлийн 21.0 хувийг тус тус эзэлж байна. Улаанбурхан өвчнөөр өвчлөгсдийн нийгмийн байдлаар авч үзэхэд гэрт болон сургуулийн насны хүүхдүүдийн өвчлөл 43.3 хувийг эзэлж байна.

**Зураг 6.3.2.1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн улаанбурхны өвчлөл, насны бүлэг, 10 000 хүн амд, 2016 он**



### 6.3.3. ГАХАЙ ХАВДАР ӨВЧИН

Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 346 тохиолдол буюу 10 000 хүн амд 1.1 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 105 тохиолдлоор буюу 10 000 хүн амд 0.3-аар нэмэгдсэн байна. Нийт халдварт өвчний дотор гахай хавдар өвчний эзлэх хувь 0.5 байна. 10 000 хүн амд ногдох өвчлөл Говьсүмбэр /2.4/, Баянхонгор /1.1/, Сүхбаатар /0.8/, Дархан-уул /0.6/, Дорноговь /0.5/, Говь-Алтай /0.4/, Завхан /0.4/, Өмнөговь /0.5/, Хөвсгөл /0.5/, Орхон /0.1/ аймгууд болон Улаанбаатар хот /1.8/ өмнөх онтой харьцуулахад /0.1-2.4/-өөр ихсэж бусад аймгуудад буурсан байна. Нийт гахай хавдар өвчний 71.9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, 10 000 хүн амд өнгөрсөн оны мөн үеэс 0.3-оор нэмэгдсэн байна. 2016 онд бүртгэгдсэн гахай хавдрын өвчлөл 5-9 насны хүүхдийн дунд нийт өвчлөлийн 40.0 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ насны хүүхдүүд нь товллын вакцин



аваагүй байна.

#### 6.3.4. САЛХИНЦЭЦЭГ ӨВЧИН

Энэ онд салхинцэцгийн нийт 6 834 тохиолдол буюу 10 000 хүн амд 22.3 тохиолдол бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад 3.3-аар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

2016 онд 10 000 хүн амд Дорнод /49.6/, Өмнөговь /44.8/, Сүхбаатар/42.5/, Дундговь /38.9/, Дорноговь /30.5/, Өвөрхангай /29.9/, Завхан /28.7/, Улаанбаатар /26.5/, Дархан-Уул /25.9/, Говьсүмбэр /23.0/ аймаг, хотод салхинцэцгийн өвчлөл улсын дундаж /22.3/-аас дээгүүр байна. Салхинцэцгийн өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Баянхонгор, Дорнод, Орхон, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгуудад 1.1-11.3-оор буурч, бусад аймгуудад 0.1-33.0-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 5 жилд бүртгэгдсэн салхинцэцэг өвчний хөдлөлзүйг авч үзвэл өвчлөл 10-11-р сараас эхлэн нэмэгдэж, 3-5-р саруудад оргил үедээ хүрчээ. 2016 онд өвчлөл 10- сараас эхлэн нэмэгдэж, 12-р сард оргил үедээ хүрсэн байна.

Салхинцэцгийн өвчлөлийн 81.1% нь 0-14 хүртэлх насны хүүхдүүдийн дунд бүртгэгдэж, үүний 68.1%-ийг 4 хүртэлх насныхан эзэлж байна. Улаанбаатар хотод салхинцэцгийн өвчлөл Баянзүрх 42.2, Хан-уул 29, Багануур 28.9, Сүхбаатар 23.7, Баянгол 23.7 бүртгэгдсэн нь нийслэлийн дундаж /22.2/-аас дээгүүр үзүүлэлттэй байна.

#### 6.3.4. УЛААНЭСЭРГЭНЭ

2016 онд улаанэсэргэнэ өвчний нийт 1 378 тохиолдол буюу 10 000 хүн амд 4.5 тохиолдол бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад 2.0-оор нэмэгдсэн үзүүлэлтэй байна. 2016 онд 10 000 хүн амд Дорнод /6.7/, Улаанбаатар /9.1/ хотод улаанэсэргэнэ өвчин улсын дундаж /4.5/-аас дээгүүр байна. Улаанэсэргэнэ өвчнийг өмнөх онтой харьцуулахад Архангай, Орхон, Өмнөговь, Төв аймгуудад 0.1-1.5-оор буурч, Улаанбаатар хотод 4.2-оор, бусад аймгуудад 0.1-2.3-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн халдварын 92% нь Улаанбаатар хотод, 8% нь хөдөө орон нутагт байна. Улаанбаатар хотод нийт 1 268 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 9.1 тохиолдол байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.2 тохиолдлоор нэмэгдсэн байна. Улаанбаатар хотын Баянзүрх 29.4%, Сонгинохайрхан 20.1%, Баянгол 17.5% дүүргүүдэд нийт тохиолдлын 67% нь бүртгэгдсэн байна.

Өвчлөл бүх насныхан дунд бүртгэгдэж байгаа хэдий ч 0-9 насны хүүхдүүд нийт өвчлөгсдийн 90%-ийг эзэлж байна. Өвчлөгсдийн 42.5% нь цэцэрлэгт, 30.2% нь гэрт, 20.7% нь сургуульд сурдаг хүүхдүүд байна.

### 6.4 БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР

Бэлгийн замаар дамжих халдварын 14 964 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 21.5 хувийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 1 745 тохиолдол буюу 10 000 хүн амд 7.4-оор буурсан байна. Нийт бүртгэгдсэн өвчлөлийн 29.2 хувийг заг хүйтэн, 41.4 хувийг тэмбүү, 29.2 хувийг трихомониаз, 0.2 хувийг ХДХВ/ДОХ өвчин тус тус эзэлж байна.


**Хүснэгт 6.4.1. Бэлгийн замаар дамжих халдвар, бодит тоо, 10 000 хүн амд, 2015-2016 он**

| "Халдварт өвчин<br>/ӨОУА-10<br>нэршлээр/" | 2015      |                | 2016      |                | "Өсөлт<br>/бууралт/"<br>10 000 хүн амд |
|-------------------------------------------|-----------|----------------|-----------|----------------|----------------------------------------|
|                                           | Бодит тоо | 10 000 хүн амд | Бодит тоо | 10 000 хүн амд |                                        |
| Тэмбүү                                    | 7 678     | 25.9           | 6 193     | 20.3           | -5.6                                   |
| Заг хүйтэн                                | 4 975     | 16.8           | 4 374     | 14.3           | -2.5                                   |
| Трихомониаз                               | 4 038     | 13.6           | 4 371     | 14.3           | 0.7                                    |
| ХДХВ/ДОХ                                  | 18        | 0.1            | 26        | 0.1            | 0.0                                    |

10 000 хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөл Баянхонгор /36.5/, Дорнод /34.7/, Сүхбаатар /31.5/, Хөвсгөл /26.5/, Говь-Алтай /24.0/, Төв /23.7/, Говьсүмбэр /23.6/, Дорноговь /21.3/ аймгууд болон Улаанбаатар хотод /22.2/, заг хүйтэн Дорнод /78.2/, Хөвсгөл /35.3/, Дорноговь /21.6/, Баянхонгор /18.5/, Сүхбаатар /14.7/ аймгууд болон Улаанбаатар хотод /15.0/, трихомониазын өвчлөл Дорнод /60.7/, Баянхонгор /53.3/, Булган /17.5/, Сүхбаатар /15.8/ аймгууд болон Улаанбаатар хотод /15.4/ байгаа нь улс /14.3/ болон аймаг /13.3/-ийн дунджаас өндөр байна.

2016 онд төрөлхийн тэмбүүгийн 42 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 10 тохиолдлоор буурсан байна. Төрөлхийн тэмбүүгийн өвчлөл Баян-Өлгий 2, Баянхонгор 1, Дорнод 1, Орхон 4, Өмнөговь 1, Сүхбаатар 1, Төв 4, Увс 1, Ховд 1, Хэнтий 1, Улаанбаатар хотод 25 тохиолдол бүртгэгдсэн байна. Төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 17 нь жирэмсний хяналтанд огт хамрагдаагүй. Харин 25 эмэгтэй жирэмсний хяналтанд хамрагдсанаас тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээг 2 удаа хийлгэсэн 5, жирэмсний зөвхөн эрт эсвэл хожуу үедээ хийлгэсэн 18, огт хийлгээгүй 2 эмэгтэй байгаа нь жирэмсний хяналтын чанар, хүртээмж хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь хүний хариуцлагагүй байдлыг илтгэж байна.


/Эх үүсвэр: ХӨСҮТ-ийн 2016 оны тайлан/

**Зураг 6.4.1. Бэлгийн замаар дамжих халдвар, 10 000 хүн амд, 2012-2016 он**

2016 оны байдлаар зонхилон тохиолдох БЗДХ-аар өвчлөгсдийн 62.4 хувь нь эмэгтэй, 37.9 хувь нь эрэгтэй байна. Насны ангиллаар авч үзэхэд 11.9 хувь нь 15-19 насны, 29.3 хувь нь 20-24 насны, 24.3 хувь нь 25-29 насны, 14.3 хувь нь 30-34 насны, 8.7 хувь нь 35-39 насны хүмүүс байна. Монгол улсын хэмжээнд ХДХВ/ДОХ-ын нийт 225 тохиолдол албан ёсоор бүртгэгдсэнээс 2016 онд 26 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 8 тохиолдлоор нэмэгдсэн бөгөөд нийт тохиолдлуудад ХДХВ-ийн халдвар бэлгийн замаар дамжсан байна. ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдлын 81.0 хувийг эрэгтэйчүүд, 18.0 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

## 6.5 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Халдварт өвчний шалтгаант нас баралтын 277 тохиолдол бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын тохиолдлыг шалтгаанаар авч үзвэл сүрьеэ 112, төрөлхийн тэмбүү 15, вирүст хепатит 5, улаан бурхан 132, ХДХВ/ДОХ 8, хачигт энцефалит 2, салхин цэцэг, менингококкт халдвар, хумхаа тус тус 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Улаанбурхан өвчний улмаас 132 хүн нас барсан бөгөөд Улаанбаатар хот 51, Хөвсгөл 11, Архангай 10, Баянхонгор 10, Сэлэнгэ 10, Дархан-Уул 8, Хэнтий 7, Дорноговь 4, Өвөрхангай 4, Увс 4, Ховд 4, Орхон 3, Төв 2, Булган, Говьсүмбэр, Дундговь, Завхан аймгууд тус бүр 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Улаанбурхан өвчний улмаас нас барсан тохиолдлуудын 78.7% нь 0-8 сартай хүүхдүүдийн өвчлөл эзэлж байна. Хүйсийн хувьд эрэгтэй 56.8%-ийг эзэлж байна. Дундаж ор хоног 7 хоног байна. Улаанбурхан өвчний улмаас нас барсан тохиолдлуудын 51.6% (64) нь туурах шинж тэмдэг эхэлснээс хойш 5-8 хоногийн дараа нас барсан байна. Нас барсан тохиолдлын 58.9% (73) нь хавсарсан болон суурь өвчтэй байсан. Үүнд: цус багадал, тэжээлийн дутагдал, сульдаа, шүүдэст эмзэгшил, дархлаа эсгэгийн дутмагшил, ДЦП, зүрхний төрөлхийн хоргүй хавдар, моноклеоз, дауны өвчин, уушги зүрхний төрөлхийн гажиг, тархины даралт байв.



## БҮЛЭГ 7.

ХАЛДВАРТ БУС  
ӨВЧЛӨЛ

## БҮЛЭГ 7.

## ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ


## 7.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Дэлхийн хүн амын халдварт бус өвчний дотор зүрхний өвчин, цус харвалт, хавдар, чихрийн шижин, уушгины архаг өвчин дийлэнх хувийг эзэлж, буурай болон дундаж хөгжилтэй улс орнуудын хүмүүс өртөж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2025 он гэхэд халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг 25 хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Манай улсын хүн амын дунд халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан болж байгаа өвчлөл 2006 онтой харьцуулахад 10 000 хүн амд 1.3-2.2 дахин нэмэгджээ. 2006 онд хоол боловсруулах тогтолцооны өвчин 10 000 хүн амд 729.6 байсан бол 2016 онд 1 231.4 болж нэмэгдсэн. Халдварт бус өвчний шалтгаан болсон архи, тамхины хэрэглээ, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний дутагдал нь манай улсын хүн амын дунд эрс нэмэгдэж, 45-64 насны хүмүүсийн талаас илүү буюу 53.2 хувь халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй байна.

Эх үүсвэр: Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаа, Монгол улс-2013 он

**Зураг 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд /2006-2016 он/**



2016 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд:

- Амьсгалын тогтолцооны өвчин /10 000 хүн амд 1 647.4/
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин /10 000 хүн амд 1 231.4/
- Зүрх-судасны тогтолцооны өвчин /10 000 хүн амд 1 007.6/
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд 807.6/
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг /10 000 хүн амд 469.9/ орж байна.

2016 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх 3 шалтгаант орж байна. Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг хотод 767.5 байгаа нь хөдөөнөөс 550.5-оор өндөр, хөдөөд шээс бэлгийн тогтолцооны өвчин 817.9 байгаа нь хотын хүн амд харьцуулахад 10 000 хүн тутамд 23.0-оор өндөр байна.

**Хүснэгт 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2016 он**

|                    | Нийт өвчлөл    | Амьсгалын тогтолцооны өвчин | Хоол боловсруулах тогтолцооны өвчин | Шээс бэлгийн тогтолцооны эмгэг | Зүрх-судасны тогтолцооны өвчин | Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант тодорхой эмгэг |
|--------------------|----------------|-----------------------------|-------------------------------------|--------------------------------|--------------------------------|----------------------------------------------------------|
| <b>Хүйс</b>        |                |                             |                                     |                                |                                |                                                          |
| Эрэгтэй            | 6 603.0        | 1 628.1                     | 996.9                               | 364.7                          | 785.6                          | 606.9                                                    |
| Эмэгтэй            | 9 962.5        | 1 692.7                     | 1 477.4                             | 1 247.7                        | 1237.9                         | 113.2                                                    |
| <b>Насны бүлэг</b> |                |                             |                                     |                                |                                |                                                          |
| <b>Эрэгтэй</b>     |                |                             |                                     |                                |                                |                                                          |
| 20 хүртэл          | 6 808.7        | 3 324.7                     | 1 017.9                             | 155.2                          | 30.7                           | 478.4                                                    |
| 20-44              | 4 284.8        | 418.0                       | 710.7                               | 365.3                          | 352.8                          | 729.2                                                    |
| 45-65              | 9 668.9        | 693.5                       | 1 451.6                             | 662.1                          | 2 534.8                        | 611.5                                                    |
| 65 ба түүнээс дээш | 19 037.2       | 1 557.7                     | 2 190.8                             | 1 412.9                        | 6 844.4                        | 550.2                                                    |
| <b>Эмэгтэй</b>     |                |                             |                                     |                                |                                |                                                          |
| 20 хүртэл          | 6 723.6        | 3 181.1                     | 1 066.5                             | 229.0                          | 42.8                           | 271.1                                                    |
| 20-44              | 9 269.4        | 710.7                       | 1 276.4                             | 1 756.7                        | 1 066.5                        | 346.2                                                    |
| 45-65              | 14 914.7       | 1 014.9                     | 2 368.5                             | 1 961.1                        | 3 483.9                        | 443.3                                                    |
| 65 ба түүнээс дээш | 21 908.1       | 1 478.6                     | 2 954.9                             | 1 859.0                        | 7 601.1                        | 530.9                                                    |
| <b>Байршил</b>     |                |                             |                                     |                                |                                |                                                          |
| Хот                | 9 250.5        | 1 632.3                     | 1 219.6                             | 794.9                          | 1 001.7                        | 767.5                                                    |
| Хөдөө              | 7 387.1        | 1 659.1                     | 1 240.6                             | 817.9                          | 1 011.9                        | 217.0                                                    |
| <b>Бүсээр</b>      |                |                             |                                     |                                |                                |                                                          |
| Баруун             | 6 215.6        | 1 260.2                     | 1 074.1                             | 778.7                          | 862.2                          | 166.3                                                    |
| Хангайн            | 7 720.9        | 1 710.7                     | 1 192.3                             | 969.0                          | 1 153.3                        | 193.2                                                    |
| Төв                | 7 916.5        | 1 862.7                     | 1 346.3                             | 785.3                          | 1 022.9                        | 258.1                                                    |
| Зүүн               | 7 416.6        | 1 787.1                     | 1 439.0                             | 548.2                          | 874.0                          | 282.0                                                    |
| <b>Улсын дүн</b>   | <b>8 245.4</b> | <b>1 647.4</b>              | <b>1 231.4</b>                      | <b>807.6</b>                   | <b>1 007.6</b>                 | <b>469.9</b>                                             |


10 000 эмэгтэй хүн амд ногдох өвчлөлийн түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад 1.5 дахин их байна. Өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл эрэгтэйчүүдэд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн улмаас бүртгэгдсэн өвчлөлийн түвшин эмэгтэйчүүдтэй харьцуулахад 5.4 дахин их, бусад өвчлөлийн түвшин 1.0-3.4 дахин бага байна.

Хүн амын өвчлөлийг бүс нутгаар авч үзвэл төвийн болон хангайн бүсэд өвчлөлийн түвшин өндөр байгаа ба амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийг бусад бүстэй харьцуулахад 300-600 тохиолдлоор өндөр байна.

## 7.2. ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭХ ӨВЧИН

Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй зүрх-судасны тогтолцооны өвчлөлийн 50.0 хувийг цусны даралт ихсэх өвчин эзэлж, 10 000 хүн амд 503.9 байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд 10 000 хүн амд 653.1, эрэгтэйчүүд 10 000 хүн амд 357.5 тохиолдож байна. Байршлаар нь үзэхэд Хангайн болон төвийн бүсийн хүн амд илүүтэй тохиолдож байна. Хангайн болон төвийн бүсийн аймгууд дотроос Булган /775.0/, Архангай /994.6/, Баянхонгор /716.6/, Хөвсгөл /605.6/, Өмнөговь-/752.1/, Дархан-Уул-/619.2/, Төв-/615.6/, Хэнтий /672.2/ аймгуудад өндөр байгаа ба эмэгтэйчүүдийн өвчлөл илүү бүртгэгдсэн байна.


**Зураг 7.2.1. Цусны даралт ихсэх өвчин, 10 000 хүн амд, 2016 он**



## 7.3. ЧИХРИЙН ШИЖИН ӨВЧИН

Чихрийн шижин өвчин дотоод шүүрэл, тэжээлийн бодисын солилцооны өвчлөлийн 48.9 хувийг эзэлж, 10 000 хүн амд 78.6 байгаа нь өнгөрсөн оноос 14.8-оор өссөн байна. Хүйсийн хувьд 10 000 хүн амд эрэгтэйчүүд 75.5, эмэгтэйчүүд 82.9 байна. Насны бүлгээр нь авч үзэхэд 45-65 насныханд хамгийн өндөр буюу 10 000 хүн ам тутамд 286.3 байна. Байршлаар нь үзэхэд төвийн бүсэд хамгийн өндөр буюу 10 000 хүн амд 74.5 байгаа ба Дархан-уул /146.6/, Сэлэнгэ /76.4/, Өмнөговь /69.8/, Говьсүмбэр /42.5/ аймгуудад өндөр байна.

**Зураг 7.3.1. Чихрийн шижин өвчин, хүйсээр, бүсээр, 10 000 хүн амд, 2016 он**



## 7.4. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ

2016 онд бүртгэгдсэн хорт хавдрын шинэ тохиолдлын 50.3 % эрэгтэй, 49.7 % эмэгтэйчүүдийн өвчлөл эзэлж байна. Элэгний хорт хавдар нийт хорт хавдрын 39.1 хувийг эзэлж 10 000 хүн ам тутамд 7.3 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.2-оор өссөн үзүүлэлтэй байна.

**Хүснэгт 7.4.1. Зонхилон тохиолдох арван байрлалын хорт хавдар, хүйсээр, /TNM ангиллаар/, 2016 он**

|    | Нийт                |      | Эрэгтэй                   |      | Эмэгтэй             |      |
|----|---------------------|------|---------------------------|------|---------------------|------|
|    | Хорт хавдар         | Хувь | Хорт хавдар               | Хувь | Хорт хавдар         | Хувь |
| 1  | Элэг                | 39.1 | Элэг                      | 42.2 | Элэг                | 36.9 |
| 2  | Ходоод              | 15.8 | Ходоод                    | 20.9 | Умайн хүзүү         | 13.9 |
| 3  | Умайн хүзүү         | 6.9  | Уушги                     | 11.9 | Ходоод              | 10.5 |
| 4  | Уушги               | 7.7  | Улаан хоолой              | 5.7  | Хөх                 | 7.1  |
| 5  | Улаан хоолой        | 5.7  | Нойр булчирхай            | 3.7  | Улаан хоолой        | 5.6  |
| 6  | Хөх                 | 3.6  | Бүдүүн шулуун гэдэс       | 2.7  | Өндгөвч             | 3.8  |
| 7  | Нойр булчирхай      | 2.6  | Бөөр                      | 2.3  | Бүдүүн шулуун гэдэс | 3.5  |
| 8  | Бөөр                | 2.4  | Уруул амны хөндий залгиур | 1.4  | Уушги               | 3.4  |
| 9  | Бүдүүн шулуун гэдэс | 3.6  | Эр бэлэг эрхтэний         | 1.1  | Нойр булчирхай      | 2.5  |
| 10 | Өндгөвчний          | 1.9  | Яс үе мөгөөрс             | 0.7  | Бөөр                | 2.5  |

Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушги, улаан хоолой, нойр булчирхайн хорт хавдар, эмэгтэйчүүдийн дунд элэг, умайн хүзүү, ходоод, хөх, улаанхоолойн хорт хавдар тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

### 7.4.1. Хорт хавдрын хяналтын байдал

Хорт хавдрын улмаас аймаг дүүргийн хавдар судлаач эмчийн хяналтад 2016 оны тайлангийн эцэст 15 837 хүн байгаагаас 5-аас дээш жил амьдарч байгаа хүмүүс 32.0 хувийг эзэлж өмнөх онтой харьцуулахад 0.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Умайн хүзүүний өмөнгийн улмаас хяналтад байгаа эмэгтэйчүүдийн 45.3 хувийг өмөн оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарч байгаа эмэгтэйчүүд эзэлж байгаа нь байрлалын хорт хавдруудтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.

**Зураг 7.4.1.1 Хорт хавдар оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарч байгаа хүний эзлэх хувь, 2016 он**





#### 7.4.2. Хүүхдийн хорт хавдрын өвчлөл, нас баралт

Улсын хэмжээнд 2016 онд хүүхэд, өсвөр насныхны дунд бүртгэгдсэн хорт хавдрын 108 тохиолдлоос эрэгтэй 56.5, эмэгтэй 43.5 хувь байна.


Өмнөх онтой харьцуулахад 21 тохиолдлоор нэмэгдсэн ба насны ангиллаар нь авч үзвэл 0-4 нас 38.0, 5-9 нас 18.5, 10-14 нас 17.6, 15-19 насны 25.9 хувийг тус тус эзэлж байна.

#### 7.5. АМБУЛАТОРИТ БҮРТГЭГДСЭН ЭЛЭГНИЙ ӨВЧИН

Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн 13.7 хувийг элэгний өвчлөл эзэлж байгаа ба 10 000 хүн ам тутамд 169.4 байна. Харин хэвтэн эмчлүүлэгчдийн 26.0 хувийг элэгний өвчлөл эзэлж байна. Бүртгэгдсэн элэгний өвчлөлөөс хорт хавдрын үндсэн шалтгаан болдог архаг хепатит 40.6, элэгний цирроз 33.5 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн амд архины шалтгаант элэгний өвчлөл 2010 онд 14.3 байсан бол 2016 онд 6.8 буюу 7.5-оор буурсан үзүүлэлтэй байна. Архаг хепатитаар 10 000 хүн амд 2010 онд 53.4 байсан бол 2016 онд 68.8 буюу 15.4-оор өссөн байна. Элэгний циррозоор 10 000 хүн амд 2013 онд 59.8 байсан бол 2016 онд 56.9 буюу 2.9-оор буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг 7.5.1. Элэгний циррозын өвчлөл, нас баралт, 10 000 хүн амд, /2000-2016/**



#### 7.6. ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

2016 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд:

- Амьсгалын тогтолцооны өвчин /10 000 хүн амд 456.1/
- Зүрх-судасны тогтолцооны өвчин /10 000 хүн амд 399.3/
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин /10 000 хүн амд 332.0/
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд 306.1/
- Мэдрэлийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд 193.7/

**Хүснэгт 7.6.1. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2016 он**

|                              | Нийт<br>өвчлөл | Амьсгалын<br>тогтолцооны<br>өвчин | Хоол<br>боловсруулах<br>тогтолцооны<br>өвчин | Шээс бэлгийн<br>тогтолцооны<br>өвчин | Зүрх-судасны<br>тогтолцооны<br>өвчин | Мэдрэлийн<br>тогтолцооны<br>өвчин |
|------------------------------|----------------|-----------------------------------|----------------------------------------------|--------------------------------------|--------------------------------------|-----------------------------------|
| <b>Хүйс</b>                  |                |                                   |                                              |                                      |                                      |                                   |
| Эрэгтэй                      | 2 102.1        | 486.5                             | 311.2                                        | 158.0                                | 341.7                                | 161.3                             |
| Эмэгтэй                      | 3 416.7        | 434.2                             | 357.4                                        | 453.8                                | 461.3                                | 228.0                             |
| <b>Насны бүлэг /Эрэгтэй/</b> |                |                                   |                                              |                                      |                                      |                                   |
| 20 хүртэл                    | 1 887.2        | 1 005.9                           | 244.4                                        | 63.7                                 | 13.1                                 | 75.5                              |
| 20-44                        | 1 342.9        | 98.2                              | 254.8                                        | 159.6                                | 148.2                                | 158.1                             |
| 45-65                        | 3 470.7        | 212.1                             | 521.1                                        | 284.4                                | 1 072.1                              | 302.3                             |
| 65 ба түүнээс дээш           | 7 787.3        | 641.2                             | 801.9                                        | 650.6                                | 3 209.4                              | 538.0                             |
| <b>Насны бүлэг /Эмэгтэй/</b> |                |                                   |                                              |                                      |                                      |                                   |
| 20 хүртэл                    | 1 795.9        | 874.5                             | 216.6                                        | 94.5                                 | 16.7                                 | 71.1                              |
| 20-44                        | 3 679.1        | 121.4                             | 24.9                                         | 597.4                                | 178.5                                | 198.2                             |
| 45-65                        | 4 640.7        | 239.0                             | 682.4                                        | 719.1                                | 1221.1                               | 491.0                             |
| 65 ба түүнээс дээш           | 8 944.2        | 549.1                             | 1 141.7                                      | 937.6                                | 3 463.2                              | 680.4                             |
| <b>Байршил</b>               |                |                                   |                                              |                                      |                                      |                                   |
| Хот                          | 3 151.6        | 488.8                             | 406.3                                        | 311.4                                | 421.5                                | 221.7                             |
| Хөдөө                        | 2 405.1        | 428.0                             | 268.7                                        | 301.3                                | 380.2                                | 169.8                             |
| <b>Бүсээр</b>                |                |                                   |                                              |                                      |                                      |                                   |
| Баруун                       | 2 685.6        | 419.1                             | 328.1                                        | 347.5                                | 423.1                                | 236.2                             |
| Хангайн                      | 2 248.5        | 362.5                             | 252.6                                        | 321.2                                | 392.4                                | 136.9                             |
| Төв                          | 2 382.9        | 512.8                             | 238.3                                        | 279.1                                | 361.6                                | 151.9                             |
| Зүүн                         | 2 366.8        | 428.6                             | 273.3                                        | 211.6                                | 309.7                                | 178.2                             |
| <b>Улсын дүн</b>             | <b>2 747.8</b> | <b>456.1</b>                      | <b>332.0</b>                                 | <b>306.1</b>                         | <b>399.3</b>                         | <b>193.7</b>                      |

Эмнэлэгт хэвтэлтийн түвшин 10 000 эрэгтэй хүн амд 2 102.1, 10 000 эмэгтэй хүн амд 3 416.7 ногдож, ойролцоогоор эмнэлэгт хэвтэж байгаа 2 хүний нэг нь эрэгтэйчүүд байна. 10 000 эрэгтэй хүн амд ногдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн түвшин 10 000 эмэгтэй хүн амд ногдох стационарын өвчлөлийн түвшингээс 1.6 дахин бага байна.

2016 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийг шалтгаанаар нь авч үзвэл: шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 63.0 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, амьсгалын тогтолцооны өвчнөөс уушгины хатгаа 52.4, хоол боловсруулах тогтолцооны өвчнөөс элэгний эмгэг 26.0, зүрх судасны тогтолцооны өвчнөөс даралт ихсэх өвчин 39.7, зүрхний ишеми өвчин 24.3 хувийг тус тус эзэлж хүн амын дунд зонхилон тохиолдож байна.

**Хүснэгт 7.5.2. Хэвтэн эмчлүүлэгчдийн зонхилон тохиолдох өвчлөл, хувиар 2007-2016 он**

| "Өвчний ангилал (ӨОУА-10)"          | Зонхилох шалтгаан                              | Өвчлөлийн тухайн бүлэгт эзлэх хувь |      |      |      |      |      |      |      |      |      |
|-------------------------------------|------------------------------------------------|------------------------------------|------|------|------|------|------|------|------|------|------|
|                                     |                                                | 2007                               | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
| Шээс бэлгийн тогтолцооны эмгэг      | "Бөөрний сувганцрын үрэвсэл (N10-N16)"         | 67.8                               | 69.1 | 66.6 | 68.3 | 67.4 | 67.1 | 66.1 | 64.1 | 63.6 | 63.0 |
| Амьсгалын тогтолцооны өвчин         | Хатгалгаа (J12-J18)                            | 40.5                               | 41.9 | 38.8 | 44.8 | 46.2 | 46.9 | 46.1 | 51.3 | 44   | 52.4 |
| Хоол боловсруулах тогтолцооны өвчин | "Элэгний эмгэг (K70-K77)"                      | 25.1                               | 25.6 | 25.7 | 25.2 | 26.1 | 26.6 | 27   | 27.8 | 26.9 | 26.0 |
|                                     | "Мухар олгойн өвчин (K35-K38)"                 | 18.6                               | 17   | 16.9 | 16.7 | 15.4 | 14.6 | 14.1 | 13.5 | 13.1 | 12.6 |
|                                     | "Цөсний хүүдийн өвчнүүд (K80-K81)"             | 14.0                               | 13.7 | 14.2 | 13.8 | 14.2 | 14.3 | 14.6 | 13.6 | 13.2 | 13.4 |
| Зүрх-судасны тогтолцооны өвчин      | "Даралт ихсэх өвчнүүд (I10-I15)"               | 32.1                               | 33.2 | 34.4 | 36.6 | 36.8 | 37.7 | 37.6 | 38.5 | 40.2 | 39.7 |
|                                     | "Зүрхний ишеми өвчнүүд (I20,I23-I25)"          | 29.3                               | 30.1 | 29.5 | 26.6 | 26   | 26.1 | 26.7 | 24.6 | 23.6 | 24.3 |
| Мэдрэлийн тогтолцооны өвчин         | "Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг ( G50-59)" | 22.1                               | 24.3 | 26   | 26.7 | 28.8 | 30.9 | 33.8 | 27.7 | 34.8 | 36.4 |
|                                     | Эпилепси (G40-G41)                             | 11.7                               | 11.2 | 10.9 | 13.3 | 12.6 | 12.1 | 11.4 | 11.4 | 11.1 | 10.6 |

Уушгиний хатгаа өвчин 2007 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 40.5 хувийг эзэлж байсан бол 2016 онд 52.4 болж өссөн байна.

2007 онд хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний өвчлөл 25.1 хувийг эзэлж байсан бол 2016 онд элэгний өвчлөл 26.0 хувь болж 0.9 хувиар өссөн байна.

Зүрхний ишеми өвчин нь 2007 онд зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 29.3 хувийг эзэлж байсан бол 2016 онд 24.3 болж 5.0 хувиар буурсан байна.

**7.7. ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГИЙН ТАЛААР**

2016 оны байдлаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 417 241 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 59.0 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад 13.2 хувиар нэмэгдсэн байна. Нийт үзлэгт хамрагдсан хүн амын 42.0 хувь нь эрэгтэй, 58.0 хувь нь эмэгтэй байна. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүмүүсийг биеийн жингийн индексийн үзүүлэлтээр авч үзвэл 4.2 хувь туранхай, 49.4 хувь нь хэвийн, 33.1 хувь нь илүүдэл жинтэй, 13.3 хувь нь тарган буюу 30кг/м.кв-аас дээш гарсан байна. Мөн үзлэгт хамрагдагсдын 59.2 хувь нь эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулсан тусгай дуудлагаар хамрагдсан бол 19.1 хувь нь өөрийн хүсэлтээр, 8.5 хувь нь зар сурталчилгаагаар ирсэн байна.

Эрт илрүүлгийн үзлэгийн үр дүнгийн үзүүлэлтээр 86.4 хувь хэвийн, 13.2 хувь нь артерийн даралтай байж болох гэж давтан үзлэгт ирүүлэхээр уригдсан байна. Эрт илрүүлгийн давтан үзлэгт нийт 76 969 хүн хамрагдаж 9 605 буюу нийт үзлэгээс 2.3% нь Артерийн даралт ихсэх өвчний онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 392 223 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 55.5 хувийг эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр хэвийн 95.5%, өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй 4.5% илэрч хоёрдогч шатлалын эмнэлэгт онош батлуулахаар илгээсэн байна. Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалтын хувийг хүйсээр авч үзэхэд үзлэгт хамрагдвал зохих нийт эрэгтэй хүн амын 42.0 хувь, эмэгтэй

хүн амын 58.0 хувь нь эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. Чихрийн шижин эрт илрүүлгийн үзлэгээс онош батлуулахаар хоёрдогч шатлалын эмнэлэгт 29 494 хүн ирснээс 1 123 хүн буюу нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 0.3 хувь нь чихрийн шижин хэв шинж 2 өвчний тохиолдол батлагдсан байна.

**Хүснэгт 7.7.1. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хүний тоо, аймгаар, 2015-2016 оны байдлаар**

| Аймаг, хот            | Артерийн гипертензи<br>эрт илрүүлэг үзлэг |             |                      |            | Чихрийн шижин хам шинж 2<br>эрт илрүүлэг үзлэг |             |                      |            |
|-----------------------|-------------------------------------------|-------------|----------------------|------------|------------------------------------------------|-------------|----------------------|------------|
|                       | Хамрагдсан хувь                           |             | Онош батлагдсан хувь |            | Хамрагдсан хувь                                |             | Онош батлагдсан хувь |            |
|                       | 2015                                      | 2016        | 2015                 | 2016       | 2015                                           | 2016        | 2015                 | 2016       |
| Архангай              | 54.7                                      | 56.8        | 9.2                  | 6.6        | 55.5                                           | 60.2        | 0.2                  | 0.2        |
| Баян-Өлгий            | 38.6                                      | 32.9        | 21.5                 | 12.5       | 29.5                                           | 22.6        | 1.1                  | 0.7        |
| Баянхонгор            | 61.2                                      | 67.6        | 2.3                  | 1.8        | 59                                             | 66.5        | 0.0                  | 0.1        |
| Булган                | 52.5                                      | 63.6        | 1.5                  | 1.5        | 53.4                                           | 65.2        | 0.1                  | 0.1        |
| Говь-Алтай            | 28.8                                      | 50.5        | 3.1                  | 5.3        | 28.1                                           | 52.1        | 0.3                  | 0.2        |
| Говь-Сүмбэр           | 34.8                                      | 24.0        | 1.8                  | 2.6        | 28.1                                           | 20.4        | 0.2                  | 0.4        |
| Дархан-Уул            | 95.5                                      | 81.9        | 0.8                  | 1.7        | 93.4                                           | 80.8        | 0.3                  | 0.3        |
| Дорноговь             | 90.1                                      | 97.4        | 2.2                  | 1.8        | 89.9                                           | 92.2        | 0.2                  | 0.3        |
| Дорнод                | 83.6                                      | 90.9        | 3.8                  | 2.2        | 76.7                                           | 89.9        | 0.2                  | 0.1        |
| Дундговь              | 59.4                                      | 57.8        | 3.1                  | 2.7        | 60.6                                           | 58.4        | 0.2                  | 0.2        |
| Завхан                | 41.2                                      | 41.0        | 5.1                  | 4.6        | 36                                             | 33.9        | 0.2                  | 0.6        |
| Орхон                 | 53.1                                      | 51.9        | 2.1                  | 2.2        | 46.3                                           | 47.9        | 0.2                  | 0.3        |
| Өвөрхангай            | 71.7                                      | 83.1        | 3.2                  | 2.2        | 71.8                                           | 83.6        | 0.2                  | 0.2        |
| Өмнөговь              | 47.4                                      | 49.6        | 4.5                  | 3.4        | 48.4                                           | 52.5        | 0.3                  | 0.3        |
| Сүхбаатар             | 84.7                                      | 88.2        | 1.9                  | 2.3        | 84.7                                           | 88.2        | 0.1                  | 0.1        |
| Сэлэнгэ               | 31.9                                      | 33.6        | 6.6                  | 4.6        | 25.3                                           | 23.5        | 0.7                  | 1.0        |
| Төв                   | 80.9                                      | 80.9        | 3.2                  | 1.8        | 74.4                                           | 78.5        | 0.2                  | 0.2        |
| Увс                   | 46.5                                      | 42.9        | 3.7                  | 2.1        | 45.1                                           | 40.9        | 0.3                  | 0.1        |
| Ховд                  | 30.7                                      | 35.0        | 8.0                  | 5.1        | 27.4                                           | 30.8        | 0.7                  | 0.5        |
| Хөвсгөл               | 56.2                                      | 57.6        | 4.9                  | 3.6        | 55.2                                           | 57.9        | 0.1                  | 0.1        |
| Хэнтий                | 58.8                                      | 73.3        | 1.1                  | 1.4        | 58.8                                           | 71.4        | 0.1                  | 0.2        |
| <b>Аймгийн дундаж</b> | <b>58.6</b>                               | <b>61.3</b> | <b>4.0</b>           | <b>3.0</b> | <b>55.8</b>                                    | <b>59.1</b> | <b>0.2</b>           | <b>0.2</b> |
| Улаанбаатар           | 79.9                                      | 56.1        | 2.8                  | 1.5        | 70.6                                           | 50.9        | 0.6                  | 0.4        |
| <b>Улсын дундаж</b>   | <b>65.1</b>                               | <b>59.0</b> | <b>3.5</b>           | <b>2.3</b> | <b>60.3</b>                                    | <b>55.5</b> | <b>0.4</b>           | <b>0.3</b> |

**2016 оны умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн талаар**

2016 оны байдлаар умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт зорилтот насны нийт 73 706 эмэгтэй хамрагдсан нь хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 44.9 хувийг эзэлж байна. Эдгээр хамрагдсан үйлчлүүлэгчдийн 21.9 хувь нь пап эерэг буюу умайн хүзүүний эсийн түвшинд өөрчлөлтэй гарсан байна.

Улсын хэмжээнд 2016 онд умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгийн ПАП шинжилгээний 78 708 сорьцоос: сорьц шаардлага хангаагүй 3.1, хэвийн 73.1, БЗДХ 1.9, пап эерэг 21.9 хувийг эзэлж байгаа ба бусад нь хариу гараагүй хүлээгдэж буй шинжилгээ байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан нийт эмэгтэйчүүдээс үтрээний дурангийн шинжилгээнд 2 033, LEEP эмчилгээнд 182, хавдрын урьдал эмгэгийг эмчлэх эмчилгээг 780 эмэгтэй хийлгэж, умайн хүзүүний хорт хавдрын 68 тохиолдол шинээр бүртгэгдсэн байгаа ба 75.0 хувь эрт үедээ оношлогдсон байна. Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 286 921 эмэгтэйчүүд хамрагдсанаас зорилтот бүлгийн 285 180 эмэгтэй, зорилтот бус бүлгийн 1 741 эмэгтэй хамрагджээ. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 169 маммографи аргаар шинжлүүлж, хөхний өмөнгийн өндөр эрсдэлт бүлгийн 204 эмэгтэй, эсийн шинжилгээ 41 эмэгтэйд авчээ. Хөхний хорт хавдрын 15 шинэ тохиолдол илэрснээс 66.7 хувь нь эрт үедээ оношлогдсон байна.

*Эх үүсвэр: Хавдар судлалын үндэсний төв*

## 7.8. МЭС ЗАСЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Улсын хэмжээнд 2016 онд 180 463 өвчтөнд мэс заслын эмчилгээ хийгдсэн бөгөөд 82.1 хувь нь Улаанбаатар хотод, 17.9 хувь нь хөдөө орон нутагт хийгджээ. Нийт мэс заслын эмчилгээний 15.8 хувь буюу 28 513 тохиолдолд 15 хүртэлх насны хүүхдэд хийгдсэн байна.

### Хүснэгт 7.8.1. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын хагалгааны тоо, 2016 он

| Мэс заслын нэр                                         | Мэс засал хийлгэсэн хүний тоо |                                 | Үүнээс              |                 | “Мэс заслын дараах хүндрэл” |                                 | Нас барсан |                                 |
|--------------------------------------------------------|-------------------------------|---------------------------------|---------------------|-----------------|-----------------------------|---------------------------------|------------|---------------------------------|
|                                                        | Бүгд                          | Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд | Дурангийн мэс засал | Давтан хагалгаа | Бүгд                        | Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд | Бүгд       | Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд |
| ЭХЭМҮТ                                                 | 14 432                        | 7 124                           | 172                 | 0               | 57                          | 14                              | 0          | 0                               |
| НЭМГ-ын харъяа улсын эмнэлгүүд                         | 92 963                        | 13 650                          | 1 097               | 420             | 3                           | 0                               | 18         | 0                               |
| УНТЭ                                                   | 11 137                        | 26                              | 2 018               | 17              | 17                          | 0                               | 24         | 0                               |
| ГССҮТөв                                                | 8 924                         | 1843                            | 220                 | 3               | 0                           | 0                               | 135        | 20                              |
| УГТЭ                                                   | 6 270                         | 158                             | 713                 | 9               | 24                          | 1                               | 23         | 5                               |
| ЭМСЯ-ны харъяа тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлгүүд | 9 331                         | 585                             | 1122                | 55              | 0                           | 0                               | 0          | 0                               |
| УХТЭ                                                   | 2 215                         | 0                               | 1 010               | 13              | 21                          | 0                               | 8          | 0                               |
| ХСҮТ                                                   | 2 198                         | 16                              | 121                 | 15              | 25                          | 0                               | 24         | 0                               |
| ХӨСҮТ                                                  | 607                           | 53                              | 0                   | 20              | 0                           | 0                               | 0          | 0                               |
| <b>Бүгд</b>                                            | <b>148 077</b>                | <b>23 455</b>                   | <b>6 473</b>        | <b>552</b>      | <b>147</b>                  | <b>15</b>                       | <b>232</b> | <b>25</b>                       |


Дурангийн мэс засал 7 104 өвчтөнд хийгдсэн бөгөөд 63.7 хувийг хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд, 13.2 хувийг шээс бэлгийн тогтолцооны өвчлөлд, 9.5 хувийг эмэгтэйчүүдийн, 13.6 хувь нь бусад эрхтэн тогтолцооны өвчлөлд хийгдсэн байна.

### Зураг 7.8.1. Мэс заслын хагалгааны тоо, аймгаар, 2016 он




**Хүснэгт 7.8.2. Зонхилон хийгдсэн мэс засал, хагалгааны төрлөөр, 2016 он**

|                                                            | Мэс засал хийлгэсэн хүний тоо |              | Дурангийн мэс засал | Давтан хагалгаа | “Мэс заслын дараах хүндрэл” |              | Нас баралт |              |
|------------------------------------------------------------|-------------------------------|--------------|---------------------|-----------------|-----------------------------|--------------|------------|--------------|
|                                                            | Бодит тоо                     | Эзлэх хувь   |                     |                 | Бодит тоо                   | Эзлэх хувь   | Бодит тоо  | Эзлэх хувь   |
| Мэдрэлийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд                  | 2 002                         | 1.1          | 3                   | 2               | 9                           | 4.5          | 80         | 31.5         |
| Дотоод шүүрлийн булчирхайн тогтолцоонд хийгдэх мэс заслууд | 544                           | 0.3          | 0                   | 0               | 4                           | 2.0          | 0          | 0.0          |
| Нүдэнд хийгдэх мэс заслууд                                 | 9 290                         | 5.1          | 34                  | 243             | 0                           | 0.0          | 0          | 0.0          |
| Чихэнд хийгдэх мэс заслууд                                 | 1 528                         | 0.8          | 2                   | 3               | 0                           | 0.0          | 0          | 0.0          |
| Хамар, ам, залгиурт хийгдэх мэс заслууд                    | 69 799                        | 38.7         | 233                 | 166             | 6                           | 3.0          | 1          | 0.4          |
| Амьсгалын эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд           | 909                           | 0.5          | 43                  | 6               | 4                           | 2.0          | 12         | 4.7          |
| Зүрх судасны тогтолцоонд хийгдэх мэс заслууд               | 2 483                         | 1.4          | 1                   | 2               | 6                           | 3.0          | 10         | 3.9          |
| Цус болон тунгалгийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд       | 230                           | 0.1          | 1                   | 3               | 2                           | 1.0          | 3          | 1.2          |
| Хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд   | 27 966                        | 15.5         | 4 527               | 104             | 107                         | 53.2         | 95         | 37.4         |
| Шээсний замд хийгдэх хагалгаанууд                          | 1 992                         | 1.1          | 939                 | 6               | 2                           | 1.0          | 3          | 1.2          |
| Эр бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд                       | 2 559                         | 1.4          | 265                 | 3               | 0                           | 0.0          | 0          | 0.0          |
| Эм бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд                       | 20 564                        | 11.4         | 674                 | 1               | 13                          | 6.5          | 0          | 0.0          |
| Эх барихын ажилбарууд                                      | 21 087                        | 11.7         | 0                   | 33              | 44                          | 21.9         | 3          | 1.2          |
| Яс, булчингийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд             | 13 053                        | 7.2          | 373                 | 12              | 3                           | 1.5          | 22         | 8.7          |
| Гадна эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд               | 6 457                         | 3.6          | 9                   | 7               | 1                           | 0.5          | 25         | 9.8          |
| <b>Бүгд</b>                                                | <b>180 463</b>                | <b>100.0</b> | <b>7 104</b>        | <b>591</b>      | <b>201</b>                  | <b>100.0</b> | <b>254</b> | <b>100.0</b> |

**Зураг 7.8.2. Цочмог мухар олгойн мэс заслын хагалгаа, аймгаар, 2016**

Улсын хэмжээгээр цочмог мухар олгойн үрэвслийн улмаас 11 325 мэс заслын хагалгаа хийгдсэн бөгөөд харъяаллаар авч үзвэл 4 108 тохиолдол буюу 36.3 хувь нь Улаанбаатар хотод хийгджээ.

**Зураг 7.8.3. Цөсний замын мэс заслын хагалгаа, аймгаар, 2016**

Улсын хэмжээгээр цөсний замын 6 940 мэс заслын хагалгаа хийгдсэн бөгөөд харьяаллаар авч үзвэл 2 306 тохиолдол буюу 33.2 хувь нь Улаанбаатар хотод хийгджээ.



## БҮЛЭГ 8.

ХҮН АМЫН  
НАС БАРАЛТ




## БҮЛЭГ 8.

# ХҮН АМЫН НАС БАРАЛТ

1995 оноос хойш хүн амын нас баралтын шалтгаанд зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, өвчлөл ба нас баралтын гадны шалтгаант нас баралт тэргүүлсээр байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нас баралтын 16 181 тохиолдол бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 193 тохиолдлоор буюу 1.2 хувиар буурсан байна. Нийт нас барсан хүний 59.7 хувь нь эрэгтэй, 40.3 хувь эмэгтэй байна. Нийт нас баралтын 4 551 тохиолдол буюу 28.1 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 22.3 хувь нь хоног болоогүй нас баралт байна.

**Зураг 8.1. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2006-2016 он**



2016 онд хүн амын нас баралтын шалтгааны 33.3 хувийг зүрх-судасны тогтолцооны өвчин, 25.6 хувийг хавдар, 15.0 хувийг өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 7.4 хувийг хоол боловсруулах тогтолцооны өвчин, 4.3 хувийг амьсгалын тогтолцооны өвчин эзэлж байгаа бөгөөд нийт нас баралтын шалтгааны 85.4 хувь ногдож байна.

2016 оны нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанаас авч үзвэл жилд дунджаар 5000-5500 гаруй хүн буюу нас барсан 3 хүний нэг нь зүрх-судасны тогтолцооны өвчин, 4000 гаруй хүн хавдараар, 2500 гаруй хүн буюу нас барсан 6 хүний нэг нь өвчлөл ба нас баралтын гадны шалтгаант өвчний улмаас нас барж байна.

2016 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд:

- Зүрх-судасны тогтолцооны өвчин (10 000 хүн амд 17.45)
- Хавдар (10 000 хүн амд 13.41)
- Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан (10 000 хүн амд 7.87)
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин (10 000 хүн амд 3.90)
- Амьсгалын тогтолцооны өвчин (10 000 хүн амд 2.26) орж байна.

Хүн амын нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 63.62, 10 000 эмэгтэй хүн амд 41.52 ногдож байна. Нийт нас баралтад эрэгтэйчүүдийн нас баралтын эзлэх хувь эмэгтэйчүүдээс 1.5 дахин их байна. Нийт нас баралтын 8.1 хувь нь 1 хүртлэх насандаа, 10.1 хувь нь 5 хүртлэх насандаа, 1.4 хувийг 5-14 насны хүүхдийн эндэгдэл эзэлж байна.

ДЭМБ-аас нас баралтын хэтийн төлөвийг 2008 онд тооцоолсноор 2030 онд дэлхийн хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан нь зүрхний ишемийн өвчин, тархины судасны өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин, амьсгалын доод замын халдварууд, замын осол гэмтэл байх тооцоо гарсан байна.

#### **Хүснэгт 8.1. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2016 он**

|                    | Нийт өвчлөл  | Зүрх-судасны тогтолцооны өвчин | Хавдар       | Гэмтэл хордлого ба гадны шалтгаант нас баралт | Хоол боловсруулах тогтолцооны өвчин | Амьсгалын тогтолцооны өвчин |
|--------------------|--------------|--------------------------------|--------------|-----------------------------------------------|-------------------------------------|-----------------------------|
| <b>Хүйс</b>        |              |                                |              |                                               |                                     |                             |
| Эрэгтэй            | 63.62        | 20.54                          | 15.18        | 12.73                                         | 4.25                                | 2.66                        |
| Эмэгтэй            | 41.52        | 14.46                          | 11.70        | 3.17                                          | 3.56                                | 1.88                        |
| <b>Насны бүлэг</b> |              |                                |              |                                               |                                     |                             |
| 20 хүртэл          | 17.56        | 0.32                           | 0.41         | 3.92                                          | 0.51                                | 2.58                        |
| 20-44              | 19.87        | 3.59                           | 2.41         | 8.87                                          | 1.79                                | 0.53                        |
| 45-65              | 105.67       | 37.17                          | 34.55        | 14.21                                         | 9.27                                | 2.70                        |
| 65 ба түүнээс дээш | 521.22       | 253.60                         | 167.60       | 7.66                                          | 37.02                               | 16.44                       |
| <b>Байршил</b>     |              |                                |              |                                               |                                     |                             |
| Хот                | 52.21        | 14.07                          | 12.30        | 9.03                                          | 4.04                                | 2.30                        |
| Хөдөө              | 53.69        | 20.32                          | 14.35        | 6.88                                          | 3.78                                | 2.23                        |
| <b>Бүсээр</b>      |              |                                |              |                                               |                                     |                             |
| Баруун             | 52.17        | 19.88                          | 15.20        | 5.25                                          | 2.90                                | 2.59                        |
| Хангайн            | 56.04        | 22.57                          | 14.08        | 7.43                                          | 3.27                                |                             |
| Төв                | 51.99        | 18.12                          | 13.71        | 7.45                                          | 4.37                                | 2.35                        |
| Зүүн               | 53.65        | 18.14                          | 14.87        | 7.49                                          | 5.71                                | 2.30                        |
| <b>Улсын дүн</b>   | <b>53.01</b> | <b>17.45</b>                   | <b>13.41</b> | <b>7.87</b>                                   | <b>3.90</b>                         | <b>2.26</b>                 |

## 8.1. ЗҮРХ-СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас жил бүр 5000-5500 хүн буюу 3 хүний нэг нь нас барж байгаа бөгөөд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

2016 онд зүрх-судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 20.54, 10 000 эмэгтэй хүн амд 14.46 ногдож байна.

Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин хангайн болон баруун бүсэд өндөр, төвийн бүсийн аймгуудад бага байна.

Шалтгаанаар тооцсон зүрх-судасны өвчний шалтгаант нас баралтын түвшинг насны бүлэг, хүйсээр харьцуулбал 45-64 насны бүлгийн эрэгтэйчүүдийн дунд 10 000 хүн амд ногдох зүрхний ишемийн өвчин 25.8, тархинд цус харвалт 19.8, цусны даралт ихсэх өвчин 1.3 ногдож байгаа бөгөөд тухайн насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшинтэй харьцуулбал зүрхний ишемийн өвчний нас баралт 4.7 дахин, тархинд цус харвалтын өвчний шалтгаант нас баралт 2.0 дахин өндөр, цусны даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт 1.4 дахин их байна. (Хүснэгт 8.1.1)

Тархинд цус харвах өвчин Монгол эрэгтэйчүүдийн нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа бөгөөд 2016 оны байдлаар 10 000 хүн амд 6.2 ногдож байгаа нь өмнөх оноос 0.3-оор буурсан байна. 2003 оныг хүртэл зүрхний ишеми, тархинд цус харвалтын шалтгаант нас баралтын түвшин ойролцоо байсан бол 2012 оноос тархинд цус харвах өвчний шалтгаант нас баралт тэргүүлэх хандлага ажиглагдаж байна.

**Хүснэгт 8.1.1. Шалтгаанаар тооцсон зүрх- судасны тогтолцооны өвчний нас баралтын түвшин, 10 000 хүн амд, /насны бүлгээр/, 2016 он**

|                        | Зүрх-судасны тогтолцооны өвчин | Тархинд цус харвалт | Даралт ихсэх өвчин | Зүрхний ишеми өвчин |
|------------------------|--------------------------------|---------------------|--------------------|---------------------|
| <b>Нийт нас баралт</b> | <b>17.45</b>                   | <b>5.47</b>         | <b>0.58</b>        | <b>8.03</b>         |
| 20 хүртэл              | 0.3                            | 0.1                 | 0.0                | 0.0                 |
| 20-44                  | 3.6                            | 1.2                 | 0.1                | 1.5                 |
| 45-64                  | 37.2                           | 14.6                | 1.1                | 14.9                |
| 65-аас дээш            | 253.6                          | 65.2                | 9.6                | 129.4               |
| <b>Эрэгтэй</b>         | <b>20.54</b>                   | <b>6.20</b>         | <b>0.52</b>        | <b>9.86</b>         |
| 20 хүртэл              | 0.4                            | 0.1                 | 0.0                | 0.0                 |
| 20-44                  | 5.0                            | 1.5                 | 0.1                | 2.3                 |
| 45-64                  | 56.8                           | 19.8                | 1.3                | 25.8                |
| 65-аас дээш            | 306.6                          | 78.9                | 9.3                | 157.4               |
| <b>Эмэгтэй</b>         | <b>14.46</b>                   | <b>4.76</b>         | <b>0.63</b>        | <b>6.25</b>         |
| 20 хүртэл              | 0.3                            | 0.1                 | 0.0                | 0.0                 |
| 20-44                  | 2.2                            | 0.9                 | 0.1                | 0.7                 |
| 45-64                  | 20.4                           | 10.1                | 0.9                | 5.5                 |
| 65-аас дээш            | 218.9                          | 56.1                | 9.8                | 111.0               |

## 8.2. ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Хорт хавдрын шалтгаант нас баралт нь 1990 оноос хойш хүн амын нас баралтын 2 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байна.

2016 оны байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 25.6 хувийг эзэлж байгаа ба нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 15.18, 10 000 эмэгтэй хүн амд 11.70 ногдож байна.


Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг, гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, уушиг, гуурсан хоолойн хорт

хавдрын нас баралт тэргүүлэх 5 шалтгаан болж байна. 2016 оны байдлаар хорт хавдартай хэмээн оношлогдсон хүн амын 78.8 хувь нь өвчнийхөө III, IV үе шатанд орсон үедээ оношлогдож, нас барсан нийт хүн амын 85.4 хувь нь анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртлэх хугацаанд амьдарсан байна. 2011 онтой харьцуулахад хожуу оношлолтын хувь 0.9 хувиар буурч, анх оношлогдсоноосоо хойш 1 жил хүртэлх хугацаанд амьдарсан хувь 17.9 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 8.2.1.** Зонхилон тохиолдох хорт хавдрын нас баралт /анх оношлогдсоноос хойшхи амьдарсан хугацаа хувиар/, 2016 он




**Зураг 8.2.2.** Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөл /анх оношлогдсон I-IV үе шатандаа/, 2016 он



### 8.3 ГЭМТЭЛ ХОРДЛОГО, ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт сүүлийн жилүүдэд нэмэгдэж, 1990 онд хүн амын нас баралтын 5 дахь, 2000 оноос хойш 3 дахь тэргүүлэх шалтгаан болсоор байна. 10 000 хүн амд ногдох гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт нь 1995 онд 6.0, 2000 онд 7.6, 2007 онд 11.7 болж, бараг 2 дахин нэмэгдсэн байна. Харин 2008 оноос сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд анх удаа гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт буурч, 10 000 хүн амд 9.3, 2009 онд 8.7 болж байсан байна. Харин 2011 онд 11.2 байсан бол 2016 онд 7.87 болж 3.3 промилиор буурсан байна. 2016 онд гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтын 2 431 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 7.87 байна. Хүйсээр авч үзэхэд 79.5 хувь нь эрэгтэйчүүд, 20.5 хувь нь эмэгтэйчүүд байна. 10 000 эрэгтэй хүн амд ногдох нас баралтын түвшин 12.73 байгаа нь эмэгтэйчүүдээс 4.0 дахин их байна.

**Зураг 8.3.** Осол гэмтлийн шалтгаант нас баралтын хэлбэр, хүйсээр, 10 000 хүн амд, 2016 он




Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтыг хэлбэрээр авч үзвэл 19.9 хувь нь зам тээврийн осол, 18.5 хувь нь амиа хорлох, 8.1 хувь нь бусдад хорлогдсон, 53.5 хувь нь бусад ослын шалтгаанаар нас барсан байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт өмнөх оноос 81 тохиолдлоор буурсан байна. Эрэгтэйчүүдийн амиа хорлох, бусдад хорлогдох, зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс их байгаа бөгөөд үзүүлэлтүүдийг 10 000 хүн амд харьцуулан авч үзвэл: амиа хорлосон тохиолдлын тоо 6.1 дахин, хүчирхийлэл, бусдад хорлогдсон тохиолдлын тоо 3.7 дахин, зам тээврийн ослын тохиолдлын тоо 3.1 дахин их байна.

Бусад ослын шалтгаант нас баралтаас архины хордлогын шалтгаант нас баралт 34.6 хувийг эзэлж байгаа ба ус, гал, байгалийн хүчинд өртсөн осол 28.9 хувийг эзэлж байна.

**Зураг 8.3.2.** Осол гэмтлийн өвчлөл, нас баралт, 10 000 хүн амд, 2006-2016 он



**Хүснэгт 8.3.1 Дэлхийн хүн амын нас баралтын 2030 он дахь төлөв байдал, 2016 оны Монгол улсын нас баралтын үзүүлэлттэй харьцуулсан байдал**

| "2030<br>Өвчлөл ба гэмтэл"                            | Нас баралт<br>хувиар | Байр | Байр | Нас баралт<br>хувиар | "2016<br>Өвчлөл ба гэмтэл"                            |
|-------------------------------------------------------|----------------------|------|------|----------------------|-------------------------------------------------------|
| Зүрхний ишеми өвчин                                   | 14.2                 | 1    | 1    | 15.3                 | Зүрхний ишеми өвчин                                   |
| Тархины судасны өвчин                                 | 12.1                 | 2    | 2    | 11.0                 | Тархины судасны өвчин                                 |
| Уушгины архаг бөглөрөлт өвчин                         | 8.6                  | 3    | 17   | 0.7                  | Уушгины архаг бөглөрөлт өвчин                         |
| Амьсгалын доод замын халдварууд                       | 3.8                  | 4    | 6    | 3.6                  | Амьсгалын доод замын халдварууд                       |
| Зам тээврийн осол                                     | 3.6                  | 5    | 7    | 3.0                  | Зам тээврийн осол                                     |
| Гуурсан хоолой, мөгөөрсөн хоолой, уушгины хорт хавдар | 3.4                  | 6    | 9    | 2.2                  | Гуурсан хоолой, мөгөөрсөн хоолой, уушгины хорт хавдар |
| Чихрийн шижин                                         | 3.3                  | 7    | 16   | 1.0                  | Чихрийн шижин                                         |
| Даралт ихсэх өвчин                                    | 2.1                  | 8    | 15   | 1.1                  | Даралт ихсэх өвчин                                    |
| Ходоодны хорт хавдар                                  | 1.9                  | 9    | 6    | 4.4                  | Ходоодны хорт хавдар                                  |
| ХДХВ/ДОХ                                              | 1.8                  | 10   | 23   | 0.0                  | ХДХВ/ДОХ                                              |
| Бөөрний өвчлөл                                        | 1.6                  | 11   | 13   | 1.5                  | Бөөрний өвчлөл                                        |
| Өөрийгөө санаатайгаар гэмтээх                         | 1.5                  | 12   | 8    | 2.8                  | Өөрийгөө санаатайгаар гэмтээх                         |
| Элэгний хорт хавдар                                   | 1.4                  | 13   | 3    | 10.8                 | Элэгний хорт хавдар                                   |
| Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар                   | 1.4                  | 14   | 18   | 0.7                  | Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар                   |
| Улаан хоолойн хорт хавдар                             | 1.3                  | 15   | 11   | 1.6                  | Улаан хоолойн хорт хавдар                             |
| Хүчирхийлэл                                           | 1.2                  | 16   | 14   | 1.2                  | Хүчирхийлэл                                           |
|                                                       | 1.2                  | 17   | 21   | 0.2                  | Суулгалт өвчин                                        |
| Элэгний хатуурал                                      | 1.2                  | 18   | 4    | 4.6                  | Элэгний хатуурал                                      |
| Хөхний хорт хавдар                                    | 1.1                  | 19   | 19   | 0.3                  | Хөхний хорт хавдар                                    |
| Сүрьеэ                                                | 1                    | 20   | 12   | 1.7                  | Сүрьеэ                                                |
| Нярайн халдвар                                        | 0.9                  | 21   | 22   | 0.0                  | Нярайн халдвар                                        |
| Хугацаанаас өмнө эсвэл бага жинтэй төрөлт             | 0.9                  | 22   | 20   | 0.2                  | Хугацаанаас өмнө эсвэл бага жинтэй төрөлт             |
| Нярайн амьсгалын дутагдал, төрөлтийн гэмтэл           | 0.7                  | 23   | 10   | 1.9                  | Нярайн амьсгалын дутагдал, төрөлтийн гэмтэл           |
| Малария                                               | 0.4                  | 24   | 24   | 0.0                  | Малария                                               |

ДЭМБ-аас нас баралтын хэтийн төлөвийг 2008 онд тооцоолсноор 2030 онд дэлхийн хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан нь зүрхний ишемийн өвчин, тархины судасны өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин, амьсгалын доод замын халдварууд, замын осол гэмтэл байх тооцоо гарсан байна.

2016 оны байдлаар манай улсын нийт нас баралтад эзлэх хувиар зүрхний ишеми өвчин, тархины судасны өвчин болон элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт тэргүүлж байна.



## БҮЛЭГ 9.

МОНГОЛ  
УЛСЫН ЭМЗҮЙН  
САЛБАРЫН  
ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

## БҮЛЭГ 9.


# МОНГОЛ УЛСЫН ЭМЗҮЙН САЛБАРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

### 9.1. ЭМИЙН ИМПОРТ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 73 дугаар тогтоолын дагуу Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд гэсэн хилийн 4 боомтоор эм, эмнэлгийн хэрэгслийг нэвтрүүлж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2016 онд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур ханган нийлүүлэх 224 байгууллагад 5 645 лиценз, улсын хилээр төрийн хяналтан дор нэвтрүүлэх бараанд 21 байгууллагад 148, нийт 5 793 лиценз олгосон байна.

**Зураг 9.1.1.** Эмийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр /2013-2016 он/




2016 онд 214.58 тэрбум төгрөгийн эмийн импорт, 183.00 тэрбум төгрөгийн борлуулалт /бөөний үнээр/ хийсэн нь 2015 оныхтой харьцуулахад эмийн импорт 31.72 тэрбум, эмийн борлуулалт 18.36 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2016 онд 2.33 тэрбум төгрөгийн эмийн түүхий эдийн импорт, 2.14 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оныхтой харьцуулахад эмийн түүхий эдийн импорт 0.71, борлуулалт 0.71 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.



**Зураг 9.1.2. Эмнэлгийн хэрэгслийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр /2013-2016 он/**




2016 онд 75.8 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн импорт, 64.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2015 оныхтой харьцуулахад эмнэлгийн хэрэгслийн импорт 31.3 тэрбум, борлуулалт 26.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2016 онд 11.53 тэрбум төгрөгийн урвалж, 7.78 тэрбум төгрөгийн оношлуур импортлон 10.92 төгрөгийн урвалж, 7.22 тэрбум төгрөгийн оношлуур борлуулсан байна. 19.2 тэрбум төгрөгийн урвалж, оношлуурын импорт, 18.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2015 оныхтой харьцуулахад импорт 1.1, борлуулалт 1.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

## 9.2. ЭМИЙН БҮРТГЭЛ

Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхитэй эмээр хангах зорилгоор эмийг бүртгэх үйл ажиллагаа Монгол улсад 1994 оноос хэрэгжиж эхэлсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасныг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2015 оны 13 дугаар тушаалаар батлагдсан “Эм, эмийн түүхий эдийг бүртгэх журам”-ын дагуу эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.


**Зураг 9.2.1. Монгол улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эмийн тоо, 1996-2016 он**



2016 онд 623 нэрийн эм шинээр бүртгэж, 321 нэрийн эм, 4 эмийн түүхий эдийн бүртгэлийн хугацааг сунган, 475 нэрийн эм, 1 нэрийн эмийн түүхий эдийн бүртгэлд өөрчлөлт оруулж, 17 нэрийн эмийг бүртгэлээс хассан байна. Үүнээс импортын 386 эм, уламжлалт 75 эм, эх орны 162 эм, 24 түүхий эдийг шинээр бүртгэсэн байна.

Түүнчлэн 2016 онд шинээр 141 оношлуур, 208 нэрийн биологийн идэвхит бүтээгдэхүүн бүртгэгдсэн байна.

**Зураг 9.2.2. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, түүхий эдийн тоо /2012-2016 он/**




2016 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 4 722 нэрийн эм, 241 нэрийн эмийн түүхий эд, 1 432 нэрийн биологийн идэвхит бүтээгдэхүүн, 466 нэрийн оношлуур бүртгэлтэй байна.

Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэлтэй эмийг 2016 оны байдлаар АТС ангиллаар авч үзвэл:


- J /Ерөнхий халдваргүйжүүлэх бэлдмэл/ - 686
- A /Хоол боловсруулах замын өвчинд хэрэглэх эм/ - 571
- C /Зүрх судасны өвчинд хэрэглэх эм/ - 427
- N /Төв мэдрэлийн системд хэрэглэх эм/ - 377
- R /Амьсгалын замын өвчинд хэрэглэх эм/ - 336
- M /Булчин, араг ясны системд хэрэглэх эм/ - 213
- B /Цус, цусны эрхтэн системд хэрэглэх эм/ - 298
- G /Шээс бэлгийн замд хэрэглэх эм, бэлгийн гормон/ - 208
- D /Арьсны өвчинд хэрэглэх эм/ - 181
- S /Мэдрэхүйн эрхтэнд хэрэглэх эм/ - 135
- T /Уламжлалт эм/ - 706
- L /Хавдрын эсрэг эм/ - 221
- V /Бусад/ - 79
- H /Гормоны бэлдмэл/ 57 бүртгэлтэй байна.

**Зураг 9.2.3. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, АТС ангиллаар, 2011-2016**



Эх орны эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний бүртгэл сүүлийн 3 жилд нэмэгдэж ирсэн бөгөөд Монгол улсад бүртгэлтэй нийт эмэнд эх орны эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувь 2016 онд 24.7 хувь болж, өмнөх оныхоос 7.1 хувиар өссөн байна.

**Зураг 9.2.4. Эмийн бүртгэлд эх орны эмийн бүтээгдэхүүний эзлэх хувь /2012–2016 он/**



### 9.3. ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

2016 онд дотоодын 11 эмийн үйлдвэр 368 нэр төрлийн 31.115 тэрбум төгрөгийн эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэсэн байна.

Үүнд:

- Европ эм - 263 нэрийн 29.801.294.727 төгрөгийн
- Уламжлалт эм - 73 нэрийн 506.343.880 төгрөгийн
- Ариутгал, халдваргүйтгэлийн бодис-32 нэр төрлийн 808.345.900 төгрөгийн бүтээгдэхүүн тус тус үйлдвэрлэсэн байна.

### 9.4. ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх журам”-ын дагуу эмийн гаж нөлөөг мэдээлэх, бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

2016 онд эмийн гаж нөлөөний 223 тохиолдлыг мэдээлсэн ба 2016 оны 12 сарын 31-ний байдлаар гаж нөлөөний мэдээний санд нийт 691 тохиолдол бүртгэгдсэн байна.

**Хүснэгт 9.4.1. Эмийн гаж нөлөөний болон мэдээлсэн эмнэлгийн тоо, 2012-2016 он**

| Үзүүлэлт                              |                                          | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---------------------------------------|------------------------------------------|------|------|------|------|------|
| Улаанбаатар хотын эмнэлэг, эмийн сан  | Мэдээлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 8    | 14   | 11   | 5    | 16   |
|                                       | Гаж нөлөөний тоо                         | 57   | 111  | 98   | 44   | 117  |
| Хөдөө орон нутгийн эмнэлэг, эмийн сан | Мэдээлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 2    | 7    | 7    | 8    | 6    |
|                                       | Гаж нөлөөний тоо                         | 8    | 66   | 60   | 24   | 106  |
| Нийт                                  | Мэдээлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 10   | 21   | 18   | 13   | 22   |
|                                       | Гаж нөлөөний тоо                         | 65   | 177  | 158  | 68   | 223  |

### 9.5. ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 8-р бүлэгт заасны дагуу эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр:

1. 6 удаагийн танхимын, 3 удаагийн теле сургалт зохион байгуулсан ба сургалтанд нийт 1017 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.
2. 479 нэрийн бүртгэлтэй эмийн хэрэглэх заавар баталгаажуулсан. /импортын 455, үндэсний үйлдвэрийн 24/,
3. 17 нэрийн эмийн зар сурталчилгааны агуулгыг хянаж, зөвшөөрөл олгосон байна.


## БҮЛЭГ 10.

# ЦУСНЫ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цус сэлбэлт судлалын үндэсний төв (ЦССҮТ) нь 2016 онд “Үйлчлүүлэгчээ дээдэлж, чанарыг эрхэмлэе” уриан дор үйл ажиллагаагаа төлөвлөн, эрүүл мэндийн байгууллагуудыг аюулгүй цус, цусан бүтээгдэхүүнээр ханган ажиллалаа. ЦССҮТ-д чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлтгэл ажлыг ханган, нийт эмч, ажилчдад чанарын тогтолцооны талаарх шат дараалсан сургалтуудыг зохион байгуулж, уг стандартын шаардлагуудыг үе шаттайгаар нэвтрүүлж байна. 2016 он Цусны албаны хэмжээнд түүхэнд тод тэмдэглэгдэх шинэчлэлтийн жил боллоо. ЦССҮТ-ийн шинэ барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд орж Баянзүрх, Сүхбаатар, Баянгол дүүргүүдэд Цус цуглуулах 3 суурин төв ажиллаж байна. Түүнчлэн орон нутгийн Цусны салбар төвүүд(ЦСТ)-ийг АХБ-ны 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн засварлалаа. АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй ЭМСХХ-5 төслөөр ЦССҮТ болон орон нутгийн ЦСТ-ийг цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх зориулалтын тоног төхөөрөмжөөр хангаснаар Цусны албаны үйл ажиллагаа олон улсын стандартын шаардлагад нийцэх боломж бүрдлээ. Мөн ЭМСХХ-5 төслийн хүрээнд Цусны албаны мэдээлэл, удирдлагын систем буюу B-SIMS (BLOOD SERVICE INFORMATION MANAGEMENT SYSTEM)-ийг суурилуулах ажлыг эхлүүлснийг онцолж байна.

2016 онд ЦССҮТ-ийн цус өгөлтийн тоо 2012 онд 14 919 байсан бол 2016 онд 25 380 болж 70.1 хувь, ЦСТ-д 2012 онд 5 935 байсан бол 2016 онд 7 586 болж 27.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Цусны албаны хэмжээнд цус өгөлтийн тоо 2012 оноос 58 хувиар өслөө. (Зураг 1)


**Зураг 10.1. Доноруудын цус өгөлтийн тоо, сонгосон онуудаар**



2016 онд 1 000 хүн ам тутамд цус өгөлтийн тоо Улаанбаатар хотод 18.4, хөдөө орон нутагт 4.5 болсон байна. (Зураг 2)

ДЭМБ-ийн зөвлөмжид нийт хүн амын дунд донорын эзлэх хувь 1.5 хувь байхад тухайн орны цусны хэрэгцээг бүрэн хангах боломжтой гэж үздэг. Монгол улс 2016 онд нийт хүн амын дунд донорын эзлэх хувийг 1.1 хувьд хүргэж чадсан байна. / Улаанбаатар-1.8 хувь, орон нутаг- 0.4 хувь/


**Зураг 10.2.** 1 000 хүн ам тутам дахь цус өгөлтийн тоо, сонгосон онуудаар



2012 онд байнгын донорын эзлэх хувь 40.1 хувь байсан бол 2016 онд 52.7 хувь болж, 12.6 хувиар өссөн нь цус цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, чанар аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. (Зураг 3)


2012 онд нийт цусаа бэлэглэгч доноруудын 3.5 хувийг төрөл төрөгсдийн донор эзэлж байсан бол 2016 онд 0 хувь болж 100 хувь сайн дурын авлагагүй донорын эгнээнд нэгдлээ.

**Зураг 10.3.** Цусны албанд цусаа бэлэглэсэн донорын төрөл /хувь/



2016 онд нийт цусаа бэлэглэгч доноруудын 75.4 хувийг 17-39 насныхан эзэлж байна. (Зураг 4)


**Зураг 10.4. Цусны доноруудын насны бүтэц, сонгосон онуудаар**



Цусаа бэлэглэсэн доноруудаас халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь 2016 онд 6.7 хувь болсон байна. (Зураг 5)

Олон талт хэлбэрээр сургалт сурталчилгааг явуулснаар ард иргэдийн дундах донорын талаарх мэдлэг, хандлага, дадал сайжирч байна. Мөн байнгын донорын эзлэх хувь нэмэгдсэн нь халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь буурах гол нөхцөл болжээ.


**Зураг 10.5. Доноруудын цус сэлбэлтээр дамжих халдвараар хасагдалт**



ЦССҮТ-ийн цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2012 онд 40 270 нэгж байсан бол 2016 онд 65 935 нэгж болж 63.7 хувь, ЦСТ 2012 онд 10 576 нэгж байсан бол 2016 онд 15 992 нэгж болж 51.2 хувиар тус тус өссөн байна. Цусны албаны хэмжээнд цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл


2012 оноос 61.1 хувиар нэмэгдсэн байна. (Зураг 6)

**Зураг 10.6. Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл /нэгжээр/**



Улсын хэмжээн дэх цус, цусан бүтээгдэхүүний 81 хувийг ЦССҮТ-д үйлдвэрлэж байна. (Зураг 7)

**Зураг 10.7. ЦССҮТ болон ЦСТ-ийн ЦЦБ үйлдвэрлэл**



2016 онд улаан эсийн бүтээгдэхүүнийг глицеринжүүлэн хөлдөөж удаан хугацаагаар хадгалах, цус цусан бүтээгдэхүүний эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэх, рентген туяагаар шарах зэрэг шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. Эдгээр шинэ технологийг нэвтрүүлснээр хөлдөөж угаасан улаан эс, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэн, ялтаст эсийн өтгөрүүлэг, туяагаар шарсан улаан эсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нэр төрлийг нэмэгдүүлж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.





## БҮЛЭГ 11.

ЭРҮҮЛ  
МЭНДИЙН  
ЭДИЙН ЗАСАГ


# БҮЛЭГ 11.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГ

Энэхүү бүлгийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлын мэдээлэлд үндэслэн боловсруулав.

### 11.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**Зураг 11.1.1. ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь**



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс; ҮСХ


Үндэсний статистикийн хорооноос дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцохдоо 2006, 2010, 2014 онуудад нийт 3 удаа тодотгол хийж, дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлогыг тооцох аргачлалыг 2007, 2013 онуудад тус тус шинэчлэн баталж, нийт 5 удаагийн өөрчлөлт хийсэн байдаг.

Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлогыг тооцох шинэчилсэн аргачлал болон тодотгол хийсэн тооцооллоор дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ өссөн байна.


Шинэчлэн тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувийг тооцож үзэхэд хуучин тооцооллуудаас буурсан дүнтэй байна.

Эрүүл мэндийн салбарын зардлын ерөнхий хандлага мөнгөн дүнгээрээ өсч байна. 2016 онд Эрүүл мэндийн салбарын нийт зардлын ДНБ-д эзлэх хувь 2.8 хувь байна.

**Зураг 11.1.2.А. Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөгөөр)**



**Зураг 11.1.2.Б. Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (хувиар)**



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс


2016 оныг 2015 онтой харьцуулахад хөрөнгийн зардал, эмийн зардлаас бусад зардал буурсан байна.

Хөрөнгийн зардлын хувьд, 2013 онд өмнөх оноос 3.3 дахин буурч, 2014 онд 2013 онтой харьцуулахад 4.8 дахин өсч, 2015 онд 2014 онтой харьцуулахад 1.7 дахин буурч, 2016 онд 2015 онтой харьцуулахад 1.6 дахин өссөн байна.

Засгийн газрын дотоод шилжүүлгийн зардалд 2012 он хүртэл “Нэг иргэнд нормативаар тооцсон зардал” буюу өрхийн эрүүл мэндийн төвийн зардлыг авч үзсэн. Харин 2013 оноос тус зардалд “Төсвийн тухай хууль”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу сумын эрүүл мэндийн төв болон орон нутаг дахь биеийн тамир, спортын хороо, клубуудын зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор эрс өссөн.

2016 онд спортыг эрүүл мэндийн салбараас салгаж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд шилжүүлсэн. 2016 онд 2015 онтой харьцуулахад 1.2 дахин буурсан байна.


**Зураг 11.1.3. Эрүүл мэндийн салбарын зардал, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (хувиар)**



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Сүүлийн хоёр жилийн үзүүлэлтээс харахад эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь 2015 онд 86.2 хувь байгаа бол 2016 онд 82.7 болж 3.5 хувиар буурсан, хөрөнгийн зардал 2015 онд 10.8 хувь байсан бол 2016 онд 17.3 хувь болж 6.5 хувиар өссөн дүнтэй байна. 2016 онд спортын салбарыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд шилжүүлсэн.

**Зураг 11.1.4. Эрүүл мэндийн зардал, дэд бүлгээр (хувиар)**



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс


Эрүүл мэндийн зардлыг дэд бүлгээр авч үзвэл, 2015 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд<sup>1</sup> нийт санхүүжилтийн 87.5 хувийг зарцуулж байсан бол 2016 онд 89.5 хувь болж 2 хувиар өссөн, эрүүл мэндийн удирдлагын зардал<sup>2</sup> 2015 онд 8.6 хувь байсан бол 2016 онд 9.3 хувь болж 0.7 хувиар нэмэгдсэн, төсөл, хөтөлбөрийн зардалд<sup>3</sup> 3.9 хувиас 1.2 хувь болж 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 2 жилд Засгийн газрын тусгай сангууд дээр зардал гараагүй байна.

<sup>1</sup>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, түргэн тусламжийн төв, НЭМГ-ын харьяа бусад эмнэлэг, орон нутаг дахь уламжлалт анагаах ухааны төв, рашаан сувилал, орон нутаг дахь зоонозын өвчин судлалын төв, БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, УАУТХ, шим тэжээлийн сорилтын лаборатори, эмийн сорилтын лаборатори, хор судлалын лаборатори, хор судлалын лабораторийн зардлыг,


<sup>2</sup>Эрүүл мэндийн удирдлагын зардалд ЭМЯ, ЭМХТ, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын зардлыг

<sup>3</sup>Хавдар судлалын эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл /Австри/, Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-4.5, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл /Австри/, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх /Австри/төслийн зардлыг тус тус оруулж тооцсон болно.

**Зураг 11.1.5.А. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, тусламж, үйлчилгээний шатлалаар (тэрбум төгрөгөөр)**



**Зураг 11.1.5.Б. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, тусламж, үйлчилгээний шатлалаар (хувиар)**



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг тусламж, үйлчилгээний шатлалаар авч үзвэл, сүүлийн 6 жилийн хугацаанд анхдагч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардал<sup>4</sup> жилд дунджаар 8.6 хувиар, хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардал<sup>5</sup> жилд дунджаар 12.3 хувиар, гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардал<sup>6</sup> 11.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Мөн сүүлийн 6 жилийн динамикаар харвал анхдагч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардалд 25.1-29.3 хувийг, хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардалд 35.0-36.7 хувийг, гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардалд 35.3-39.2 хувь бусад байгууллагын зардалд зарцуулсан байна. 2016 оноос бусад байгууллагыг Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газарт шилжүүлсэн<sup>7</sup> байна.

<sup>4</sup>Анхдагч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардалд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн зардлыг,


<sup>5</sup>Хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардалд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, түргэн тусламжийн төв, НЭМГ-ын харьяа бусад эмнэлэг, орон нутаг дахь уламжлалт анагаах ухааны төв, рашаан сувилал, орон нутаг дахь зоонозын өвчин судлалын төвийн зардлыг,

<sup>6</sup>Гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зардалд БОЭТ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, УАУХ-гийн зардлыг,


<sup>7</sup>Бусад байгууллагын зардалд шим тэжээлийн сорилтын лаборатори, эмийн сорилтын лаборатори, хор судлалын лабораторийн зардлыг тус тус оруулан тооцсон.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд анхдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагын зардлын эзлэх хувь 2015 онд 26.6 хувь байсан бол 2016 онд 25.1 хувь болж 1.5 хувиар буурсан, хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагын зардлын эзлэх хувь 2015 онд 36.7 хувь байсан бол 2016 онд 35.7 хувь болж 1.0 хувиар буурсан, гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагын зардлын эзлэх хувь 2015 онд 36.8 хувь байсан бол 2016 онд 39.2 хувь болж 2.4 хувиар өссөн байна.

**Зураг 11.1.6.А. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төрлөөр (тэрбум төгрөгөөр)**




**Зураг 11.1.6.Б. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төрлөөр (хувиар)**



Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Хөрөнгө оруулалтын зардлын 2015 онд 52.1 хувь байсан бол 2016 онд 55.0 хувь болж 2.9 хувиар өссөн, их засвар 2015 онд 4.8 хувь байсан бол 2016 онд 8.4 хувь болж 3.6 хувиар өссөн, авто машин тоног төхөөрөмжийн эзлэх хувь 2015 онд 43.1 хувь байсан бол 2016 онд 36.6 хувь болж 6.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг.11.1.7. Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр (хувиар)**




Эх үүсвэр: ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтэс

Эрүүл мэндийн салбарын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд авч үзвэл, 2014-2016 онуудад гадаад эх үүсвэрээс санхүүжих эх үүсвэр бүртгэгдэж 2014 онд 1.8 хувь байсан бол 2016 онд 9.8 хувь болж өссөн байна. Энэхүү гадаад эх үүсвэрээр төсөл, хөтөлбөр болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэр 2015 онд 66.5 хувь байсан 2016 онд 62.1 хувь болж 4.4 хувиар буурсан, ЭМД-ын сан 2015 онд 23.3 хувь байсан бол 2016 онд

24.9 болж 1.6 хувиар өссөн, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2015 онд 2.9 хувь байсан бол 2016 онд 3.2 хувь болж 0.3 хувиар өссөн, гадаад эх үүсвэрээс санхүүжих 2015 онд 7.4 хувь байсан бол 2016 онд 9.8 хувь болж 2.4 хувиар өссөн байна.

## 11.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ

**Зураг 11.2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал (тэрбум төгрөгөөр)**




Эх үүсвэр: ЭМНДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал жил ахих тусам нэмэгдэх хандлагатай байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын эзлэх хувийг 17 жилийн дунджаар авч үзвэл жилд дунджаар нийт орлогын 72.2 хувийг зарцуулдаг байна. Үүнээс 2007 онд хамгийн бага буюу нийт орлогын 54.8 хувийг 2010 онд хамгийн өндөр буюу 89.1 хувийг тус тус зарцуулсан байна. 2016 онд сангийн орлогын 79.9 хувийг зарцуулсан байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 2015 онд 45.1 тэрбум байсан бол 2016 онд 60.6 тэрбум болж 15.5 тэрбумаар өссөн байна.

**Зураг 11.2.2.А. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, орлогын эх үүсвэрээр (тэрбум төгрөгөөр)**



**Зураг 11.2.2.Б. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, орлогын эх үүсвэрээр (хувиар)**



Эх үүсвэр: ЭМНДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

2011 онд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 121.6 тэрбум байгаагаас 116.5 тэрбум төгрөг нь шимтгэлийн орлогоос<sup>8</sup>, 5.1 тэрбум төгрөг нь орлогын бусад эх үүсвэрээс<sup>9</sup> бүрдсэн бол 2016 онд нийт орлого 302.7 тэрбум төгрөгний байгаагаас 302.5 тэрбум төгрөг нь шимтгэлийн орлогоос,


0.2 тэрбум төгрөг нь бусад орлогоос бүрдсэн байна.

Ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл нь 2016 онд 37.6 хувь нь байна. Удаах орлогын эх үүсвэр нь даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого 2016 онд 37.1 хувьтай байна.

Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл 2011-2015 онд 4.8-9.0 хувь байсан бол 2016 онд нэмэгдэж 14.7 хувь болж 5.7 хувиар өссөн байна. Өсөлтөд амьжиргааны түвшин доогуур иргэдийг төр хариуцаж эхэлсэн болон 2016.01.01-нээс шимтгэлийн хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувь болж өссөн нь нөлөөлсөн.

Акт төлбөрийн орлого<sup>10</sup> 2016 онд 0.1 хувьтай байна. Сангийн чөлөөт үлдэгдлийн банкинд хадгалуулсны хүү 2016 онд 10.5 хувьтай байна.

### Зураг 11.2.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал (хувиар)



Эх үүсвэр: ЭМНДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Эрүүл мэндийн даатгалын сангийн сүүлийн 2 жилийн үзүүлэлтээс харахад 96.6-98.1 хувь эрүүл мэндийн даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний зардал эзэлж байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд нийт зардлын 1.6-2.0 хувийг зарцуулсан байна. Бусад зардал 2015 онд 1.4 хувь байсан бол 2016 онд 0.3 хувь болж 1.1 хувиар буурсан байна.


<sup>8</sup>Шимтгэлийн орлогод даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл, акт төлбөрийн орлогыг,

<sup>9</sup>Бусад эх үүсвэрт сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хэтрүүлсэнд ногдуулсан алданги болон торгууль, залруулга хийгдсэн орлого, шилжүүлсэн орлого гэх мэт орлогыг оруулан тооцно.

<sup>10</sup>Акт төлбөрийн орлого гэдэг нь эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг зөрчсөн байгууллага, холбогдох албан тушаалтанд даатгалын байцаагчийн тавьсан актын дагуу төлөх шимтгэл, төлбөр



**Зураг 11.2.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний зардал, даатгалын тусламж, үйлчилгээний ангилалаар (хувиар)**



Эх үүсвэр: ЭМНДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг тусламж, үйлчилгээний ангиллаар авч үзвэл, 53.8-66.3 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд, 15.2-17.7 хувийг амбулаторийн тусламж, үйлчилгээнд, 6.9-10.7 оношилгоо, шинжилгээнд, 3.4-10.9 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд, 6.4 хувийг өндөр өртөгтэй зарим тусламж үйлчилгээнд, сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 2.7-4.2 хувийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд, 1.7-2.6 хувийг өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээнд, 1.3-1.8 хувийг уламжлалт эмчилгээнд, 0.01-0.1 хувийг хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд тус тус зарцуулсан байна.

Мөн 2012 онд даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний нийт зардлын 5.6 хувийг “Эрүүл хүүхэд” аянд, 2013 онд мөн зардлын 0.01 хувь, 2014 онд 0.4 хувь, 2015 онд 0.8 хувийг дараалсан 3 жилийн хугацаанд тусламж, үйлчилгээний зардал гаргаагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах үйлчилгээнд, 2016 онд 0.008 хувийг удааны хугацааны нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг санхүүжүүлж эхлэхэд тус тус зарцуулсан байна.

**Хүснэгт 11.2.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид үзүүлэх хэвтүүлэн эмчлэх болон өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээний зардал, (хамгийн өндөр зардал бүхий 10 оношийн бүлэг), 2016 он**

| Байр | Оношийн бүлгийн нэр                                                   | Хүний тоо<br>(мянган хүн) | Мөнгөн дүн<br>(тэрбум төгрөг) |
|------|-----------------------------------------------------------------------|---------------------------|-------------------------------|
| 1    | Хатгаа, уушгины үрэвсэл                                               | 48.4                      | 11.5                          |
| 2    | Даралт ихсэх өвчнүүд                                                  | 37.7                      | 9.5                           |
| 3    | Бөөр, шээсний замын үрэвсэл, нефрит                                   | 40.5                      | 8.8                           |
| 4    | Амьсгалын замын үрэвсэлт өвчнүүд                                      | 24.8                      | 5.6                           |
| 5    | Мэдрэлийн тогтолцооны бусад эмгэг                                     | 21.8                      | 4.5                           |
| 6    | Нуруу, үе мөчний ба бусад эд эрхтэний гэмтэл бэртлийн үеийн мэс засал | 8.8                       | 4.0                           |
| 7    | Зүрхний шигдээс, ишеми эмболизм, перикардит                           | 14.3                      | 3.6                           |
| 8    | Артрит, артропати, үе холбох эдийн бусад эмгэг                        | 13.4                      | 3.1                           |
| 9    | Элэгний архаг үрэвсэл ба бусад эмгэг                                  | 13.7                      | 3.1                           |
| 10   | Халдварын бус ходоод гэдэсний үрэвсэлт өвчин                          | 11.5                      | 3.0                           |
|      | <b>Нийт</b>                                                           | <b>234.8</b>              | <b>56.8</b>                   |

Эх үүсвэр: ЭМНДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

2016 оны байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ болон өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээний нийт зардалд 11.2.1-д үзүүлсэн 10 оношийн бүлгийн зардал хамгийн их зардлыг эзэлж байна.

Зардлын хувьд эхний 10 байранд орж буй оношийн бүлгийн нийт зардал, тухайн тусламж үйлчилгээнд олгосон нийт нийт зардлын 50 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 1. Эрүүл мэндийн сайдын баацын санхүүжилтийн үндсэн үзүүлэлт**

| Үзүүлэлт                                           | 2006        | 2007        | 2008        | 2009        | 2010        | 2011         | 2012         | 2013         | 2014         | 2015      | 2016         |
|----------------------------------------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|-----------|--------------|
| ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр (сая.төг)*    | 4 027 558.6 | 4 956 647.2 | 6 555 569.4 | 6 590 637.1 | 9 756 588.4 | 13 173 763.4 | 16 688 419.6 | 19 174 242.6 | 22 227 054.3 | 66,779.1  | 23,886,409.5 |
| Эрүүл мэндийн салбарын нийт зардал (сая.төг)       | 103 168.0   | 155 400.0   | 211 497.1   | 206 429.3   | 250 264.7   | 333 702.5    | 424 387.9    | 415 823.8    | 584 164.7    | 581,851.5 | 657,478.0    |
| ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь    | 2.6         | 3.1         | 3.2         | 3.1         | 2.6         | 2.5          | 2.5          | 2.2          | 2.6          | 2.5       | 2.8          |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (төг)         | 40 029.1    | 43 092.0    | 79 529.7    | 76 183.0    | 90 732.5    | 119 764.5    | 149 447.6    | 143 436.4    | 197 145.6    | 192,229.2 | 217,214.3    |
| <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр (сая төгрөг)</b> |             |             |             |             |             |              |              |              |              |           |              |
| Улсын төсвөөс                                      | 74 843.5    | 118 900.0   | 167 680.3   | 154 356.2   | 183 939.8   | 236 443.9    | 310 604.8    | 318 346.3    | 438 232.1    | 386,847.1 | 409,356.7    |
| ЭМД-ын сангаас                                     | 24 196.6    | 31 400.0    | 38 212.4    | 45 086.7    | 59 457.4    | 65 127.3     | 85 955.7     | 85 133.5     | 122 842.7    | 135,363.3 | 164,436.8    |
| Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос       | 5 462.5     | 4 500.0     | 6 178.5     | 5 630.0     | 8 199.1     | 9 467.8      | 11 073.2     | 12 339.1     | 21 351.3     | 16,995.7  | 20,769.2     |
| Гадаад эх үүсвэрээс                                | -           | -           | -           | -           | -           | -            | -            | -            | 10 850.8     | 42,821.2  | 64,757.9     |

Тайлбар: \* ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан /www.1212.mn/stat.html/stat.html.do

**Хүснэгт 2. Эрүүл мэндийн салбарын зардал, эдийн засгийн ангиллаар (сая төгрөг)**

| Эдийн засгийн ангилал                | 2006      | 2007      | 2008      | 2009      | 2010      | 2011      | 2012      | 2013      | 2014      | 2015      | 2016      |
|--------------------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Нийт зардал                          | 103 168.3 | 155 400.0 | 211 497.1 | 206 429.3 | 250 264.7 | 333 702.5 | 424 387.9 | 415 823.8 | 584 164.7 | 581 851.5 | 657,500.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 33 437.3  | 63 300.0  | 92 982.4  | 92 743.8  | 100 363.8 | 121 680.3 | 176 880.1 | 166 808.4 | 193 195.5 | 207 980.8 | 211,600.0 |
| Эм                                   | 13 361.1  | 15 600.0  | 23 298.1  | 25 415.6  | 34 982.2  | 41 101.3  | 58 893.5  | 58 227.2  | 68 589.4  | 70 433.6  | 86,648.8  |
| Хоол                                 | 3 577.1   | 4 100.0   | 5 814.1   | 6 911.5   | 7 777.9   | 9 011.3   | 9 933.1   | 9 859.1   | 10 677.2  | 11 041.4  | 11,424.8  |
| Ашиглалтын зардал                    | 12 118.7  | 14 400.0  | 14 974.6  | 15 096.3  | 19 576.8  | 22 896.9  | 20 871.8  | 20 355.7  | 21 828.3  | 25 110.3  | 26,968.8  |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг*     | 4 056.2   |           | 9 230.1   | 9 674.1   | 10 209.8  | 13 125.7  | 16 557.3  | 84 776.0  | 104 056.9 | 110 959.1 | 106,330.8 |
| Хөрөнгийн зардал                     | 5 799.5   | 10 846.1  | 15 758.7  | 20 591.4  | 41 112.8  | 77 765.9  | 72 694.5  | 22 161.8  | 106 870.7 | 62 870.5  | 114,060.3 |
| Барилга                              | 2 054.3   | 6 603.5   | 7 378.8   | 12 156.9  | 24 299.8  | 53 023.2  | 40 440.3  | 9 558.4   | 67 160.1  | 32 740.2  | 62,789.5  |
| Их засвар                            | 886.9     | 1 756.5   | 4 593.2   | 5 434.9   | 7 631.0   | 9 060.3   | 11 457.2  | 7 426.6   | 16 589.5  | 3 003.3   | 9,569.3   |
| Авто машин, тоног төхөөрөмж          | 2 858.3   | 2 486.1   | 3 786.7   | 2 999.6   | 9 181.9   | 15 682.4  | 20 797.0  | 5 176.7   | 23 121.0  | 27 127.1  | 41,695.1  |
| Бусад зардал                         | 30 818.5  | 47 153.9  | 49 439.1  | 35 996.6  | 36 241.5  | 48 121.2  | 68 557.5  | 53 635.5  | 78 946.7  | 93 455.8  | 100,446.5 |

Тайлбар: \* Засгийн газрын дотоод шилжүүлэг нь 2000, 2001, 2002, 2007 онуудад бусад зардалд бүртгэгдсэн болно.

**Хүснэгт 3. Эрүүл мэндийн сайдын багцын зардлын бүтэц (сая төгрөг)**

| Эрүүл мэнд, спортын салбарын зардал                          | 2012             | 2013             | 2014             | 2015             | 2016             |
|--------------------------------------------------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|
| <b>Эрүүл мэндийн зардал</b>                                  | <b>351 569.6</b> | <b>393 662.0</b> | <b>456 415.3</b> | <b>501 823.2</b> | <b>543,417.8</b> |
| Эрүүл мэндийн удирдлага                                      | 36 767.2         | 27 034.2         | 32 618.0         | 43 150.3         | 50,535.6         |
| Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ                             | 297 421.5        | 355 565.6        | 403 125.5        | 438 897.0        | 486,401.8        |
| Өрхийн эрүүл мэндийн төв                                     | 16 697.2         | 84 776.0         | 94 655.2         | 101 279.3        | 106,330.8        |
| Сумын эрүүл мэндийн төв                                      | 55 853.6         |                  |                  |                  |                  |
| Тосгоны эрүүл мэндийн төв                                    | 904.4            |                  |                  |                  |                  |
| Сум дундын эмнэлэг                                           | 11 311.7         | 12 982.2         | 14 187.3         | 15 260.5         | 15,826.8         |
| Түргэн тусламжийн төв                                        | 4 687.2          | 5 494.7          | 5 766.4          | 6 151.3          | 6,663.4          |
| Орон нутаг дахь зоонозын өвчин судлалын төв                  | 2 378.1          | 2 818.3          | 2 982.6          | 3 156.7          | 3,238.6          |
| Орон нутаг дахь уламжлалт анагаах ухааны төв, рашаан сувилал | 1 276.9          | 1 471.7          | 1 741.8          | 1 838.6          | 1,885.7          |
| Амаржих газар                                                | 6 526.5          | 9 766.7          | 12 094.3         | 13 634.2         | 14,930.9         |
| Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг                                    | 55 335.0         | 66 142.4         | 7 969.7          | 9 126.4          | 9,780.8          |
| Аймгийн нэгдсэн эмнэлэг                                      |                  |                  | 70 825.3         | 78 901.8         | 83,752.4         |
| Дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг                  | 29 619.6         | 34 521.6         | 37 697.3         | 42 103.8         | 47,481.4         |
| НЭМГ-ын харъяа бусад эмнэлэг                                 | 4 196.6          | 4 920.8          | 5 268.3          | 5 989.9          | 5,847.5          |
| БОЭТ                                                         | 22 586.9         | 26 455.2         | 28 275.1         | 30 958.2         | 32,946.4         |
| Төв эмнэлэг                                                  | 30 372.3         | 34 129.5         | 38 571.0         | 44 828.8         | 58,651.6         |
| Тусгай мэргэжлийн төв                                        | 54 178.5         | 69 389.5         | 80 182.3         | 84 130.1         | 97,505.1         |
| Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн                | 1 274.4          | 1 363.9          | 1 504.6          | 1 510.0          | 1,560.4          |
| Бусад                                                        | 222.7            | 251.4            | 257.0            | 27.4             | -                |
| Төвлөрсөн арга хэмжээ                                        | 8 277.4          | 1 023.7          | 2 271.9          | -                | -                |
| ЗГ-ын тусгай сангууд                                         | 8 792.6          | 9 410.7          | 10 375.0         | 128.9            | -                |
| Төсөл, хөтөлбөрийн зардал                                    | 310.9            | 627.8            | 8 024.9          | 19 646.9         | 6,480.2          |
| <b>Спортын зардал</b>                                        | <b>123.8</b>     | <b>-</b>         | <b>20 878.7</b>  | <b>17 157.8</b>  | <b>-</b>         |
| <b>Хөрөнгийн зардал</b>                                      | <b>72 694.5</b>  | <b>22 161.8</b>  | <b>106 870.7</b> | <b>62 870.5</b>  | <b>114,060.3</b> |
| <b>Нийт зардал</b>                                           | <b>424 387.9</b> | <b>415 823.8</b> | <b>584 164.7</b> | <b>581 851.5</b> | <b>657,478.1</b> |

**Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал**

| ЭМД-ын сангийн орлого, зардлын үзүүлэлт                                                                                                                              | 2011                         |                               | 2012                         |                               | 2013                         |                               | 2014                         |                               | 2015                         |                               | 2016                         |                               |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|-------------------------------|------------------------------|-------------------------------|------------------------------|-------------------------------|------------------------------|-------------------------------|------------------------------|-------------------------------|------------------------------|-------------------------------|
|                                                                                                                                                                      | Хүний тоо<br>(мянган<br>хүн) | Мөнгөн<br>дүн (сая<br>төгрөг) | Хүний тоо<br>(мянган<br>хүн) | Мөнгөн<br>дүн (сая<br>төгрөг) | Хүний тоо<br>(мянган<br>хүн) | Мөнгөн<br>дүн (сая<br>төгрөг) | Хүний тоо<br>(мянган<br>хүн) | Мөнгөн<br>дүн (сая<br>төгрөг) | Хүний тоо<br>(мянган<br>хүн) | Мөнгөн<br>дүн (сая<br>төгрөг) | Хүний тоо<br>(мянган<br>хүн) | Мөнгөн<br>дүн (сая<br>төгрөг) |
| ЭМД-ын сангийн орлого                                                                                                                                                | 2 793.2                      | 121 576.4                     | 2 593.6                      | 166 500.8                     | 2 864.5                      | 203 954.2                     | 3 064.8                      | 231 800.2                     | 3 003.7                      | 248 130.7                     | 2,966.3                      | 302,676.9                     |
| Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл                                                                                                                | 1 439.3                      | 52 162.8                      | 1 123.8                      | 65 681.0                      | 1 206.3                      | 80 596.0                      | 1 241.3                      | 92 995.2                      | 1 204.8                      | 96 114.6                      | 1,374.4                      | 112,153.9                     |
| Ажиллагсдаас төлсөн шимтгэл                                                                                                                                          |                              |                               | 742.0                        | 61 639.5                      | 803.9                        | 75 943.9                      | 832.9                        | 87 980.2                      | 799.8                        | 91 111.7                      | -                            | -                             |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэнээс төлсөн шимтгэл                                                                    |                              |                               | 381.8                        | 4 041.5                       | 402.4                        | 4 652.1                       | 408.4                        | 5 015.1                       | 405.0                        | 5 003.0                       | -                            | -                             |
| Ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл                                                                                                                | 659.3                        | 53 421.3                      |                              | 78 375.0                      |                              | 92 417.1                      |                              | 102 420.0                     |                              | 106 726.7                     | -                            | 113,730.3                     |
| Төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл                                                                                                       | 1 353.9                      | 10 906.1                      | 1 469.8                      | 12 151.5                      | 1 658.3                      | 12 151.5                      | 1 823.5                      | 12 033.2                      | 1 798.9                      | 12 040.2                      | 1,591.9                      | 44,469.1                      |
| Акт төлбөрийн орлого                                                                                                                                                 |                              |                               |                              | 9 341.8                       |                              | 17 695.7                      |                              | 22 896.8                      |                              | 32 249.6                      | -                            | 31,800.0                      |
| Сангийн чөлөөт үлдэгдлийн банкинд хадгалуулсны хүү                                                                                                                   |                              | 4 833.8                       |                              | 669.6                         |                              | 590.3                         |                              | 883.9                         |                              | 643.7                         | -                            | -                             |
| Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хэтрүүлсэнд ногдуулсан алданги                                                                                        |                              | 115.9                         |                              | 215.4                         |                              | 308.2                         |                              | 468.3                         |                              | 279.8                         | -                            | 454.5                         |
| Бусад эх үүсвэр                                                                                                                                                      |                              | 136.5                         |                              | 66.4                          |                              | 195.4                         |                              | 102.6                         |                              | 76.1                          | -                            | 69.0                          |
| ЭМД-ын сангийн зардал, тусламж, үйлчилгээний ангиллаар                                                                                                               | 3 198.4                      | 89 949.3                      |                              | 114 898.9                     |                              | 125 636.0                     |                              | 182 919.3                     |                              | 203 070.5                     | 5,708.11                     | 246,778.3                     |
| Даатгуулагчид үзүүлэх ЭМД-ын тусламж, үйлчилгээний зардал, гүйцэтгэлээр                                                                                              | 3 196.7                      | 87 145.7                      |                              | 114 357.7                     |                              | 120 737.4                     |                              | 174 680.9                     |                              | 196 133.5                     | 5,708.1                      | 242,077.6                     |
| Даатгуулагчид үзүүлэх ЭМД-ын тусламж, үйлчилгээний зардал, олгохоор тооцсоноор                                                                                       |                              |                               | 4 126.4                      | 113 786.6                     | 3 843.2                      | 120 813.5                     | 4 452.1                      | 174 592.7                     | 5 042.6                      | 196 392.1                     | -                            | 242,077.6                     |
| Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ                                                                                                                                  | 351.8                        | 57 781.9                      | 362.3                        | 67 516.9                      | 374.1                        | 72 187.8                      | 419.1                        | 102 733.1                     | 427.0                        | 105 733.6                     | 462.6                        | 113,971.9                     |
| Амбулаторийн тусламж, үйлчилгээ                                                                                                                                      | 1 537.8                      | 14 319.1                      | 1 636.8                      | 17 286.4                      | 1 755.1                      | 19 091.2                      | 1 971.6                      | 30 434.3                      | 2 242.0                      | 34 849.2                      | 2,411.1                      | 37,854.8                      |
| Оношилгоо, шинжилгээ                                                                                                                                                 | 593.5                        | 6 031.9                       | 716.0                        | 8 947.6                       | 753.6                        | 10 369.9                      | 861.9                        | 15 808.8                      | 939.1                        | 20 371.3                      | 1,116.6                      | 25,940.1                      |
| Уламжлалт эмчилгээ                                                                                                                                                   | 20.6                         | 1 609.7                       | 20.6                         | 1 853.7                       | 22.0                         | 2 044.0                       | 20.6                         | 2 327.8                       | 26.0                         | 2 966.2                       | 28.1                         | 3,193.5                       |
| Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ                                                                                                                                        | 0.6                          | 32.3                          | 0.1                          | 11.5                          | 0.1                          | 10.8                          | 0.2                          | 61.1                          | 0.4                          | 123.9                         | 2.9                          | 870.8                         |
| Сэргээн засах тусламж, үйлчилгээ                                                                                                                                     |                              |                               | 55.8                         | 4 017.8                       | 58.7                         | 4 342.8                       | 67.7                         | 7 402.3                       | 71.4                         | 7 847.3                       | -                            | 9,035.4                       |
| Рашаан сувиллын үйлчилгээ                                                                                                                                            | 50.3                         | 2 388.4                       | 54.9                         | 3 955.3                       | 57.4                         | 4 244.9                       | 66.8                         | 7 298.1                       | 70.5                         | 7 748.1                       | 82.1                         | 9,035.4                       |
| Клиник сувиллын үйлчилгээ                                                                                                                                            |                              |                               | 0.9                          | 62.6                          | 1.3                          | 97.8                          | 0.9                          | 104.2                         | 0.9                          | 99.2                          | -                            | -                             |
| Өдрөөр эмчлэх тусламж үйлчилгээ                                                                                                                                      | 19.4                         | 1 994.1                       | 24.5                         | 2 931.3                       | 24.8                         | 3 033.2                       | 28.4                         | 3 444.4                       | 27.8                         | 3 383.6                       | 25.5                         | 3,106.4                       |
| Эмийн үнийн хөнгөлөлт                                                                                                                                                | 622.8                        | 2 988.3                       | 706.9                        | 4 886.4                       | 854.5                        | 9 727.4                       | 1 073.3                      | 11 634.6                      | 1 286.3                      | 16 450.8                      | 1,564.9                      | 26,291.0                      |
| Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             | 2.1                          | 3 036.4                       | 11.4                         | 15,562.0                      |
| Өрхийн эмнэлэг                                                                                                                                                       | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             |
| Эрүүл монгол хүүхэд                                                                                                                                                  | -                            | -                             | 603.3                        | 6 335.1                       | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             | -                            | -                             |
| Урамшуулал                                                                                                                                                           | -                            | -                             | -                            | -                             | 0.3                          | 6.4                           | 9.3                          | 746.4                         | 20.4                         | 1 629.7                       | -                            | -                             |
| ЭМД-ын байгууллагын үйл ажиллагааны зардал                                                                                                                           |                              | 2 766.9                       |                              | 398.2                         |                              | 3 693.7                       |                              | 5 491.0                       |                              | 4 114.0                       |                              | 3,913.9                       |
| Бусад зардал                                                                                                                                                         | 1.7                          | 36.7                          |                              | 143.0                         |                              | 1 204.9                       |                              | 2 747.4                       |                              | 2 823.0                       |                              | 786.7                         |
| ЭМД-ын сангийн зардал, салбараар*                                                                                                                                    | 3 198.4                      | 89 949.3                      |                              | 113 786.6                     |                              | 120 813.5                     |                              | 174 592.7                     |                              | 196 392.1                     |                              | 54,765.8                      |
| Улсын салбар                                                                                                                                                         |                              | 68 905.6                      |                              | 89 374.7                      |                              | 89 760.2                      |                              | 128 768.0                     |                              | 141 626.2                     |                              | 54,765.8                      |
| Хувийн салбар                                                                                                                                                        |                              | 18 276.9                      |                              | 24 411.9                      |                              | 31 053.4                      |                              | 45 824.8                      |                              | 54 765.8                      |                              | -                             |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн оны үлдэгдэл                                                                                                                  |                              | 31 627.1                      |                              | 51 601.9                      |                              | 78 318.2                      |                              | 48 880.9                      |                              | 45 060.2                      |                              | 55,898.6                      |
